



Нүдэндээ харагдтал мөрөөдвөл бодит болно...

Жорж Вашингтон

"Би гоо үзэсгэлэнт эмэгтэйтэй гэрлэх болно. Би Америкийн хамгийн баян хүн болно. Би цэрэг захирах болно. Би Америкт тусгаар тогтнолыг тогтоож ерөнхийлөгч нь болох болно."

Асуу Америкийн эцэг гээгддэг Жорж Вашингтон 12 настай байхаасаа эхлэн ийм зорилго тавьж бичин нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөддөг байжээ.

Брюс Ли

"1980 он гэхэд би АНУ-д хамгийн алдартай ази жүжигчин болсон байх болно. Би 10 сая \$ хөлс аван кинонд тоглох болно."

Брюс Лигийн өөрийн гараар бичсэн гар бичмэл Нью-Йорк 11 планет Холливудад хадгалагдаж байгаа гэнэ.

Битлз

"Жон бид 2 дандаа л нэг тэмдэглэлийн дэвтэр бариад зэрэгцээд суудаг байлаа. Бүчр ноорт гүйцсэн тэр дэвтрийг одоо хүртэл нандигнан хадгалдаг юм. Эхний хуудсан дээр нь "Леннон ба Маккартни оригинал" гэсэн гартис өгөөд л санаану орсон дүхнээ бигдээ байв. Зай завсаргүй дүүрэн юм бичсэн байсан. Бид дараагийн үеийн хамгийн шилдэг хамтлаг гэсэн мөрөөдлөөр дүүрэн дэвтэр байлаа. Тэгээд бид тэр мөрөөдлөө биелүүлж чадсан билээ."

Билл Тейтс

Билл Тейтс дэлхийн тэргүүн баян. Тэр компьютер чигдвэрлэн асар их хөрөнгө хураасан гэдгийг бусад мэднэ. Тэгвэл яаж түүний компьютерийн чигдвэрлэл дэлхийг байлдан дагуулж чадав аа? Энэ асуултанд Билл Тейтс өнгөрсөн жилүүдийн турш залхтал нь ингэж хариулж байгаа билээ.

"Би арван хэдтэй байхаасаа эхлээд дэлхийн айл бүр нэг нэг компьютертэй болсон байгаагаар төсөөлж заавал тийм болгох болно гэж өөртөө хэлдэг байсан. Тэр бол эхлэл байлаа."

ISBN 999298170-9



GaVaL.net

Нүгэндээ харагдтал мөрөөдвөл бодит болно...

Vivid Dream Realization R=VD

Дээврийн өрөөн дэх
МИЖИЙ МӨРӨӨДӨЛ

Ц.ЖиСонь



Улаанбаатар 2010

ГАРЧИГ

Өмнөх үг

5

Чиний цээжинд оргилон ирэх түүгээр амьдар

PART 01. Дээврийн хонгилын өрөөндөө мөрөөдөнө

1. Онассис ба Спилбергийн мөрөөдлөө биелүүлсэн арга 14
2. Мөрөөдөх чадварыг даган амьдрал өөрчлөгдөнө 20
3. Хичээл зүтгэлээс илүү чухал зүйл бол мөрөөдөх чадвар 25
4. Амжилтыг $R=VD$ шийдвэрлэдэг 30
5. Хүн нүдэндээ харагдтал төсөөлснөөрөө л болдог 37
6. $R=VD$ үр дүн түүний гэрчүүд 42
7. Бидний тархи ч мөрөөддөг 50

PART 02. Мөрөөдлийг биелүцлэхэд тусалдаг ид шидийн захиалга

1. Бодол эд хөрөнгийг дууддаг 58
2. Эрүүл мэндийг хамгаалагч ид шидийн захиалга 68
3. Сэтгэл санаа өөрөө эмч 76
4. Бодит бус үйл хөдлөл нь бодит бус үр дүнг л бүтээнэ 82
5. Мөрөөдсөн зүйлээ л авах болно 92
6. Гялалзсан ид шидийн хүч 100

PART 03. Нууцлаг ид шидийн захиалгыг цээжлэе

1. "Чрр" зураг аваарай 110
2. Яв! Хүсэл мөрөөдөл рүүгээ 118
3. Хэлж ярьж байгаа чинь бодит болно 126
4. Бич тэгээд унш 133

PART 04. Дээврийн өрөөний мөрөөдөл биелэх болно

1. Оюун санааны кино театр дотор төсөөлнө 144
2. Саятны коктеил үдэшлэг 152
3. Миний зөвлөгч Толстой 160

Номоо дуусгаж байгаа танд_Одоо таны ээлж. 168

ӨМНӨХ ҮГ

☞ Чиний цээжинд оргилон ирэх тцүгээр амьдар.

Найдвар мөрөөдөл эхлэх газар болох - Дээврийн хонгилын өрөө. Тэнд цагийн аясаар хуучирч муудсан модон тавилгууд, тайван унтаж болох ор, танил хуучин ширээ байна. Сандал дээр суунгаа цонхоор харвал жижигхээн цэцэрлэг харагдаж тэндээс салхины аясаар аятайхан анхилуун үнэр дайгдан ирж шингэсэн эгэл жирийн амар амгалангийн орон мэт санагдана. Хэн ч гэсэн нэг иймэрхүү газартай болох юмсан мөрөөддөг дээврийн хонгилын өрөө ийм байвал?

Хорвоо дээр амьдрахаа, “болих” гэдэг ганц үг байхад л дуусгаж болохоор аюултай ч ийм бодит байдалд ч бид найдвар алдахгүй байдаг шалтгаан нь биелүүлэхийг хүсдэг мөрөөдөлтэй, түүнийхээ төлөө чин сэтгэлээсээ тэмүүлж өөр өөрийнхөө дээврийн хонгилын өрөөнд сууж тасралтгүйгээр өөрийн хүсэл рүү тэмүүлж байдагт байгаа юм.

Бидний дахин босох ёстой шалтгаан, бидний дахин инээх ёстой шалтгаан ч бас адил. Бидэнд хараахан гүйцээж хийж амжаагүй зүйлс үлдээд тэдгээр нь бидний дотрыг арзагнуулан оргилон гарч ирнэ.

Нэг найз маань “Өөрийн хүссэн төрхийг бодит болгох чадвартай бай” гэж хэлдэгсэн. Мөрөөдлөө биелүүлэхийн тулд хамгийн түрүүнд хийх ёстой зүйл бол өөрийгөө ятган өөрчлөх юм. Тэгж байж л өөрийн хүссэн төрхийг яг жинхэнэ юм шиг төсөөлж, өөрийн хүссэн Би-г бий болгож эцэст нь өөрийн хүссэн амьдралаар амьдарч чадах болно.

Зарим нь өөрийн хүссэн би-г бий болгохын “туфлиэ тайлж чулууудаад өндрөөс өндөрт холоос хол нисээрэй” гэж хашгирна. Энд туфлиатай ч бай гуталтай ч бай түүнийгээ тайлахгүй байсан ч тэр бусдаас илүү үсэрч чадах арга бичигдсэн байгаа.

Илүү итгэлтэй, амархан өөрийн мөрөөдлийг биелүүлж чадах арга юм шүү.

☞ Та мөрөөдлөө бодит болгоорой.

“Нүдэндээ харагдтал төсөөлж түүнийгээ цаасан дээр буулгавал бодит болох болно.”

Эрт цэвс ингэж яригддаг байлаа.

1837 онд болсон явдал юм. Суут сэтгэгч агуу төсөөлөгч алдарт зохиолч Эдгар По бодит байдал зөгнөлийн алийг нь ч ялгахад хэцүү үзэгдэлд автаж “А.Гордон Бимийн яриа” гэдэг туужийг бичсэн байна. Эхнээсээ төгсгөл хүртлээ аймшгийн үйл явдлуудаар дүүрэн энэ туужийн гол агуулга нь гол баатараа оролцуулан 4 далайчин далайгаар аялж байхдаа осолд орж төөрөөд өлсөхийн эрхэнд хожигдсоныгоо идэхээр мөрийцөж хожигдсон нэгнийгээ алаад махыг нь идсэн тухай байсан юм. Уг туужид гардаг золиосны усан цэргийн нэрийг Ричард Паркер гэдэг байлаа.

1884 он. Английн шүүх англичуудыг айлгаж цохилтонд оруулсан аллага үйлдсэн 3 эрд шийтгэл оноосон юм. Тэд сууж явсан усан онгоц нь сүйрэн далайд төөрөх үедээ өлсгөлөнгөө барьж дийлэлгүй нэгнийгээ мөрийцсний эцэст алж идсэн хэргийн төлөө шийтгүүлсэн байлаа. Золиослогдсон хүний нэрийг гайхалтай нь Ричард Паркер гэдэг байв.

Э.По ирээдүйн нэгэн үйл явдалыг өөрийн нүдээр харсан мэт төсөөлөн түүнийгээ цаасан дээр буулгасан юм. Харин тэр нь 47 жилийн дараа жинхэнэ амьдрал дээр бодитоор тохиолдсон байлаа.

Ихэнх зохиол бүтээлүүд зохиогчийн сэтгэл дотор зохиомлоор төрж зохиомлоор дүрслэгддэг. Гэхдээ тийм биш бүтээлүүд ч байдаг л даа. “А.Гордон Бимийн яриа” нь тиймэрхүү төрлийн зохиолуудын тод жишээ юм.

Жүжгийн зохиолч А.Луй 1885 онд осолд орсон Каролин хөөлгийн цорын ганц амьд үлдсэн хүн болох Роберт Гордоны

рианд үндэслэн “Каролин усан онгоц” хэмээх зохиол бичиж. Хэсэг хугацааны дараа Каролин гэдэг нэртэй усан онгоц үнэхээр осолдсон байна. Ганцхан хүн амьд үлдсэн бөгөөд түүнийг Роберт Гордон гэдэг байжээ. Зохиолч Морган Робертсон 1898 онд “Титан хөлгийн живэлт” хэмээх туужаа хэвлүүлсэн байна. Хүн төрөлхтөний хамгийн сүүлийн үеийн техник технологиор бүтээгдсэн асар том Титан усан онгоц мөсөн уултай мөргөлдөж живсэн тухай бичигдсэн байв. Харин түүнээс хойш 14 жилийн дараа буюу 1912 онд тухайн үеийнхээ хамгийн шилдэг технологийг бүхнийг ашиглан бүтээгдсэн Титаник нэртэй усан онгоц Атлантын далайн хойд хэсэгт мөсөн уултай мөргөлдөж живжээ. Энэ үйл явдлаар Леонардо Де Каприогийн гол дүрд нь тоглосон “Титаник” гэдэг кино ч хийгдсэн. Гэхдээ хамгийн сонирхолтой нь зохиолд гарч байгаа усан онгоц болон бодит усан онгоц хоёрын живсэн сар, зорчигч ба багийнханы тоо, лавины тоо, нийт урт ба эзэлхүүний хэмжээ, мөсөн уултай мөргөлдөх үеийн хурд зэрэг нь яг адилхан байсан байна.

Германы зохиолч Рейнхард Франк 1927 онд “Дуучид” гэдэг зохиол бичиж түүндээ “Ханна” хэмээх нэртэй эмэгтэйн дүрийг бүтээжээ. Ханна нь түүний хүүхэд байхаасаа л мөрөөдөж ирсэн эмэгтэйн загвар байлаа. Мэдээжээр тэр Ханнагийн гадаад төрх, зан чанарыг амьд хүн мэт дүрсэлж чадахаар байв. Түүнээс хойш 21 жилийн дараа 1948 онд өөрөөсөө 28 дүү эмэгтэйтэй гэрлэсэн байна. Тэр эмэгтэйтг Ханна гэдэг ба яг тэр зохиолд гардаг эмэгтэй шиг царай зүс, зан ааштай байсан гэнэ.

Том Клэнсигийн “Яаралтай тушаал” хэмээх туужид Колумбийн хар тамхины хаан нууц байранд хоргодож байхдаа гэрийнхэнтэйгээ гар утсаар ярьсан яриагаар байршил нь илрэн баригдаж Колумбийн цагдаагийнханд буудуулдаг үйл явдал гардаг. Гайхалтай нь уг зохиолын амьд модель болох Колумбийн хар тамхины хаан Пабло Эскобар яг тэр туужид гарсан шиг алуулсан юм.

Эдгээр зохиолуудад 2 янзын нийтлэг зүйлүүд байна.

1-рт, Зохиолч санаатай ба санаандгүйгээр бодит байдал ба төсөөллийн ертөнцийг ялгаж чадахгүйгээр ирээдүйн ямар нэгэн үйл явдлыг нүдэндээ харагдтал төсөөлсний

эцэст цаасан дээр буулгасан байдал. Тэр нь жинхэнэ амьдрал дээр ч яг тийм байдлаар биелсэн байна.

2-рт, Зориудаар эсвэл зориуд бусаар эрт дээр үеэс цөөхөн хэдэн хүмүүсээр нууц байдалтай дамжин ирсэн юуг ч гэсэн тэр нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөдөж дараа нь тэмдэглэвэл тэр нь биелнэ гэсэн нууцыг зохиогч нь үнэнчээр дагасан гэдэг зүйл.

Хэрвээ, хэрвээ байна шүү дээ. Та ч гэсэн тийм зүйл заалгаад үнэнчээр дагах юм бол танд бас ийм зүйл тохиолдох болов уу? Таны чин сэтгэлээсээ мөрөөдөж байсан тэр бүхэн жинхэнээсээ биелэх болов уу?

☞ Ид шидийн захиалга, $R=VD$

Оршилоо арай л хачин этгээд маягаар чимэглэчих шиг боллоо. Хүлцэл өчиж байна. Гэхдээ бас ойлгоосой гэж хүсэж байна. Эхний хуудсандаа уншигчийн сонирхлыг татахаар арай л онцгой юм бичих хэрэгтэй гэсэн зохиол бүтээл бичих дүрэм гэдэг юмуу даа нэг тийм дүрмийг дагаад бичсэн юм шүү.

Хэрвээ би гарамгай сод зохиолч байсан бол “Артур Гордон Бимийн яриа” шиг жихүүдэс хүрмээр жишээний оронд арай хөнгөн цовоолог яриагаар эхлэх байсан байх. Гэхдээ дөнгөж эхэлж байгаа зохиолч болохоор тэгж чадсангүй. Ямартай ч гэсэн оршлын эхэнд байгаа яриагаар хүсч байсан үр дүнд хүрсэн гэж найдаад гол яриандаа орёё.

Энэ ном амжилтын ур чадварын тухай ном юм. Нүдэнд харагдах талаас нь үзвэл хүн төрөлхтөн хэзээд хоёр хэсэгт хуваагдаж байсан. Юмтай хүн ба юмгүй хүн, тэнцэгч ба унагч, эрүүл хүн ба өвчтөн гэх мэт. Мэдээж ялагч ба ялагдагч гэж хуваагдана. Тэгвэл ялагч ялагдагч гэж ялгаад байгаа тэр шийдвэрлэгч шалтгаан нь юу вэ?

Бид ерөнхийдөө тэр шалтгааныг хичээл зүтгэл гэж мэддэг. Мэдээж энэ харьцангуй чухал шалтгаан гэдэг нь ойлгомжтой асуудал. Гэхдээ л зөвхөн хичээл зүтгэл гол шийдвэрлэх шалтгаан гэж үү? Тийм биш гэдгийг та сайн мэдэж байгаа.

Насан туршдаа нуруугаа бөгтийтөл ажиллаад ядаж өөрийн гэсэн орон гэртэй болж чадаагүй хүмүүс олон байхад, амарч дугаалангаа асар их хөрөнгө эзэмшиж, алдар нэрийн оргилд хүрэн амьдарч байгаа хүмүүс байгаад л байна.

Хичээл зүтгэлийг амжилтын гол нууц гэж үзэх нь онолын хувьд ч итгэхэд хэцүү ойлголт. Насаар таньтай чацуу мөртлөө таниас арав хорь дахин илүү амжилт олон амьдарч байгаа хүмүүс байна. Хэрвээ хичээл зүтгэлийг амжилтын гол нууц гэж үзэх юм бол тэд таниас арав хорь дахин илүү хичээн ажилласан байх гээд байгаа биз. Та өдөрт 2 цаг ажилладаг бол тэд 20 бүр 40 цаг ажилласан болох гээд байна. Үнэхээр тийм гэж үү? Утасны аппаратыг зохион бүтээсэн Александр Грэхэм Беллийн сонирхлыг энэ асуудал татсан бололтой. Белл Германы алдартай физикч Райсийн бүтээсэн утсыг харж удаан хугацааны турш бодсон юм. Райсийн бүтээл нь Беллийнхээс 15 жилийн өмнө бүтээгдсэн учир Райсийнхтай бүх талаараа адилхан байсан. Гэхдээ яагаад ч юм салхины чимээ л дамжуулахаас хүний яриаг дамжуулж чадахгүй байлаа. Товчоор хэлбэл Белл Райс 2 адилхан хичээл зүтгэл гаргасан ч эсрэг тэсрэг үр дүн гарсан юм. Белл амжилт олж Райс ялагдсан.

Эцсийн эцэст Белл Райсийн ялагдлын шалтгааныг олж чадсан. Райсийн аппаратын электродын нэг эргийг 1000-ны 1 хувиар буцааж эргүүлээд болох нь тэр. Белл эргийг яг тааруулан тохируулж чадсан. Тэгмэгц л хүний дуу хоолой тод тунгалаг дамжуулагдаж байлаа (3). Тэгэхэд Белл өөртөө маш том асуулт тавьсан байна. Төсөөлөн бодох үедээ 1000-ны нэг хувийн алдаа гаргаж байгаа нь алдарт физикч Райс биш тусгай дунд сургуулийн багш тэр өөрөө байх ёстой байсан учраас юм. Белл “Яагаад Райс бүтэлгүйтэж би амжилтанд хүрч чадав аа?” гэдэг асуултанд хариулт олохын тулд тэр хоёрыг зааглаж байгаа гол шийдвэрлэгч ялгааг олохоор хайж эхэлсэн юм. Эцэст нь тэр хариултаа олсон. Тэр нь санамсаргүй сэтгэлгээний хүч байлаа (4). Беллээс ялгаатай нь Райс санамсаргүй сэтгэлгээний хүчинд итгэдэг ч үгүй хэрэглэдэг ч үгүй байсан юм.

ХХ зууны хамгийн их амжилтанд хүрсэн эмэгтэйчүүдийн нэг боллох Эсти Лаудер (*тэрээр одоо ч хамгийн их амжилт олсон эмэгтэйчүүдийн нэг хэвээрээ байгаа*). Беллийн санамсаргүй сэтгэлгээний хүч гэж нэрлэж байгаа хүчийг нүдэндээ харагдтал төсөөлөхийн хүч гэдэг үгээр томъёолсон байдаг.

Залуудаа тэрээр нэг удаа баячуудын хороолол дахь үсчинд ороод нэг баян авгайд нүд үзүүрлэгдэн загнуулсан байна. “Хөөх энэ цамцыг хараач, Ямар тансаг гоёмсог юм бэ, Та үүнийг хаанаас авсан бэ?” гэж асуутал “Чи тэрийг мэдэж яах гээв? Чам шиг ядуучууд насандаа гар ч хүрч чадахгүй юм чинь” гэсэн хариу сонссон байна.

Эсти Лаудер хариу ч хэлж чадалгүй үсчингээс гүйн гарсан гэдэг. Тэгээд гэрлүүгээ гүйх замын турш өөртөө бардмаар “Дахиад хэзээ ч хэн ч намайг ядуу гэж хэлэхээргүй тийм хүн болох болно. Хүссэн бүгдээ авч чаддаг хүн болох болно” гэж дахин дахин тангарагласан гэдэг.

Гэхдээ амжилтанд хүрнэ гэж тангараглалаа гээд бодит байдалд амжилтанд хүрнэ гэсэн үг биш ээ. Бас зүгээр л идэвх зүтгэлтэй ажлаа хийлээ гээд амжилтанд хүрнэ гэсэн үг биш юм. Амжилтанд хүрэхийн тулд онцгой дотоод хүчин хэрэгтэй. Зүгээр байж байсан ч гэсэн амжилт өөрөө татагдан ирдэг энерги хэрэгтэй. Хүмүүс үүнийг аз гэж хэлдэг. Эсти Лаудер ч гэсэн энэ тухай сайн мэддэг байлаа.

Тэгээд тэрээр амжилтанд хүрсэн хүмүүсийг тууштай нямбай судалж эцэст нь амжилтыг татдаг тэр дотоод хүчийг олох аргыг ойлгож авсан байна. Эцсийн үр дүн нь таны мэдэж байгаа тэр л зүйл юм. Баян авгайд доромжлуулсан хараалаас 4 тэрбузмын хөрөнгөтэй (20 зууны түвшин) дэлхийн хэмжээний гоо сайхны Эсти Лаудер компанийн эзэн болсон явдал юм. Тэрээр өөрийн намтартаа амжилтыг дуудан авчирдаг энергийн тухай ингэж бичсэн байдаг.


“Та мөрөөдлөө нүдэндээ харагдтал төсөөлөх ёстой. Хэрвээ та сэтгэлийнхээ нүдээр аль эрт амжилттай ажиллаж байгаа компани, хийгдсэн наймаа арилжаа, олсон ашиг зэргийг харж чаддаг бол бодит амьдралд

тийм зүйл болох боломж нь өндөр байна гэсэн үг. Сэтгэлийнхээ гүнд аль эрт амжилт олсон байдал төрхөө нүдэндээ харагдтал зурах зуршил нь зорилгод хүргэх хамгийн хүчирхэг арга юм. Би их дэлгүцрт орохын өмнөөс эхлээд Эсти Лаудерын бүтээгдэхүүнцүд том том их дэлгүцрүцүдэд асар ихээр зарагдаж байгаа байдлыг нүдэндээ харагдталаа төсөөлдөг байлаа. Нэг хоёр удаа биш шүцү. Их дэлгүцрийг зүглэх бүртээ хэдэн мянган удаа тэгдэг байсан. Тэгэхэд миний сэтгэл дэх зураг жинхэнэ амьдрал дээр биелдэг байсан юм. Амжилтыг нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол тэр нь заавал бодит болох болно.

Энэ гайхалтай дүрмийг асар их амжилтанд хүрсэн хүн бүхэн мэддэг, хэрэгжүүлдэг. Бизнес эрхлэгч, үл хөдлөх хөрөнгийн наймаачин эсвэл тамирчид зэрэг амжилтын оргилд гарсан хүмүүс ихэнх нь энэ аргыг хэрэгжүүлдэг юм.” (5)

Александр Грэхэм Белл “санамсаргүй сэтгэлгээний хүч” гэж нэрлэж, Эсти Лаудер “Нүдэндээ харагдтал төсөөлөхийн хүч” хэмээн нэрлэж байгаа энэ хүчийг энэ номонд $R=VD$ томъёо хэмээн албан ёсоор нэрлэх болно. Үүнийг ингэж тайлбарлаж болно.

***Нүдэндээ харагдтал VIVID мөрөөдвөл DREAM биелнэ
REALIZATION.***



ТЭМДЭГЛЭЛЭ

ГЭМЭДЭГЛЭЛЭ

МОНГОЛ

1999

Vivid



Part

01

Дээврийн хонгилын өрөөндө— мөрөөдөнө.

Жирийн хэмцэе гэхтэлээ хилээнегцлэн ажиллахыг амжилтын хамгийн гол хүчин зүйл гэж үздэг. Харин амжилтанд хүрсэн хэмцэе өөрийгөө аль эрт амжилт олсноор төсөөлөх чадвартай байхыг хамгийн гол хүчин зүйл гэж үздэг. Энэ хоёрын хэний нэг зөв бол? Мэдээжийн хэрэг амжилтын эздийн зөв. Зочид дуудлын хаан гээгддэг Конрад Хилтон амьд гэрцүн байхдаа “Зочид дуудлын хаан гээгдэх би болон энгийн нэг дуудлын цйлчлөөг хоёрын ялгаа амжилтыг төсөөлөх чадвар гэдэг ганц л зүйлд байдаг.” хэмээн амны уншлага болгон ярьж явдаг байжээ.

Realization

1. ОНАССИС БА СПИЛБЕРГИЙН МӨРӨӨДЛӨӨ БИЕЛҮҮЛСЭН АРГА

☛ Онассис ба $R=VD$

1986 он Пусан боомтод нэгэн гадаад эр усан онгоцноос буулаа. Хэдэн өдрийн дараа тэр Сөүлийн Карибон хороонд (дайны цед хятадад дүрвэж байгаад эргэн ирсэн солонгосууд болон хятадууд зэрэг гадаадын иргэд олноор амьдардаг Сөүлийн нэгэн дүцрэг) хагас подвалын өрөө хөлслөн авлаа. Намхан, царай муутай, мөнгөгүй солонгос хэл ч мэдэхгүй энэ залуу ихэнх цагийг ажилгүй эсвэл хар ажил хийж өнгөрөөдөг байлаа.

Түүнээс хойш 20 жилийн дараа 2007 онд нөгөө гадаадын иргэн чинь Солонгосын хамгийн алдартай дуучин эмэгтэйгээс салах гэж байгаа тухай бүх сонингуудад бичнэ. Гэтэл хэдхэн сарын дараа өөрөөсөө 20 насаар дүү томоохон корпорацийн боссын охинтой суухаар болно. Иймэрхүү түүх байж болох уу?

Магадгүй хүмүүсийн 99% нь дуустал нь ч сонсохгүйгээр боломжгүй гэж хэлэх байх. Гэхдээ үнэн амьдрал дээр ийм амьдралаар амьдарсан хүн байсан юм. XX зууны дэлхий дээр шүү! Түүний нэр Аристотель Сократос Онассис.

1923 оны 9-р сар, Онассис нь Франц, Парисын дараа гял цалаараа бахархдаг хот Буэнос-Айрес хотод хөл тавив. Түүнд ядуусын хороололд байр хөлслөх барьцаа, хамгийн доод зэргийн амьдралаар 4 сар орчим амьдрах мөнгө л байлаа. Царай муутай, намхан, боловсролгүй аргентин хэл ч мэдэхгүй учир мэдээжээр гуйлагчингийн амьдралаар амьдрахаас өөр аргагүй байв.

Харин яг 4 жилийн дараа түүний хадгаламж 1 тэрбумын хөрөнгөтэй болсон байв. Гэхдээ энэ нь дөнгөж эхлэл байлаа. Түүний хөрөнгө аажмаар нэмэгдсээр 10 жилийн дараа гэхэд 10 дахин өссөн байлаа. Яаж ийм зүйл болж чадав аа?

Онассис ном унших дуртай хүн байлаа. Тэрээр ялангуяа амжилтын эздийн яриаг бичсэн ном унших дуртай байсан учир R-VD-г аяндаа л мэдэх болсон байна. Амжилтын тухай ном зохиолууд дунд энэ аргын тухай яриа гарахад уншигчдын 99% нь зүгээр л тоохгүй өнгөрөөдөг. Мэдээж хариулт өгөх хүмүүс байна л даа. Гэхдээ тэр нь агшин зуурынх л байх байх. Өөрөөр хэлбэл энэ томъёоны төлөө өөрийн бүх зүйлээр дэнчин тавих хүн гарахгүй.

Харин Онассис энэ аргыг олж мэдсэн тэр мөчид өвдгөө алгадсан юм. “Энэ үгээгүй ядуу амьдралаас намайг энэ л аврах болно.” гэж итгэсэн. Тэгээд амьдралаараа дэнчин тавьсан байна.

Бямба гариг бүр хамгийн дээд зэргийн хувцас өмсөж Апгужон хороо (Сөцлийн баячууд амьдардаг дүцрэг) чиглэн ивдэг нэгэн залуу байлаа. Тэр Апгужоны хамгийн мөнгөтэйчүүд цугладаг дээд зэргийн ресторанд очно. Гэхдээ энэ залуугийн үйлдэл нь онцгой. Хоолонд нэг их сонирхол үгүй. Хоёр нүдээ том болгон ирж байгаа зочдыг нэгд нэггүй харж байснаа нүдээ ахин бясалгал хийнэ. Үүнийгээ л тасралтгүй давтана. Хоол идэхээр ирж байгаа хүн биш ямар нэгэн шашны ёслол үйлдэхээр ирсэн хүн аятай. Гайхалтай нь энэ залуугийн бясалгалаа үйлдэхээр ирэхдээ төлж байгаа мөнгө нь түүний бүтэн 7 хоногийн хар ажлын хөлс байгаа гэдэгт байгаа юм. Та энэ залууг юу гэж бодож байна?

Онассис яг л ийм залуу байв. Онассис бямба гариг бүр Буэнос-Айросын дээдсүүд баячууд очдог 1-р зэрэглэлийн рестораныг чиглэнэ. Тэгээд ширээний ард суугаад зочдыг анхааралтай ажигладаг байлаа. Тэгээд тэдэн шиг баян болсон байдлаар өөрийгөө нүдэнд харагдтал төсөөлдөг байжээ.

Тэгтэл нэг өдөр Коста Кречо гэдэг хүн түүнд ойртон ирж яриа өдлөө. Онассис сонирхлыг нь татсан байж. Коста Кречо нь “Дракурис” хэмээх усан онгоц үйлдвэрлэдэг компанийн эзэн баян грек хүн байлаа. Тэр мөч Онассисийн хувь тавиланг орвонгоор нь эргүүлсэн мөч байсан юм.

Одоо сэдвийг Онассисийн хайр сэтгэлийн тухай яриа руу эргүүлэе.

Онассис 37 нас хүртлээ гэрлээгүй юм. Гэрлэмээр эмэгтэй байгаагүй учраас тэр. Гэтэл нэгэн өдөр Онассис санаандгүй нэгэн бүсгүйг хараад зүрх нь амаараа гарах шахан догдолсон байна. “Зүүдэндээ төсөөлж байсан эмэгтэй” тэр чигээрээ байлаа.

Гачлантай нь бүсгүй дөнгөж 16 хан настай байсан юм. Онассис тэгэнгүүт бизнес хийж мөнгө хураахад хэрэглэж байсан $R=VD$ -г хурим хийхийн төлөө хэрэглэж эхэлсэн байна. Бүр 3 жилийн турш шүү.

Хайрын хүч үү, эсвэл энэ томъёоны хүч үү? Онассис 40 настайдаа тэр бүсгүйтэйгээ гэрлэсэн юм. Энэ хүртэл Онассис томъёог эерэг зүйлд ашигласан жишээ гарч байна.

Түүнээс хойш тэр энэ томъёог сөргөөр ашиглаж эхэлсэн юм. Тухайн үеийн алдартай дуурийн дуучин Мария Калласыг хайрлах болж, дахиад л нөгөө томъёог ашиглан түүнийг хайрынхаа боол болгож орхисон юм. Тэрээр эхнэрээсээ нууцаар Мария Калластай хайр сэтгэлийн холбоотой 9 жил болсон ч эцэст нь эхнэрээсээ салж төгссөн. Дараа нь ерөнхийлөгч Кеннеди агсны бэлэвсэн эхнэр Жаклин Кеннедийг харсан цагаасаа эхлэн дахиад л хайрлах болж, мөн аргаа ашиглав. Жаклин Кеннеди илбэдүүлсэн юм шиг л Онассис руу очиж түүний 2 дахь эхнэр нь болсон юм. Энэ үед Онассис 62 настай байлаа.

☞ Спилберг ба $R=VD$

Стивен Спилберг 12 настайгаасаа эхлэн энэ аргыг ашиглаж хэрэгжүүлсэн хүн юм.

Спилбергтэй бага сургуульд хамт сурч байсан Жим Соллинберг нэгэн ярилцлагадаа ингэж хэлсэн байдаг.

“Стивен Спилберг 12 настайгаасаа эхлэн Академийн шагнал авч олны өмнө талархлын цг хэлж байгаагаар чин сэтгэлээсээ төсөөлдөг байсан. Тэр үнэхээр нүдэнд харагдтал төсөөлөн зураглан ярьдаг байсан болохоор бид Стивийн мөрөөдлийг маш сайн мэддэг байсан юм.”

1982 онд нэгэн ярилцлаганд тэрээр “Би 12 настайгаасаа л кино найруулагч болохоор шийдсэн байсан. Зүгээр нэг мөрөөдөх биш. Би тов тодорхой мөрөөддөг байсан. Тэгээд ч хүссэнээрээ кино найруулагч болж чадсан.”

Гэхдээ Спилбергийн мөрөөдөл нь тийм хурдан биелж чадаагүй. R=VD аргыг ашиглаж байсан ч 9 жилийн турш тэрээр кино найруулах бүү хэл зураг авалтын газрын ойр ч очиж чадахгүй байлаа. Киноныхон дунд түүний нэрийг мэдэх хүн байсангүй. Тэрээр кинонд ямар ч талаар хамааралгүй нэгэн байсан юм. Магадгүй Спилберг жирийн нэгэн хүн байсан бол төгсгээд л болих байсан байх. “Нүдэндээ харагдтал мөрөөдвөл биелнэ гэнэ ээ? Битгий инээд хүргээд бай” гэж хэлээд л. Харин Спилберг бол тэс өөр хүн. Тэрээр бүр илүү бодитойгоор мөрөөдөх замыг сонгосон байлаа.

Спилберг яг кино найруулагч шиг хувцаслан Universal студид нэвтрэн орсон байна. Түүний байр байдал үнэхээр бат итгэлтэй байсан учир хамгаалагч нар огт анзаараагүй гэдэг. Тэгээд хоосон өрөө хайж олсны эцэст “Стивен Спилберг кино найруулагч” гэсэн хаяг хадлаа. Мөн холбооны өрөө рүү очин утасны аппарат болон дугаар авсан байна. Тэрээр үнэхээр өөртөө итгэлтэй байсан учраас түүнд хэн ч эргэлзээгүй аж (7).

Спилберг тэр өрөөнд 2 жил илүүтэй байрласан юм. Тэрээр 2 жилийн турш R=VD аргыг үнэхээр бараг төгс болтол нь хэрэгжүүлж чадсан. Дэлхийд нэртэй найруулагч нарын ажиллаж байгааг яг дэргэдээс нь харж төсөөлнө гэдэг өөрийнх нь ганцаараа төсөөлж байснаас үндсээрээ өөр байлаа. Тэр бол мөрөөдөл юмуу эсвэл бодит байдал юмуу ялгагдахааргүй тийм бодиттой бөгөөд жинхэнэ дүрс бичлэг байсан байна.

Спилбергийн мөрөөдөл биелсэн үү? Хариулт нь “Тийм”.

Нэг өдөр Спилберг нэрнээс цаашгүй ажлын өрөөнөөсөө гарч далайн эрэг рүү салхинд гарахаар явжээ. Тэнд санаандгүй нэг эрэгтэйтэй хэдэн үг сольсон нь Спилбергийг тоохооргүй нэгэн байв. Гэсэн ч хоорондоо яриа нийлж байсан учир эртний найзууд шиг л өөрийнхөө байр байдал, сэтгэл зовоож байгаа бүхнээ уудлан ярилцсан байна.

Тэгтэл санаандгүй “Таны халуун сэтгэл сонирхлыг минь татлаа. Би киноны зураг авалтанд хэрэгтэй мөнгийг өгье. Ханатлаа кино зураг ав даа.” гэвэл яахав. Дараа нь л түүнийг Америкийн хуруу дарам цөөхөн хэдэн баячуудын нэг гэдгийг мэдсэн байна. Спилберг түүний саналыг хүлээн авлаа. Ингэж “Зугаалга” хэмээх кино төрж, энэ кино Венийн Олон Улсын киноны их наадмаас шагнал авсан юм (8).

Анхаараарай. $R=VD$ -г хэрэгжүүлбэл амжилтын боломж таны хувь тавилан мэт өөрөө олоод ирэх болно.

☞ Усан дээр ХӨВӨХ ТОС МЭТ

1955 онд болсон явдал юм. XXI зууны Билл Гейтсээс дутахааргүй их хөрөнгөтэй Аристотел Сократос Онассис Монако хотод болсон Олон Улсын Автомашины уралдаанд 2-р байр эзэлсэн Мерседес бенц машины багийнхныг усан онгоцон дээрээ болсон баярын үдэшлэгт урьсан байна. Мерседесийнхний фен гэргийгээ баярлуулахын тулд тэр шүү дээ. Үдэшлэг ид дундаа явж байх үед Липера нэрт тамирчин Онассисаас ингэж асуужээ.

- “Явал тань шиг дэлхийн тэргүүн баян болох бол?”

Тэрээр намуухнаар хариуллаа.

- “Усан дээр хөвж байгаа тос мэт дэлхийн хүмүүсийн бодлын дээр байнга тогтож байх ёстой.” (9).

Хүмүүс Онассис Спилберг мэтийн хүмүүс шиг болохыг хүсэж байна гэх боловч тэдэн шиг бодлынхоо фокусыг мөрөөдлийн дүрс бичлэг хийх гэдэг цэг дээр тааруулдаггүй. Харин Онассис, Спилберг шиг хүмүүс бол өөрийн амьдралаараа дэнчин тавьж мөрөөдлийнхөө дүрс бичлэг хийхэд бодлынхоо фокусыг тааруулж чаддаг. Түүний үр дүн нь бидний мэдэх Онассис ба Спилберг шиг болох боломжийг олгосон байна.

Юу ч үгүй хов хоосон бодлоос өөр юмгүй дэлхийн хүмүүсийн сэтгэлгээний хэв маягийг битгий дагаарай. Усан дээр хөвөх тос мэт дээд зэрэглэлийн сэтгэлгээний хэв маягийг эзэмшээрэй. *Жирийн хүмүүсийн хэрэгжүцлэдэггүй $R=VD$*

толгёог хэргэгжцүлээрэй. Тэгвэл та хүсэл мөрөөдлөө биелцүлж чадна.

Тэр оройн тансаг үдэшлэгийн уур амьсгалд мансууран баруун с олгойгүй цацан мөнгө үрж байсан Онассисийн хариулт түүнд оролцож байгаа Мерседесс багийнхныг бишрүүлсэн гэдэг.



2. МӨРӨӨДӨХ ЧАДВАРЫГ ДАГАН АМЬДРАЛ ӨӨРЧЛӨГДӨНӨ

☞ Пикассо ба Ван Гог

Пикассо ба Ван Гог энэ хоёр зураач авъяас чадварын хувьд адилхан зураачид байжээ. Харин амьдрал нь та бүхний мэдэж байгаагаар өдөр шөнө хоёр шиг өөр байсан юм. Пикассо нь амжилтын үлгэр загвар гэмээр амьдралаар амьдарч, харин Ван Гог эсрэгээр нь бүтэлгүйтлийн үлгэр загвар гэмээр амьдралаар амьдарсан байлаа.

Пикассо 30 дөнгөж гарч байхдаа саятан болсон байв. Түүний амжилт нас ахих тусам улам л цэцэглэж байсан бөгөөд 10 саятан, цаашлаад бүр тэрбумтан болсон юм. Зураачийн хувьд нэр алдар нь ч бас тийм байлаа. Анхандаа урлагийн ертөнцөд бага багаар танигдаж эхлэн удалгүй бүр од болж дэлхийн хэмжээний зураач болж чадсан.

Ван Гог насан туршдаа мөнгөтэй байх тавилангүй хүн байлаа. Тэрээр 20 настайдаа үгээгүй ядуу, 30тайдаа ч ядуугаас ядуу, үхэхдээ ч ядуугийн туйл байсан байна. Зураачийн хувьд нэр алдар нь ялгаагүй л доод зэргийн байжээ. Түүний зургууд ямар нэг хараалд автсан мэт хүмүүсийн анхаарлыг татаж чаддаггүй байв. Тэрээр ямар ч нэргүй амьдарч нэргүйгээр үхсэн юм.

Гэтэл өнөөдөр харахад Ван Гог Пикассогоос ч илүү чадварлаг зураач байсан. Учир нь Пикассо зураач аавын уйгагүй нөлөөн дор 4 настайгаасаа эхлэн зураг зурж байсан бол, Ван Гог 27 нас хүрч байж зураг зурж эхэлсэн байна. Бас Ван Гогт багш ч байгаагүй удирдан чиглүүлэх хүн ч байгаагүй. Энэ агуу Ван Гог тэгвэл яагаад Пикассогоос доор амьдралаар амьдрах болов? Пикассо эерэгээр $R=VD$ -г ашиглаж, Ван Гог сөргөөр $R=VD$ хийж байсан учраас тэр юм.

Пикассог Ван Гог шиг хэн ч мэддэггүй явсан үе байсан. Ямар ч нэр алдаргүй үе нь 10 жил үргэлжилсэн юм. Түүний зургууд зарагдахгүй, хэнд ч хүлээн зөвшөөрөгдөөгүй зураач

байлаа. Ван Гогийн нэгэн адил ядуусын хороололд амьдарна. Түүний нэр алдаргүй байсан цаг үеийн турш сэтгэлийнхээ гүнд нурж байсан зураг бол эд хөрөнгө, нэр алдарыг гартаа атгаж чадсан өөрийнх нь дүр зураг байсан юм. Дэлхийн хэмжээний зураач болсон өөрийнх нь төрх шүү. Пикассогийн хувьд сэтгэлийн гүн дэх төсөөлөл нь хангалтгүй санагдаж байгаа юм шиг ам л нээвэл ингэж хэлдэг байжээ.

“Би уран зургаар тэрбумтан болох болно.”

“Би уран зургийн тцүхэнд шинэ цөийг нээсэн зураач болох болно”

“Би хамгийн баян хүний амьдралаар амьдарч байгаад хамгийн баян хүнээр үхэх болно.”

Харин Ван Гог эсрэгээр сэтгэлийнхээ гүнд аажмаар бүдэгрэн алга болж байгаа өөрийн төрхийг л зурдаг байлаа. Идуурал, өвчинд баригдан амьдарч байгаад хөөрхийлөлтэй үхэж байгаа тийм л зургийг. Пикассогийн нэгэн адил өөрийн амьдралыг ямар байхыг ингэж хэлдэг байжээ.

“Би насан туршдаа ийм хөөрхийлөлтэй амьдралаар амьдарч байгаад үхэх байх.”

“Би мөнгөтэй байх хувь тавилангүй юм шиг байна.”

“Азгүй тохиол надаас салахгүй юм шиг байна.”

Иймэрхүү үгсийг түүний дүү Теодоо бичсэн захиануудаас олж илрүүлсэн юм.

Яг адилхан авъяас чадвартай хоёр хүний амьдрал нь тэр хоёр сэтгэлдээ юу төсөөлж байсан яг л тийм болсон байна. Харин Ван Гогийн гараар бүтээгдсэн гайхамшигт бүтээлүүд нь түүнийг хөөрхийлөлтэй нас барсны дараа эзнийхээ бүтэлгүй VD-ийн нөлөөнөөс салсан цагаас эхлэн өөрийнхөө оршин тогтнож байгааг дэлхий дахинд мэдэгдэж эхэлсэн билээ.

❖ Зочид буудлын хааны ӨЧИЛ

Хүний ирээдүй түүний авъяас чадвараас биш харин сэтгэлийнхээ гүнд нүдэндээ харагдтал төсөөлдөг тэр зургаас

шалтгаална гэж батлан хэлдэг нэг хүн байсан. Тэр хүн бол тааруухан явдлаараа алдартай Пэрис Хилтоны өвөө Конрад Хилтон юм. Конрад Хилтон дэлхий даяар байгаа 250 гаруй Хилтон зочид буудлын сүлжээг бий болгосон хүний хувьд өнөөдөр ч гэсэн “Зочид буудлын хаан” гэж нэрлэгддэг билээ.

Тэр анх зочид буудалд үйлчлэгчээр ажиллаж эхэлсэн гэдэг. Тэрээр мөнгө ч үгүй юу ч үгүй гэр бүлээс гаралтай урт удаан хугацааны туршид санхүүгийн хувьд чадвар муухан хүмүүсийн дунд амьдарч байв. Тэгээд мөнгөтэй, чадалтай хүмүүсийн цүнхийг зөөж, тэдний буух өрөөг цэвэрлэж, сайн муу бүхнийг нь хийж амьдралаа авч явдаг хүн байсан юм. Конрад Хилтон хэзээнээс ямархуу байдлаар $R=VD$ -г хэрэглэж эхэлсэн нь тодорхойгүй байдаг. Ажиллаж байсан буудалд нь бууж байгаа амжилтын эзэдтэй үргэлж нүүр тулан харьцдаг байсан болохоор өөрийн эрхгүй сурсан ч байж болох юм. Ямар ч л байсан тэр арван хэдтэй байхдаа л өндөр зэрэглэлийн VD -г хийдэг болсон байсан байна.

Тухайн үеийнхээ АНУ-ын хамгийн том зочид буудлын зургийг олж аваад ширээн дээрээ нааж, тэр буудлынхаа эзэн болсон өөрийнхөө зургийг “хүчтэйгээр” төсөөлдөг байлаа. Зүгээр л нэг ирээдүйн тухай мөрөөдөл зэргийн юм биш байв. Бодит амьдрал ба мөрөөдлийн ертөнц хоёрыг ялгаж чадахааргүй болтол хүчтэйгээр VD хийж байв. Өдөрт хэдэн арван удаа бүр биенийхээ бүх чадлыг барагдтал шүү.

15 жилийн дараа 1949 оны 10 сард Конрад Хилтоны VD нь R болсон. Тэр Америкийн хамгийн том зочид буудлын эзэн болж чадсан байв. Нэг л өдөр Зочид буудлуудын хаан болж чадсан түүнээс хүмүүс амжилтынх нь нууцыг асуух бүрд тэрээр ингэж хариулдаг байлаа.

“Хүмүүс авъяас чадвар ба хичээл зүтгэл амжилтыг авчирч өгдөг гэж ихэвчлэн боддог. Гэхдээ үнэндээ тийм биш юм. Амжилтыг татан дуудагч гол хүчин зүйл нь нүдэндээ харагдтал мөрөөдөж чадах чадвар юм. Намайг буудлын үйлчлэгчээр ажилладаг байхад миний эргэн тойронд яг над шиг үйлчлэгч хөвгүүд олон байсан.

Зочид бууцлыг удирдах чадвар нь надаас илүү хүмүүс бүр олон, тийм амайг бодвол илүү сайн ажилладаг хүн ч бас олон байсан. Харин бүх л биеэ дайчлан амжилт олж байгаа өөрчлөлийн зургийг нүдэндээ харагдтал зурж байсан хүн ганцхэвч би л байсан юм. Амжилт олоход хэрэгтэй хамгийн чухал зүйл бол мөрөөдөх чадвар билээ.” (10).

Мэргэжилтэн АМЖИЛТАНД ХҮРДЭГ

Эхэнд нь Онассис болон Спилбергийн тухай, энд Пикассо Жилтоны жишээ гээр R=VD аргын хүч чадлын тухай өгүүлсэн а бас л дутуу байгаа мэт санагдаж байна.

Нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол үнэхээр биелнэ гэдэг нь нэг л үнэмшилгүй сонсогдож байгаа байх. Гэхдээ тийм биш юм. R=VD шинжлэх ухааны үүднээс аль эрт батлагдсан. Энэ тухай дараагийн хэсэгт ярих болно.

“Чиний үнэхээр хийж чадахаар ажлаа олсны дараа бүх хүч чадлаа дайчил. Тэгвэл амжилт олох болно.”

Бодоод үз л дээ. Ямар оновчтой бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй үг вэ? Иймэрхүү зүйлийг хоолойгоо хүчлэн хичээн л бол хичээн ярьж болно. Харин “Байнга туйлдталаа ирээдүйгээ төсөөлөн бод. Тэгвэл амжилтанд хүрэх болно. “Ийм яриа бол хоолой дээр ирээд л гацаж орхино. Бүр амнаас ч гарахгүй. Магадгүй бид R=VD томъёонд бат итгээгүй бас гэр бүлийнхэн найма нартаа итгэлтэйгээр хэлж ярьж чадахгүй болохоор хараахан амжилтанд хүрч чадаагүй ч байж болох юм.

Гэхдээ бодоод үзээрэй. Амжилт гэдэг тэр үг өөрөө хичээн бодит бус вэ? Гэдгийг Ядуусын хорооллын залуу дэлхийн хамгийн баян хүн болж, киноны зураг авалтын талбайгаас хоогдох гэдэг ажил хийдэг байсан нэгэн Академийн шагналт кино найруулагч болж, буудлын үйлчлэгч банди 250 зочид буудлын эзэн болж чадсан байна шүү дээ. Иймэрхүү зүйлийг л амжилт гэх ёстой байтал эдгээр яриа маань ч гэсэн тэгвэл үнэхээр бодит бус байгаа биш гэж үү!

Тийм юм гэж хэзээ байсан гэж хэлэгдэхээр зүйлийг бүтээхийн тулд боломжтойд тооцогдох аргаар бүтээх бололцоо байхгүй гэж би бодож байна. Конрад Хилтоны хэлсэн шиг зөвхөн авъяас, хичээл зүтгэлээр бүтэхгүй ээ. Тийм юм гэж юу байдгийн гэхээр ажлыг бүтээхийн тулд боломжгүй гэсэн арга л хэрэглэгдэнэ. Өөрөөр хэлбэл $R=VD$ -г хэрэгжүүлэх шиг.

Нэг ижил дээд сургуульд, нэг компанид ажилд орно гэдэг нь адилхан чадвартай байна гэсэн үг. Захирлын хувьд удирдан авч явна гэдэг ч мөн адил. Хэдийгээр хэмжээ хүрээ нь өөр ч компаниа босгож авч явна гэдэг нь тэр чигээрээ ижил бизнесийн чадвартай байгаа гэсэн үг. Гэтэл 10 жилийн дараахь ирээдүй нь хүн тус бүрийн хувьд шал өөр. Амжилтанд хүрсэн нь 10-аас 1 хүн л байдаг.

Амжилтанд хүрсэн хүн бүр $R=VD$ -г хэрэгжүүлж чадсан хүн байна гэдгийг би баттай хэлж чадна. Мэдээж тэр хүн өөрийгөө $R=VD$ -ын хүчээр амжилтанд хүрсэн гэхгүй л байх. Манай үеийнхний ёс заншилд тааруулан даруухнаар “Зүгээр л би их азтай хүн” гэх болов уу? Амжилтанд хүрэгсэд сайн мэдэж байгаа учраас тэр. Харин амжилтанд хүрч чадаагүйчүүдийн ихэнх нь $R=VD$ -ын хүчийг мэдэх ч үгүй итгэх ч үгүй. Амьдралын туршид өөрийн хүсэл мөрөөдлөө ярих гэж оролдоод үл тоомсорлуулан доромжлуулсан гашуун туршлага ч нэг биш удаа тохиолдсон байх болно.

Зохиогч энэ номыг бичихийн тулд өөрийн хүчээр орон гэртэй юм юмтай болсон олон хүнтэй уулзаж ярилцаж үзсэн. 30 орчим насандаа Каннам дүүрэгт (*Сөүлд газар нь хамгийн цнэтэй дцүрэг*) 3 газар бизнес эрхэлж байгаа хүн, 30 нилээн гараад 2 аптек ажиллуулж байгаа хүн, мөн л 40 дөхөж яваа насандаа брэндийн дэлгүүртэй хүн, 40 дөнгөж гарсан насандаа өдөрт 5 сая давсан орлоготой байгаа хүн гэх мэт.

Тэднээс “ $R=VD$ -г мэдэх үү?” гэж асуусан. Бас “Хэрэгжүүлж үзсэн удаа байна уу?” гэж асуусан юм. Тэдний хариултыг нэг л өгүүлбэрээр илэрхийлэхийг хичээе. Тэд бүгд ингэж хариулсан юм.

“Би $R=VD$ мэргэжилтэн юм шүү.”

3. ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭС ИЛҮҮ ЧУХАЛ ЗҮЙЛ БОЛ МӨРӨӨДӨХ ЧАДВАР

Эйнштейн ба $R=VD$

Жирийн нэгэн эрдэмтэнд “Шинэ нээлт хийхийн тулд лабораторитоо байнга хадаатай байх шаардлага байхгүй. Туршлага хийж байгаагаар толгойдоо төсөөлөх л хангалттай” гэж хэлвэл яах бол? Үгүй ээ, энэ асуултыг таниас асуумаар байна. Та юу гэж бодож байна?

Эйнштейн Шинжлэх ухааны түүхийг шинээр бичсэн хүн билээ. Тэрээр үнэхээр хэлэх юм байхгүй сод ухаантан. Хэдэн зуунд нэг удаа төрдөг! Гэтэл гайхалтай нь Эйнштейн лабораторит туршлага хийж байсан нь ховорхон гэнэ. Тэрээр ихэнхдээ $R=VD$ туршлага хийдэг байсан байх юм. Харин зөрүү бараг гардаггүй байсан аж. Жинхэнэ хэмжилтийн дүнтэй огт зөрүүгүй яг таардаг байсан байна. Хүн төрөлхтөний хамгийн суут эрдэмтдийн нэг болох тэрээр VD хийвэл R болно гэдгийг өөрийн туршлагаараа баталж чадсан юм.

Эйнштейний харьцангуй онол нь $R=VD$ аргын хүчийг гэрчилж чадсан томоохон жишээ юм. Эйнштейн бүх талаар нь VD туршилтаар дамжуулан харьцангуйн онолыг бүрэн гүйцэт нээж чадсан. Харин үүнд эргэлзэх хүн цөөнгүй байлаа. Финкийн салбарын Нобелийн шагналт эрдэмтэн Лоренц нарын зэрэг хүмүүс харьцангуйн онолыг анхнаас нь эсэргүүцэж байсан. Нэг бодлын мэдээжийн асуудал байлаа. Эйнштейнд урдаа бариад үзүүлчихмээр туршлагын дүн хариу гэхээр юм ганц ч байгаагүй учраас.

1919 оны 5-р сарын 29-нд Английн одон орон судлаач Эддингтон ажиглалт хийхээр Африкийн Кен улс руу явжээ. Нарны хиртэлтийг судалвал Эйнштейний онолын зөв эсэхийг мэдэх боломжтой учир. Хэрвээ Эйнштейний онол үнэн бол Нар хиртэлтийн үед нарны ойролцоох одод нарны таталтын долоогөөр жинхэнэ байх ёстой байрнаасаа бага зэрэг хазайж үзэгдэх ёстой байлаа. Ажиглалтын үр дүн нь Эйнштейний зөв

байсныг баталсан юм. Нарны таталтаар байрлалаа өөрчилсөн одны байрлалыг тооцоолж үзэхэд Эйнштейний VD туршилтаар гаргаж авсан дүнтэй яв цав нийлж байсан юм.

Товчоор дүгнэхэд:

1. Эйнштейн шинжлэх ухааны салбарт амжилт олохыг хүссэн.
2. Эйнштейн VD хийсэн.
3. Эйнштейний VD нь R буюу бодит болсон.

Таны хувьд ч адилхан. Амжилт олохыг хүсвэл VD хийх ёстой. Тэгвэл хэзээ нэгэн цагт таны VD бодит R болох болно.

Жирийн хүмүүс үхтэлээ хичээж ажиллахыг амжилтын үндэс гэж боддог. Харин амжилтын эзэд бол амжилт олон гялалзаж байгаа өөрийнхөө төрхийг нүдэндээ харагдтал төсөөлөх чадварыг амжилтын хамгийн гол зүйл гэж үздэг. Энэ хоёрын хэнийх нь зөв гэж бодож байна? Мэдээж амжилтанд хүрэгсдийн зөв.

Зочид буудлын хаан Конрад Хилтон амьд ахуйдаа “Буудлын хаан гэгдэх би болон жирийн буудлын үйлчлэгч хоёрын ялгаа нь ганц л зүйлд, амжилтыг төсөөлөх чадварт л байгаа.” хэмээн амны уншлага болгон явдаг байсан гэдгийг тунгаан бодоосой гэж хүсэж байна.

Эйнштейний хувьд ч ялгаагүй. Эрдэмтдийн ихэнх нь зөвхөн лабораторитоо ажиллаж амьдарч байж л амжилтанд хүрнэ гэж итгэдэг байхад, Эйнштейн VD хийхэд л амжилт ирэх болно гэдэгт итгэж байсан юм. Тэрээр сэтгэл амар амьдардаг байлаа. Найз бүсгүйтэйгээ болзож хайранд умбан, утга зохиол, гүн ухааныг шимтэн судалж, аяллаар явдаг байжээ. Мэргэжил сонгохдоо физиктэй ямар ч хамааралгүй патент олгодог албан хаагчийн ажлыг сонгож байлаа. Тэрээр хоногт 8 цаг патент олгох бичиг баримт шалган амьдралаа залгуулж байсан юм (11). Харин энэ ажлынхаа хажуугаар тасралтгүйгээр VD-гээ хийдэг байлаа. Цацарсан гэрэл унан аялж байгаагаар өөрийгөө төсөөлөн, тэр төсөөлөл дундаа туршилт хэмжилтээ хийдэг байсан юм.

Хар ухаанаар бодоход Эйнштейн амжилтанд хүрэх учиргүй. Лабораторитоо бүхнээ зориулан суудаг хүмүүс л ялалт байгуулах ёстой мэт санагдана. Харин түүх шал өөр бүгдийг хэлж өгч байна. Лабораторитоо үхтлээ ажилласан хүмүүс биш гэртээ тайван амрангаа VD хийж байсан Эйнштейн амжилтанд хүрсэн.

➤ Амжилтыг мөрөөдөх юм бол БОЛОМЖ ӨӨРӨӨ Л ХҮРЭЭД ИРНЭ

Зүгээр л нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол биелнэ гэдэг намар ч амьдралгүй үнэмшилгүй сонсогдож байгаа байх. Тийм бодохоор хүмүүсийн ихэнх нь VD хийдэггүй. Магадгүй та ч гэсэн хийхгүй байгаа. Бүр хийж үзсэн удаа ч байхгүй л байгаа бизээ.

Иг энэ үедээ л бодож үзээрэй гэж хүсэж байна. Нийгэмд амжилт олсон хүний тоо цөөхөн байдгийн учир нь VD-г хийдэг хүний тоо цөөхөнтэй холбоотой байж болохыг! Бас одоог хүртэл таны амжилт олж байгаагүйн учир ч гэсэн таны амьдралаас VD гэдэг ойлголт хол байсан учраас ч байж магадгүйг!

Одоо бүгдээрээ бараг хүн бүхний мэддэг Жеймс Нетмед хошуучийн тухай ярианд орцгооё.

Тэрээр Вьетнамын дайнд оролцон тулалдаж байгаад аялагдон 7 жилийн турш бага сургуулийн хүүхэд дөнгөж багтах төдий нүхэнд хоригдож байжээ. Түүний хувьд бусад хоригдлуудтай уулзах болон дасгал хөдөлгөөн хийх хориглогдсон байлаа. Нетмэд хошуучийн өмнө хоёр зам байсан юм. Нэг бол галзуурч үхэх үгүй бол төсөөллийн ертөнцөд амьдрах.

Мань хүн хоёр дахь замыг сонголоо. Тэгээд сэтгэлийн гүндээ гольфийн талбай бүтээв. Ингээд л нүдэндээ харагдтал төсөөлж эхэлсэн байна. Гольфийн цохиур барьсан өөрийгөө, нов ногоон зүлэг, энд тэнд ургасан модод, моддын мөчир дамжин гүйлдэх хэрэмнүүдийг, нүүр зөөлөн илбэх салхи, тэнгэрт нүүх үүлсийг, хамтдаа гольф тоглож байгаа хүмүүсийг... Өмссөн гольфийн хувцсаа, зүлэгний үнэр, хэрэмнүүдийн гүйлдэж

байгаа чимээг хүртэл сонсож, мэдэ [] оч, үнэртдэг байсан гэхээр үнэхээр бодитойгоор төсөөлж байса [] н байгаа биз. Тэр өдөр бүр 4 цаг төсөөллийн 18 нүхээ тойрдог [] байсан байна.

7 жилийн дараа суллагдсан [] тэрээр гольфийн цохиур гартаа барьлаа. Тэгээд бодит амьд [] ал дээрхи 18 нүхээ тойрч үзлээ. Гайхмаар нь анхны цохилто [] ороо 70 оноо хийсэн байна. Гольф тоглох чадвар нь 7 жилийн [] өмнөхтэй харьцуулахад 20 оноогоор сайжирсан байсан байна ([] 2).

Хошууч Жеймс Нетмэд чадсан [] бол та ч гэсэн чадна гэсэн үг. Өнөөдрөөс эхлээд амжилт ол [] ж байгаа өөрийн төрхийг байнга нүдэндээ төсөөлөх юм бо л [] жинхэнээсээ амжилт олж чадна. Болгоомжтойгоор хэлэхэд амь [] сил огт хийхгүйгээр ч гэсэн амжилт олох боломжоос зуураад амь [] ах боломжтой юм.

Онассис болон Спилберг далайн [] тээвэр, киноноос холоос хол байсан гэдгийг санаарай. Онассис [] тамхины наймаачин, харин Спилберг хэн ч хэрэггүй кино на й [] уулагч болохыг мөрөөдөгч л байсан гэдгийг. Тэгээд тэр үеийн [] далайн тээврийн компанийг болон киноны студийг бодоод үзэ [] эрэй. Алдартай усан онгоц үйлдвэрлэгч компанид болон кино [] үйлдвэрт нуруугаа хугартал ажил хийж байсан хамгийн чадва [] арлаг хүмүүсийг бодоорой. Хар ухаанаар бодоход сүүлд яригд [] аж байгаа хүмүүс л амжилт олох нь зүй ёсны хэрэг мэт. Гэвч [] үнэн амьдрал дээр амжилт ологсон нь Онассис болон Спилберг [] байсан юм.

Та өөрийн амьдралаа нэг [] ргээд хараарай. Амжилт олохын төлөө өөрийнхөөрөө хич [] нгүйлэн зүтгэсэн ч сайхан боломжуудыг бусдад алдсан у [] даа байхгүй юу? Нэг их хичээдэггүй өрсөлдөгчдөө ялагда [] ж байсан удаа байхгүй гэж үү? “Энэ удаа үнэхээр сайхан [] болно” гэж бодон бүхий л мөрөөдлөөрөө дэнчин тавьсан ч элц [] ийн мөчид хөөс мэт замхран өнгөрсөн удаа байхгүй гэж үү?

Магадгүй танд ялагдлын га [] шуун амтыг мэдрүүлсэн тэр хүн хэнд ч мэдэгдэхгүйгээр $R=VD$ [] хэрэгжүүлэгч нэгэн ч байж болох юм. Магадгүй та эцсийн мөч [] ид ялагдсан шалтгаан нь та амжилтын “түлхүүр” гэж нэрлэж [] болохоор VD дутагдсанаас ч болсон байж болох юм.

Хэрвээ амьдрал дээр нэг их хичээгүй боловч ганцхан VD-
өөр гялалзсан амжилтанд хүрсэн хүмүүсийн яриаг ном болгоё
гэвэл 100 гэдэг тоо ч багадах байх.

Амжилтанд хүрэхийг хүсэж байвал түүнийгээ
"Нүдэндээ харагдтал төсөөлөх" ёстой. Тэгэхэд тань
рүү хувь тавилангийн боломж хүрээд л ирэх болно.



4. АМЖИЛТЫГ R=VD ШИЙДВЭРЛЭДЭГ

☞ Амжилтанд хүрэгсэд ба БҮТЭЛГҮЙТЭГСДИЙН ЯЛГАА

Амжилттай сайн ажиллаж байгаа компани ба энгийн л нэг компани болон муу ажиллаж байгаа компани эдгээрийн ялгаа юу вэ? Амжилтын эзэн ба жирийн нэг хүн, тэгээд бүтэлгүйтсэн хүн эдгээрийн ялгаа юунд байна вэ? Янз бүрийн л зүйлд байгаа. Гэхдээ хамгийн гол шийдвэрлэгч ялгаа бол R=VD-д яаж хандаж байгаагаас шалтгаалдаг гэж л би хэлмээр байна.

Амжилтын эздэд ийм нэгэн нийтлэг шинж байдаг.

1. R=VD-г хэрэглэн амжилтанд хүрдэг.
2. Амжилт олох туршлагатай мэргэжлийн хүмүүст асар их хэмжээний мөнгө төлөн мэргэжлийн R=VD хийх дадлагад суралцана.
3. Тасралтгүйгээр амжилт олох болно.

Байгуулагдсан анхны цагаасаа эхлээд л маш хүчирхэгээр амжилтын VD хийн амжилтанд хүрэн, Фортун 500-ийн тоонд орсон дэлхийн шилдэг компаниуд нь VD мэргэжилтнүүдийг урин тогтмол 1 удаадаа хэдэн арван сая эсвэл 100 саяар нь төлөн төгс төгөлдөрөөр VD хийх аргад суралцдаг. IBM, Американ Экспресс, AT&T цахилгааны компани, Cambellsoup, Domina pizza, Sunkist, Johnson&Johnsons, General Electric зэргийг дурдаж болно.

Билл Клинтон, Жорж Буш нарын АНУ-ын экс ерөнхийлөгчид, Хиллари Клинтон нарын зэрэг сенаторчид, дэлхийн лидер удирдагчдын холбоо түүний ивээн тэтгэгчид, дэлхийн улс тус бүрийн олимпын шигшээ багийн тамирчид, Андре Агасси, Грег Норман нарын зэрэг хамгийн өндөр цалинтай тамирчид, Том Круз, Жим Керри нарын алдартай жүжигчид, Ванесса Мей шиг дэлхийн хэмжээний хөгжимчид, альбом гаргах бүрдээ Биллборд жагсаалтыг тэргүүлдэг дуучид, АНУ-ын хуурай болон тэнгис агаарын хүчний цэргийн адмиралууд ч мөн

адна. Тэд амжилтын хүчирхэг VD-ээр суурилан амжилтанд хүрэхийн тулд, багаар бодоход хэдэн арван саяас эхлэн хэдэн зуун сая хүртэл төлбөр хийж амжилтын VD мэргэжилтнээр системтэйгээр VD хичээл заалгадаг.

Тэд сайн мэдэж байгаа. Амжилтын VD тэдний амьдралд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд одоо ч гэсэн тэдэнд амжилтын баталгаа болж, ирээдүйд ч гэсэн амжилтанд хүргэнэ гэдгийг...

Харин жирийн хүмүүст ийм нийтлэг шинж байдаг.

1. R=VD аргыг огт хэрэглэдэггүй.
2. Мэргэжилтэнд төлбөр төлөн амжилтын VD сургалт хийнэ гэдэг солиотой хүний яриа шиг сонсогддог.
3. Ядартлаа ажиллан нэг л хэвийн амьдардаг.

Ийм хүмүүсийн төлөөлөгч жишээ нь? Та холоос хайсны хэрэггүй. Таны яг хажууд л байгаа. Бүр маш олон байгаа. Магадгүй таны найз нар ч юмуу эсвэл та өөрөө ч байж магад. Ийм хүмүүс ажлын их багын хэмжээ биш харин VD дутагдсандаа тэднийг амжилтаас холдуулаад байгаа гэсэн шийдвэрлэх шалтгааныг ойлгож чаддаггүй. Тэд амжилт олохын тулаа улам их ажиллахыг сонгодог. Мэдээж хичээл зүтгэлийн үр дүнд байдал арай дээрдэнэ. Гэхдээ гялалзсан амжилтын амьтыг бол хэзээ ч үзэхгүй. Хальт амжилтанд хүрсэн ч эргээд л байсан байрандаа ордог. Дүгнээд хэлэхэд тэд хэзээд эгэл жирийн байсан тиймээрээ үлдэх болно.

Илалдагчид бүтэлгүйчүүлд ийм нийтлэг шинж байдаг.

1. Санаатай ч тэр санаандгүй ч тэр сөрөг VD хийх чадвар нь гаргуун.
2. Тэгээд бодит байдал VD-ээр нь батлагдаж сэтгэлээр унаад бүтэлгүй VD-гээ хийж эхэлнэ.
3. Үргэлжилсэн бүтэлгүйтлүүд эцсийн эцэст дахин хэзээ ч босож ирэхгүй.

Ийм хүмүүсийн шилдэг жишээ нь хэн байхав? Сүйрэх хуль тавилантайгаа эвлэрсэн бизнес, нурахын даваан дээр

байгаа гэр бүл, SOS өгөхийн ирмэгт очигсод, ажилгүйчүүд, дампуурагчид, орон гэргүйчүүд гэх мэт. Тэдний VD чадвар амжилтын эздийн VD хийх чадвараас илүү. Гэхдээ эсрэг талруугаа шүү.

Энэ группынхны бүтэлгүй VD хийх чадвар нь гойд гаргуун. Тэдний хийж байгаа ажлын хэмжээ ба ажилд зориулж байгаа энерги нь эхэнд дурдсан 2 группынхнээс онцын ялгаагүй. Гэхдээ л байнга бүтэлгүйтэж байдаг. Өнгөцхөн харах юм бол тэдэнд бүтэлгүйтээд байх шалтгаан огт байхгүй мэт. Тийм учраас тэд эргэн тойрноо болон хорвоо дэлхийг буруутгадаг. Тэд тэднийг бүтэлгүйтэл рүү түлхээд байгаа шийдвэрлэх этгээд нь тэр өөрөө гэдгийг мэддэггүй.

Өнөөг хүртэл та ямар VD хийж ирсэн бэ? Амжилтын VD юу, бүтэлгүйтлийн VD юу, эсвэл ямар ч VD хийж байсангүй юу? Бас энэ нь таны амьдралд ямар нөлөө үзүүлж байна вэ? Амжилтанд хүрэхийг хүсэж байгаа бол бие сэтгэлээ амжилтын энергиэр дүүргэх хэрэгтэй. Ялагч шиг бодож, үйлдэж, VD хийх ёстой. Ганцхан ажил хичээнгүйлэн хийснээр амжилтанд хүрнэ гэж хэзээ ч байхгүй. Газраас хөндийрөн тэнгэрт нисэхийн тулд 2 далавч хэрэгтэй байдаг шиг амжилтанд хүрэхийн тулд хичээл зүтгэл гэдэг далавчнаас илүү амжилтын VD хэмээх арай өөр далавч зүүх хэрэгтэй юм шүү.

☞ Төсөөлөх чадвар БОДИТ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОНО

Уолт Дисней амжилтын өндөр шаардлага тавьдаг хүн байсан гэдэг. 9 настайгаасаа л үүрийн 3 цагт босож сонин түгээдэг байсан гэхээр өөр илүү юм ярих хэрэггүй байх. Арван хэдтэйдээ сурахын хажуугаар 2 газар цагийн ажил хийдэг байсан бөгөөд энэ бүхнийг өөрөө хүссэн болохоор хийдэг байсан гэдэг. Шалтгаан нь ганцхан л байв. Хурдхан их мөнгөтэй болж хүүхэлдэйн кино хийдэг компанитай болохын төлөө тэр. Гэвч Дисней амжилт олохын тулд юу юунаас түрүүнд амжилтын VD хийх ёстой гэдгийг мэддэггүй байлаа.

Бусдын нэгэн адил Дисней хичээнгүйлэн ажиллаж байсан болохоор мөнгө ч их цуглуулж чадсан байсан. Тэгээд

Эрмэлдэлдөө хөтлөгдөн байгуулсан Лау-О-Грэм кино компани нь 1 жил ч бололгүй сүйрч, захирал Уолт Дисней нь ажилгүй болж үлдсэн. Захиалагчдаа луйвардуулсан нь гол шалтгаан нь байлаа. Амжилтын VD хийж байсан Онассис ба Спилбергийг "Эрхэм мэддэгтэй уулзах уулзалт" өөрөө хайгаад ирж байхад, амжилтын VD-г хийж мэддэггүй Уолт Диснейг "муу хүнтэй уулзалт" хайж ирсэн гэдэг үнэнийг сайтар тунгаан бодож үзвэл.

Хүн төрөлхтөнд бүтэлгүйтлийн VD хийх чадвар төрөлхийн л шингэсэн байдаг. Цөмийн дайнд сүйрсэн дэлхийн дүр зөрхийг кино ном зэрэгт нүдэнд харагдтал дүрсэлж чаддаг мэтлэн бүгдээр энх амгалан амьдрах диваажинг дүрслэх чадваргүй оршихуй бол бид билээ. Хувь хүний хувьд ч адил. Дээр нь амжилтыг гартаа хийж байгаагаар төсөөлж чадахгүй мэтлэн бүтэлгүйтээд гудамжинд гарч байгаагаар бол хэнбугай ч гэсэн нүдэндээ харагдтал зураглаж чадна даа.

Бүтэлгүйтлийн VD чадвар нь жирийн үед бидний дотор тэнгис унтаж байгаад жинхэнээсээ хүнд байдалд ороод ирэхээр атигас гээд л сэрж бидний дотоод сэтгэхүйг эзэмддэг. Нэг бүтэлгүйтсэн хүн үргэлжлүүлээд л бүтэлгүйтээд байдгийн хамгийн гол шалтгаан нь тэр хүн угаасаа мулгуу тэнэг эсвэл буруу үеийг сонгоод байгаадаа биш юм. Бүтэлгүйтлийн VD-ээр улам олон том том азгүйтлийг үргэлжлүүлэн дуудаад байдаг учраас тэр юм.

Уолт Дисней ч гэсэн энэ хүлээснээс мултарч гарч чадахгүй байлаа. Нэг удаа бүтэлгүйтээд л өөртөө итгэх итгэлээ алдаж сөрөг VD хийж эхлэн эцэстээ тэр нь бодит байдал болж байгаа юм.

Диснейн бүтэлгүйтлийн VD-ийн татан дуудсан азгүйтлэлчдийн байсан.

1. Мэдээний зураг авдаг газар зурагчнаар ажилд орсон ч удалгүй халагдав.
2. Байрныхаа мөнгийг төлж чадахаа болиг гурван ч байрнаас хөөгдөнө.

3. Хоол авч идэх мөнгөгүй болон хүмүүсийн баралгүй үлдээсэн талхаар хооллож байсан.

Харин ашгүй 2 жилийн дараа Холливуд явахаар зориглон тэнд очиж чадсан. Гуйлагчин шиг л хувцаслан Голливудад очсон юм.

Харин Уолт Дисней ажиглалт хийх тал дээрээ хэнийг ч дагуулахааргүй хүн байлаа. Хэрэмний тухай баримтач киноны зураг авахдаа АНУ-ын Юта мужийн хойд хэсэгт 20 хүнтэй группын хамтаар 3 жилийн турш хэрэм ажигласан гэх жишээтэй (13). Дисней тэр алдартай ажиглах чадвараараа Холливудын алдарт кино найруулагчид, жүжигчид болон багийнхныг ажиглаж байв. Тэгээд тэд бүгд нэг хүн шиг амжилтын VD хийж, мэргэжилтнүүдэд мөнгө төлөн VD хийх аргыг суралцаж байгаа гэдгийг олж мэдсэн байна. Ингээд тэр амьдралаа ийм VD-ээр дүүргэж эхэлсэн байна.

1. Амьдралдаа анх удаа амжилтын VD хийн байж бүтээсэн “Алиса үлгэрийн оронд” хүүхэлдэйн киноны эхний 6 анги гарсан даруйдаа л далавч зүүсэн мэт борлогдсон байна. 7-р ангиас эхлэн олны анхаарал татахаа больсон гэсэн шалтгаанаар хийхээ боль гэсэн санал гарсан ч гэсэн амжилтын VD хийж байгаа болохоор заавал амжилтанд хүрнэ гэж зүтгэсээр 12 хүртэл ангийг нь хийсэн байна. Тэгмэгц дахин сэргэн чадварлаг найруулагч гэдгээ баталж чадлаа.
2. Улам эрчимтэйгээр VD хийсээр бүтээсэн кино “Освальд сериал” нь урд байгаагүй амжилтанд хүрч чадсан юм.
3. “Микки маус”-ыг хийхэд ажилчид нь түүнийг эсэргүүцэн зарим нь ажлаас гарч, хөрөнгө оруулагчийн зүгээс түүний амжилтанд эргэлзэн хөрөнгө оруулалтандаа унжиж байсан ч тэр зүтгүүлсээр байж хийсэн бөгөөд энэ кино Диснейн амжилтын VD-ээр дээд рекорд тогтоож чадсан.
4. “Микки Маус” бүтээх үеэс эхлэн Дисней академийн шагнал авч байгаагаар төсөөлж эхэлсэн бөгөөд 4 жилийн дараа энэ нь бодитоор биелсэн юм.

8. Анахемд Диснейлэндийг босгохдоо 320 гаруй банк хөрөнгө оруулагчдаас “бүтэх найдваргүй” гэсэн шалтгаанаар татгалзсан хариу авсан байсан ч тэгэх тусам бүр ч илүүгээр нүдэндээ харагдтал Диснейлэндийг төсөөлөх болсон бөгөөд эцсийн үр дүн ямарыг бид сайн мэднэ.

9. АНУ-ын Флоридад байдаг Эпкот төв, Японы Диснейленд, Францын Диснейлэнд ч мөн адил түүний бүх хүчээ дайчлан байж хийсэн VD шүү дээ. Эдгээр барилгууд нь түүнийг нас барснаас хойш хэдэн жилийн дараа баригдсан юм.

Имар ч алдар нэргүй байхдаа Дисней өглөө нойрноосоо гаравгүүтээ 2 нүдээ тас аниад Холливудын хамгийн сайн кино найруулагч болсон өөрийнхөө дүр төрхийг нүдэндээ харагдтал төсөөлдөг байлаа. Тэгээд чамархайндаа долоовор хуруугаа хүргээд чангаар ингэж хашгирдаг байлаа.

“Миний төсөөлөх чадвар миний бодит амьдралыг бүтээх болно. Би Холливудын хамгийн шилдэг кино найруулагч.”

Нэг л одор өөрийн VD-ээр Холливудын хамгийн шилдэг кино найруулагч болж өөрийн кино компанитай болж чадсан Дисней өглөө бүр 7.30 минутад бүх ажилчдаа студидээ цуглуулаад ийм ёслол хийхийг шаарддаг байжээ.

1. Тухайн үед зургийг нь авч байгаа киноныхоо амжилтыг нүдэндээ харагдтал төсөөлнө.
2. Чамархайндаа долоовор хуруугаа хүргэнэ.
3. Чанга дуугаар “Бидний төсөөлөх чадвар бидний бодит амьдрал дээр биелнэ. Бидний бүтээж байгаа кино дэлхийн хамгийн шилдэг кино” гэж хашгирна (14).

Уаааа Диснейн жишээнээс бид ийм зүйлийг сурч болно.

1. Амжилтын VD хийхгүйгээр хичээнгүйлэн ажиллахад амжилтанд хүрч болно. Гэвч дараа нь яах вэ гэдэг л асуудал юм. Санаанд ороогүй газраас аюул нүүрлэн ирж магад.

2. Юу ч үгүй болтлоо шатсан ч амжилтын VD хийгээд эхэлвэл найдвар байгаа. Гайхамшиг гэмээр амжилтыг дуудаад ирэх болно.
3. “Лау-О-Грэм Хүүхэлдэйн Кинокомпани” биш “Уолт Дисней Кинокомпани”-ий явсан замаар явахыг хүсэж байгаа бол одооноос эхлээд амжилтын VD хийж эхлэх ёстой шүү.

Та яг одоо яаж амьдарч байна? Мөн $R=VD$ аргад хэрхэн хандаж байна? Хэрвээ та зөвхөн ажлаа, маш сайн хийж байгаа бол таны хичээл зүтгэл хий дэмий өнгөрөхгүйн тулд одооноос эхлээд амжилтын төлөө VD хийгээрэй. Нүд гялбуулсан амжилт бэлэг болон өгөгдөх болно.

Та, гол харлуулсан, бүтэлгүйтэл, азгүйтэл, ялагдалтай учирсан байгаа бол тэр чигээрээ суугаад байлгүй амжилтын VD хийгээрэй. Шинэ найдварын гэрэл таныг гэрэлтүүлэх болно.

Хэрвээ та аль эрт амжилт олсон бол улам их амжилтын төлөө VD хийгээрэй. Асар том амжилтууд тасралтгүйгээр таныг хайгаад ирэх болно.

Таны VD амжилтыг тань тодорхойлох болно.

5. ХҮН НҮДЭНДЭЭ ХАРАГДТАЛ МӨРӨӨДСНӨӨРӨӨ Л БОЛДОГ

88 R=VD аргын ЭХЛЭЛ

R=VD нь Европ тивээс Америк руу дамжин очсон гэдэг. Тэгээд Омниод Солонгост ирсэн байна. Европт R=VD-г бараг л үгүйсгэсэн нэгэн хүн байсан. Түүнийг Наполеон гэдэг юм. Үнд бүхний мэдэж байгаагаар Наполеон цэргийн гарамгай стратегич байлаа. Чингис хаан Цезарийг удаалах баатар байв. Энэ агуу хүний хэлсэн дайны тухай сэтгэгдэл төрүүлсэн үг байдаг. “Дайн энэ бол төсөөлнө гэсэн үг.”

Энэ Наполеон амжилтын суутан гэгдэхээр хүн байсан. Японы колоничлолын үед япон цэргийн сургуульд солонгос хүн орж сураад Японы эзэн хаан болж барууны хүчирхэг улсуудыг эзлэн Хятадтай нэгтгэнэ гээд бодоод үздээ. Наполеон үнэндээ ийм л зүйлийг хийж чадсан хүн байлаа. Францын колони Виркет төрсөн ч Францын эзэн хаан болоод Европын хаадыг эзлээд сөгдүүлж чадсан учраас тэр юм. Наполеон ялалтын тухай ингэж хэлдэг байжээ. “Ялахын тулд эхлээд ялалтаа төсөөлөх хэрэгтэй.”

Наполеон дайн хаяанд тулаад ирэхээр унтлагынхаа өрөөнд ирж түгжээд дайныг төсөөлөн боддог байсан гэнэ. Наполеон судлаач Макс Карлогийн дүрсэлж хэлснээр бол дайныг “бясалгадаг” байсан байна. Тэр төсөөлөл дотроо дайн хийдэг байж. Идэх ч үгүй, унтах ч үгүй хэдэн өдрөөр үргэлжилдэг төсөөллийн дайнд Наполеоны цэрэг гарцаагүй ялсны дараа дуусдаг байжээ.

Наполеон колони нутгаас гаралтай байсан болохоор Францаас дэмжлэг авч чадаагүй юм. Түүний цэргүүд бараа материалын хангамж, зэвсэг бүү хэл цэргийн хувцас гутлаар ч хангагдаж чадахгүй “Ноорхой цэргүүд” гэж нэрлэгдэхээр байдалд байсан. Эсрэг талд түүнийг сөрөн зогсож байсан Европын генералууд нь улсаасаа асар их хангамж авч байлаа.

Харин тулалдаад ирэхээр ялалт Наполеоных байдаг байсан юм. Дайнд бодитоор бэлдсэн Европын удирдагчид биш шүү.

Наполеон $R=VD$ хуучны Палестинд амьдарч байсан нэгэн хүүгээс сурч авсан байлаа. Тэр үед Палестинд хүний хуви тавилан орчиноос шалтгаалан шийдэгддэг гэсэн сэтгэлгээ газар авсан байлаа. Бүр улсынх нь ноёлогч үзэл бодол байсан юм.

Харин тэр хүүгийн бодол шал өөр байв. Тэр ингэж хэлж байлаа.

“Хүн түүний мөрөөдөж байгаагаар тийм л болох болно.”

Мэдээжээр ийм үзэл бослого гаргаснаас ялгаагүй байсан учир түүнийг барьж эрүүдэн шүүсэн байна. Гэсэн ч тэр үзэл бодлоо өөрчилсөнгүй. Харин ч бүр түүнийгээ “Чин үнэн” гэж тунхагласан байна. Тэгээд хөөрхийлөлтэйгөөр цаазлуулсан аж.

Түүнийг оршуулаад удаагүй байхад түүний дагалдагч нар гэсэн хүмүүс гарч ирэн түүний амьд байхдаа хэлж ярьж байсан үгийг дэлгэрүүлж эхэлсэн байна. Гайхалтай нь тэд “Тэр дахин амилсан, Бурханы хүү бөгөөд хүн төрөлхтөний аврагч” хэмээн тунхаглаж эхэлсэн байна. Тэр дундаас “Хүн түүний төсөөлж байгаагаар тийм л болох болно.” гэдэг үг нь аяндаа дэлхийгээр нэг тарж эхэлсэн аж. Залуу хүүгийн адилаар дагалдагч нар нь ч бүгд баригдан эрүү шүүлт тулгуулсан байна. Харин тэдний хэн нь ч үгээ өөрчилсөнгүй тэгснийхээ төлөөсөнд амиа өгцгөөсөн юм.

Гэхдээ залуугийн дагалдагч нарын үгэнд итгэсэн хүмүүс байлаа. Нэг хоёр хүн ч биш. Нэгэн цаг үеийнхэн ч биш. Тэд хэдэн үе дамжин газар доорхи нийтийн оршуулгын газарт нуугдан амьдарцгааж байжээ. Тэр үймээн дунд байсгээд л баригдаж харгис хэрцгийгээр алуулдаг байлаа. Тэд тоолохын аргагүй олуулаа байсан. Тэгээд эцсийн эцэст Эзэн хаан нь итгэх болж итгэлийн эрх чөлөө нь хүлээн зөвшөөрөгдөж ил гарч ирэн өөрсдийн итгэлээ бүх Европ даяар тунхагласан байна.

“Хүн түүний мөрөөдөж байгаагаар тийм л болох болно.” бол $R=VD$ арга Европ руу албан ёсоор гарч ирсэн гол эхлэл юм. Тэр цагаас хойш энэ арга бүх Европоор тархаж амьдралаа

Энэ үеэр нь өмнөд чадсан хүмүүс гарч ирцгээсэн байна. Тэд бидний
дээрх нь Европын бүх л зүйлсийг бүтээж Америкийг ч бас бүтээн
байгуулсан юм.

Түүний нэг нь Наполеон билээ.

II — VD ба ОРЧИН ҮЕИЙН ФИЗИКИЙН НИЙМЖЛЭХ УХААН

II — VD арга нь хэн нэгэн завтай утга зохиол судлаач юмуу
хүн үзэж авч ядарч туйлдсан ард олныг тайвшруулан аргадах
дээрх нь болгосон амнаас цаашгүй амжилтын дүрэм хууль биш
гэж бид дээр үеийн юмуу орчин цагийн гүн ухаантнуудын
амжилтын онолуудын нэг ч биш.

II — VD гэдэг бол эртний Палестиний нэгэн залуу хүүгийн
амжилт юм. Икөө амийг золиослон байж ойлгуулахыг хүссэн
хүүгийн хууль бөгөөд чин үнэн юм. Тэгээд олон зууныг
дараа нь олон сая хүний амь насаараа дэнчин тавин хамгаалж
энэ XXI зууны бидэнд уламжлан авчирч өгч байгаа хүн
түүний оюунлаг сүнслэг өв хөрөнгө юм. Бид бүрэн дүүрэн
үзсэн болохоор барахгүй өөрийн амьдралыг дэнчин болгон
түүний ч болох арга билээ.

I — $E=mc^2$ эсвэл $E=mc^2$ гэдгээс ч илүүгээр найдаж болохоор
энэ аргыг дэлхий тийм ч найрсаг хүлээж аваагүй юм. Үгүй
бүр эсвэл эргээр үл тоомсорлон басамжилж байв. Нөхцөл байдал
дээр ч өөрчлөгдөөгүй л байна. Гэртээ эсвэл ажил дээрээ энэ
тухай нэг яриад үзээрэй.

"Хүний амжилт нь мөнгө, эрдмийн зэрэг эсвэл чадвар
зэрэг материаллаг бодит зүйлээс биш мөрөөдөх чадвараас
шалтгаалдаг гэнэ." гээд л.

II — Их найрсаг хандлага хүлээгээд нэмэргүй л болов уу.
Хэнэ нь хуумгай хүнд тооцогдох магадлал өндөр байх байх. Бүр
"Дамны ярихаа боль" гэж хэлүүлж ч магадгүй.

X — Үн төрөлхтөн мөрөөдлийн хүчийг эсэргүүцэх өвчин
тусни хсан юм болов уу? Яасан ч гэсэн $R=VD$ түүхийн явцад
дэлхийгээр хүлээн зөвшөөрөгдөж чадаагүй юм. Хоосон

мөрөөдөгчид, хий юманд итгэгч эсвэл шинжлэх ухаанд үл итгэгчдэд хандаж байгаа юм шиг л хандаж ирсэн. Тэгж байтал XX зуун гараад санаандгүй зарим хүмүүст хүлээн зөвшөөрөгдөх болсон. Тэд бол орчин үеийн физикийн буу гэж нэрлэгддэг квантын онол болон харьцангуйн онолыг судлаач нар байлаа.

Квантын физикчид орчлон ертөнц атомаас ч бага өчүүхэн жижиг биетүүдээр дүүрэн байгааг олж нээсэн байна. Тэгээд энэ өчүүхэн жижиг биетүүд нь хэзээ л бол хэзээ материаллаг бодит биет болон хувирах бэлтгэлтэй байдаг гэдгийг олж мэдсэн байна. Бас эдгээр өчүүхэн биетүүд нь ямар нэгэн материаллаг бус хүч буюу энергийн нөлөөнд автдаг гэдэг нь батлагдсан байна.

“Хүн ямар нэгэн зүйлийг нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөдөх юм бол тэр энерги тэдгээр өчүүхэн биетүүдэд нөлөөлж эхэлнэ. Тэдгээр эгэл биетүүд аажим аажмаар материаллаг байдал руу хувирч эхэлдэг. Хүн өөрөө зогсолтгүйгээр мөрөөдөх юм бол эцсийн эцэст өчүүхэн эгэл биетүүд төгс төгөлдөр материаллаг биет болон хувирч уг хүний өмнө бий болох болно.”

Энэ бол орчин үеийн физикийн шинжлэх ухааны ноён оргил гэж нэрлэгдэж байгаа цөмийн физикчдийн олж нээсэн үнэн юм. Далд ухааныг судлагчид цөмийн физикчдийн нээлтийг “Чи үнэхээр чин сэтгэлээсээ хүсэх юм бол орчлон чиний хүслийг хэрэгжүүлэхийн тулд хөдөлж эхэлнэ.” гэж тайлбарлаж байна. Квантын онолын хамтаар орчин үеийн физикийн шинжлэх ухааны нэг багана нь болсон харьцангуйн онол ч бас ижил зүйлийг хэлж байна.

“Энерги нь материаллаг бөгөөд материаллаг биет нь энерги юм.”

Энэ бол харьцангуйн онолын гол утга бөгөөд үүгээр болох юм бол одоо бидний мөрөөдөж байгаа нь ирээдүйн бодит байдал бөгөөд одоогийн бидний байгаа нь өнгөрсөн үеийн бидний мөрөөдөл юм. Арай тодруулбал харьцангуйн онол нь $R=VD$ ийн физик хувилбар гэж үзэж болно.

Эдгээр эрдэмтэд нь $R=VD$ -г хүлээн зөвшөөрдөг эрдэмтэд

Микс Планк 1918 онд Физикийн салбарын Нобелийн шагнал, Вернар Хайзенберг 1932 онд Физикийн Нобелийн шагнал, Эрвин Шредингер 1933 онд Физикийн Нобелийн шагнал, Пол Дирек 1933 онд Физикийн Нобелийн шагнал, Вольфган Паули 1945 онд Физикийн Нобелийн шагнал, Жон Кеклер физикч, "Хар нүх" гэсэн нэрийг анх хэрэглэсэн, Дэвид Бом Английн онолын физикч (15).

Нэг ийм тохиолдлыг бодоод үзээрэй. Та санаандгүй өгөгдөл уран зурагтай болжээ. Харин тэр зураг чинь яалт ч үгүй Пикассогийн урд нь мэдэгдэж байгаагүй бүтээл мэт санагдан Францын Луврын музейгээс лавлахаар болов. Гэтэл Луврын захирлаас "Үнэхээр Пикассогийн нийтийн өмнө урд гарч байгаагүй бүтээл болохыг батлав." гэсэн баталгаа бичиг ирлээ. Тэгвэл та тэр урлагийн бүтээлийг яах вэ? Тэр зургийг хамгаалах гэж бүх л хүч чадлаа дайчлахгүй гэж үү? Пикассогийн цэрний эхний үе болох "Пи"-г сонсоод л унтаж байсан ч бондгосхийн босож зураг байрандаа байгаа эсэхийг шалгахгүй гэж үү?

"Хүн түүний мөрөөдснөөр тийм л болох болно." гэсэн $M=VD$ томъёо нь Квантын онол ба Харьцангуйн онол гэсэн эрчин үеийн физикийн шинжлэх ухааны 2 тулгуур баганаар батлагдсан туйлын шинжлэх ухаанч арга юм.

Хэрвээ та энэ томъёоны үр нөлөө ач тусад итгэж чадахгүй байгаа бол тэр таны буруу. Бас хэрвээ энэ аргыг хэрэглэхгүй байгаа бол та өөрөө мэдэхгүй гээр бүтэлгүйтлийг чиглэн явж байна гэсэн үг шүү. Гэхдээ та яг одоо энэ томъёог хэрэглэхээр шийдсэн бол та одоо амжилтын зам дээр зогсож байгааг илэрхийлж байгаа юм шүү.

Алийг нь ч сонгож болно сонголт таны өмнө байна.

6. R=VD ИЙН ҮР ДҮН ТҮҮНИЙ ГЭРЧҮҮД

☛ Амьдралаараа гэрчилсэн ХҮМҮҮС

Хорвоо дээр хамгийн итгэхэд хэцүү зүйл бол хүний хэл яриа байдаг. Хүмүүн гэдэг хорвоо дээр худлаа ярьдаг цорын ганц оршихуй учраас юм. Нөгөө талаас нь харвал дэлхий дээр хамгийн итгэж болохоор зүйл ч бас хүний хэл яриа. Хүмүүн гэдэг хорвоо дээр амь насаараа дэнчин тавин үнэнийг ярьдаг цорын ганц оршихуй учраас тэр.

“Ямар хүний үгэнд итгэх ёстой вэ?” гэсэн асуултанд хүн тус бүр өөр өөрийнхөөрөө хэдэн мянган янзаар хариулах байх. Гэвч хорвоо дээр хэн ч байсан гэсэн дараах түвшинд хүрсэн хүний үгэнд итгэж болно гэдгийг эсэргүүцэхгүй байх.

1. Үнэнийг судлахын төлөө гялалзсан амжилтын баталгаа болсон мэргэжлээ орхисон хүн. Тэгээд үнэхээр 10 жил чин сэтгэлээсээ үнэнийг нээж түүнийгээ ямар ч харамж авалгүй хүмүүст тарааж өгөөд үхсэн хүн.
2. 40 жилийн турш 30 гаруй сая хүнээр шалгуулсны эцэст “Таны хэлсэн зөв байжээ” хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн хүн.
3. “Миний хэлсэнтэй санал нийлэхгүй байгаа хүн байвал хэзээ ч гэсэн яриарай” гээд бүх дэлхий даяар өөрийн хаяг хомпейжээ зарлаж байгаа хүн.
4. Өөрийн итгэл үнэмшлээ 30 жилийн турш хэрэгжүүлэн гайхалтай үр дүнд хүрч тэр итгэл үнэмшлээ 20 улсын сая гаруй хүнд өөрийн биеэр зааж сурган тэднээрээ дамжуулан гайхалтай үр дүнд хүрсэн хүн.

Эдгээр хүмүүс хэн байсан ба тэд юу гэж ярьж байсан юм бол?

Жеймс Аллен 1864 онд Англид төржээ. Тэрээр 1902 онд удирдлагын зөвлөхөөр тун амжилттай ажиллаж байснаа гэнэт л түүнийгээ орхин Английн өмнө хэсгийн далайн эргийн

шинэжсэн тосгонд очсон байна. Тэндээ 10 гаруй жилийн турш ямар нэгэн үнэнийг чин сэтгэлээ зориулан нээж түүнийгээ ном болгонд дэлхий дахинд мэдэгдсэн байна.

Түүний ном 10 саяаас ч олон хувь борлогдсон юм. Үүнийг шинэгийн мөнгөөр тооцох юм бол 10 сая доллар давна. Харин тэр ямар ч хөлс мөнгө аваагүй юм. Өөрийнх нь нээсэн үгэн зөвхийгээр тархахад мөнгө саад болж болно гэж бодсон учраас тэр ан

Түүнийг нас барсны дараа номыг судлах хүмүүс гарч ирсэн байна. Тэд Жеймс Аллены олж нээсэн амьдралын үнэнийг ганц л өгүүлдбэрээр товчилсон байлаа. “Хүн түүний төсөөлж байгаа зүйл л болох болно.” (16).

Максвел Мальц хэмээх Америкийн гоо сайхны мэс засалч ажилтан байна. Тэр өвчтөнүүдээ эмчлэх явцдаа нэгэн сонин үзэгдлийг ажигласан байна. Өвчтөний итгэлийг дагаад зан чанар нь тэр бүү хэл амьдрал нь хүртэл өөрчлөгдөж байжээ.

Тэр олон жилийн турш энэ үзэгдлийг судалсан байна. Тэгээд эцэст нь 60 нас хүрсэн хойноо судалгааныхаа үр дүнг нэгэнд тунхаглаж эхэлсэн байна.

“Та одоо болтол амжилтын амьдралаар амьдарч чадаагүй байгаа нь та амжилтанд итгэдэггүй учраас тэр юм. Өдөрт 30 минут итгэлийнхээ гүнд аль хэзээний амжилт олсон байгаагаар өөрийнхөө нүдэндээ харагдтал төсөөлөөд үзээрэй. Тэгвэл амьдралынхээсээ амжилтанд хүрэх болно.” гэсэн мессеж байлаа.

Энэ мессежийг одоог хүртэл 40 гаруй жилийн турш 30 гаруй сая хүн хэрэгжүүлж байна. Тэгээд Мальцийн үзэл бодлыг дагаад маш том амжилтанд хүрч түүний дагалдагч болон “Максвел Мальцийн үзлийг тараагч” болсон хүнийг төлөхийн аргагүй олон гарсан ч үр дүнг нь үзээгүй хүн ганц тараагүй юм.

Ден Кеннеди ээрч ярьдаг хүн байлаа. Нэг удаа Максвел Мальц докторын онолын тухай олж мэдсэн байна. Тэгээд өөрийнхөө амьдралдаа хэрэглэжээ. Тэр өнөөдөр өдөрт 1 удаагийн уншсан лекцийнхээ хөлсөнд 100 мянган доллар авдаг

гэнэ. Ээрч гацан ярьдаг байсан өөрийгөө түгдрэхгүй бэлэн цэцэн ярьдаг болсноор төсөөлсний үр дүн дэлхийд алдартай илтгэгч болсон байна.

Ден Кеннедийн лекцийн сэдэв нь голчлон $R=VD$ томъёо (Максвел Мальцийн дүрсэлснээр *Psycho-cybernetics*)-ны тухай юм. Түүний факс хаяг болон хомпейж нь дэлхий даяар тарсан байдаг (сонирхсон хүн “Амжилтын хууль” хэмээх номных нь 32-р хуудсыг үзээрэй). Тэгээд энэ тухай сонирхсон эсвэл эсэргүүцэж байгаа хүн байвал хэзээ ч хандаж болно гэж хэлж байна.

Жек Кэнфилд дээд сургуульд сурч байхдаа үргэлж хамгийн хямдхан лаазалсан улаан лоолийн пасттай гоймонгоор хооллодог байв. Ар гэр нь мөнгөгүй учир хамгийн доогуур түвшинд хамрагддаг бөгөөд өөрөө ч мөнгө хийх чадваргүй нэгэн байсан юм.

Дээд сургуулиа төгсөөд дан ядуусын хорооллын хар арьстнууд явдаг Чикагогийн Өмнөд хэсгийн нэг ахлах сургуульд томилогдон очив. Гэхдээ тэр амьдралаа энэ чигээр дуусгахыг хүсээгүй юм. Амжилтын эздийг судалж эхлэн, $R=VD$ -г мэддэг болж 30 жил түүнийгээ хэрэгжүүлэн амьдарч байна. Тэгээд ийм үр дүнд хүрсэн юм.

1. Дэлхийн 40 улсад 80 сая уншигчтай зохиолч болов.
2. Офра Уинпригийн шоунаас эхлээд ТВ бүрийн программын байнгын оролцогч болов.
3. Фортун сэтгүүлийн шалгаруулдаг дэлхийн 500 том группуудээс лекц унших үй түмэн урилга авдаг алдартай хүн болсон байна.

Жек Кэнфилд $R=VD$ -г хүмүүст зааж байна. Тэрээр одоог хүртэл АНУ-ын 50 муж дэлхийн 20 улсын сая хүнд тогтмол системтэйгээр $R=VD$ аргыг зааж байна. Үр дүн нь энд байна.

1. Түүний дагалдагч нараас өөрийн хүчээр саятан болсныг нь тоолж барахааргүй олон.
2. Ажиллаж байгаа компанийнхаа борлуулалтын дээд амжилтыг эвдсэн хүнийг ч тоолоод барахааргүй олон байна.

3. Жирийн ажилтнаас хамгийн шилдэг удирдагч болж чадсан хүн ч олон гарсан байна.
4. Од жүжигчин, од дуучин, од тамирчин олон гарсан.
5. Бестселлерийн зохиолчид.
6. Сонгуульд оролцож улс төрт өндөр албан тушаалд хүрсэн хүмүүс.

Нэг үгээр хэлэхэд Жек Кэнфильдээр $R=VD$ ном ёсоор нь авалгасан хүмүүс бүгд гайхамшиг гэмээр амжилтанд хүрч чадсан юм. Дээр нь нэмэхэд Жек Кэнфилдийн $R=VD$ сургалтын амжилтын жишээ нь Америкийн бүх ТВ-ээр олон удаа гарсан юм (17).

29. Зохиолчийн биеэрээ үзэж туулсан НӨЛӨӨ

Одоо зохиогчийн яриаг сонсоцгооё. Би ч гэсэн $R=VD$ аргыг хэрэглэжүүлж байгаа. Тэгээд ач тусыг нь нилээн сайн үзэж байна.

Энэ номын зохиолчийн гэрийн том өрөөнд нэг хувилагч байдаг юм. Дүү нарынхаа сургалтын төлбөрийг төлөхийн тулд ажиллаж байсан өрөөнийхөө түрээсийг ч хэцүүхэн төлдөг байх үүний өд л дээ. Тэр үед миний хувьд хамгийн хэрэгтэй зүйл тэр хувилагч байсан юм. Би ном бичихдээ маш олон материал ашигладаг. Өөрийн гэсэн хувилагчгүй байхдаа материалаа хайгчлаж юмуу эсвэл word processor ашиглаж материалаа өөрийн болгодог байлаа. Харин тэгэхэд мөнгө болон цаг маш их зарцуулагддаг байв. Өөрийн гэсэн ганц хувилагчтай байхад амархаан шийдэгдэхээр асуудал байсан.

Тэр үед миний гар дээр яг 300.000 вон байсан. Юмыг яаж мэдэхэв гээд хуучин хувилагч сонирхож үзэхэд 600-800.000 вонд үнэтэй байв. Миний бүх хөрөнгө 2 дахин орохоор үнийн дүн гэсэн үг. Итгэхэд хэцүү ч хэрвээ би тэр хэмжээний мөнгө амьт гэх юм бол 1 жил 8 сараас илүүгээр хүлээхээр байсан гэж 2 дүүгээ сургууль төгсөхөөс нааш... Ингээд надад нэг бол хувилагч авахаа болих эсвэл $R=VD$ -г хэрэглэх хоёрын аль нэгийг сонгох гэсэн 2 зам үлдсэн. Би мэдээж 2 дахь замыг

сонгосон. Ингээд манай гэрт хувилагч орж ирж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлж эхэллээ. Тэр үед би миний тархин дотор байгаа төсөөлөл цаг хугацаа орон зайг даван хувилагчийг авч ирж байгаагаар бүхий л хүч чадлаа дайчлан төсөөлж байсан юм. Бодит байдал дээр хувилагч авах чадал хүрэхгүй ч гэсэн ямар нэг аргаар хувилагчтай болох зайлшгүй шаардлагын үүднээс хийсэн үйлдэл байсан.

Гэхдээ гайхалтай нь яг 7 хоногийн дотор хувилагчтай болж чадлаа. Супер маркетаас хагас боодол ногоон сонгино автал худалдагч нь гэр ахуйн барааны реклам гардаг сэтгүүлээр сайтар боож өгсөн байлаа. Тэгээд гэртээ ирэнгүүтээ задлан сэтгүүлийг үзтэл тэнд ийм зарлал байдаг байгаа.

“Хуучин хувилагч онцгой хямдрал 340.000 вон.”

Нэг бөөний төв нүүхдээ тэр үед хэрэглэж байсан хэдэн ширхэг хувилагчаа яаралтай зарахаар болон зарлал өгсөн нь тэр байлаа. Би шууд утасдаж хувилагч тэр өдөртөө л миний өмч болсон юм. Би одоо хүртэл түүнийгээ маш сайн хэрэглэж байгаа билээ.

Өнөөдрийг хүртэл би 6 ном гаргасан. Эх нь хэвлэгдэхээр бэлтгэгдэж байгаа ном 3 байгаа. Гайхуулж байгаа биш боловч миний бичсэн ном болгон бестселлер болсон. Би утга зохиолын мэргэжлээр сургууль төгсөөгүй. 20 хүрэхээсээ өмнө бол нэг мөр ч бичиж үзээгүй хүн билээ.

Зохиолчдын оролцдог тэмцээнүүдэд оролцож үзээгүй болохоор мэдээж шагнал авч үзсэн удаа байхгүй. 20 наснаасаа эхлэн 8 жилийн турш хичээнгүйлэн шүлэг л бичиж байсан.

Гэхдээ үнэнийг хэлэхэд надад зохиол бичих ямар ч авьяас байгаагүй. Хэрвээ тийм чадвар байсан бол утга зохиолын ертөнцөд анхны гараагаа хийх байсан байх. Би Багшийн Дээд сургууль төгсөөд Хуулийн сургууль руу шилжин орж, эрдмийн ажил дуусангуут байлдагч болон цэргээс халагдмагц багш болж одоо ч бага сургуулийн багшаар ажиллаж байна. Надад юм бичихэд өөрийгөө бүрэн зориулах цаг байсангүй. Оюутан цагаа тэгж ингэж тэнэсээр өнгөрөөн, цэрэгт байхад бол генерал л биш бол хэн юм бичих вэ дээ. Багшийн ажил амархан гэж

үү? Орлоо босоод ажилдаа явах бэлтгэл хийгээд завгүй, орой 5 хүртэл сургууль дээр яс байх ёстой, тараад оройн хоол энэ тэр тусгаар нэг л мэдэхэд 9, 10 цаг болно. Бодит байдлын үүднээс харах юм бол би хэзээ ч зохиолч болж чадахааргүй хүн. Гэхдээ би зохиолч болж чадсан юм. 20 настайгаасаа эхлэн нэг өдөр ч адгасалгүй өдөрт 10 аас дээш минутаар өөрийгөө зохиолч болж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлж байсан болохоор тэр шүү дээ.

2004 онд бичсэн “Соломоны сурах арга” гэдэг ном маань Тайланд орчуулагдан гарсны дараа Тайваны Улсын Номын санд худалдагдах номын жагсаалтад орсон. Бас нэг ном хятад хэлээр орчуулагдаж байгаа ба бас нэг ном япончуудын сонирхлыг татаж байгаа болно. Энэ бүгд мэдээж $R=VD$ -г хэрэгжүүлсний үр дүн билээ. Би 4 жилийн өмнөөс эхлэн номнуудаа гадаад хэлээр орчуулагдан гарч байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлж байгаа юм.

2005-12 сард “Амжилтын эзэн хүүхдэд ирээдүйн сургалтын хөтөлбөр байдаг.” хэмээх ном хэвлүүлж Жун-Ан Набу сониноос эхлээд төрөл бүрийн сонингууд ба SBS, JET, CBS зэрэг ТВ-үүдэд ярилцлага өгөн лекц уншсан. Энэ бүхэн бүгд л би сонингууд ба ТВ-ийн логог харж болж байгаа мэтээр төсөөлсний үр дүн юм. Гайхалтай нь би нэг хоёр удаа л төсөөлөөд орхисон сонины газар юмуу ТВ-ээс над руу ярьдаггүй нь үнэн билээ.

Миний танилууд дунд өөрөөсөө 11 насаар дүү царайлаг буутан бүсгүйтэй сүй тавиад байгаа залуу байдаг юм.

Тэр бусдаас онцгой юм юу ч үгүй жирийн л нэг 30 настай эхлэн залуу билээ. 30 нас гартлаа эмэгтэйчүүдээс хөндий авсан тэрээр нэг удаа надаас яавал зохиолч болж болохыг асууж байсан юм. Би түүнд $R=VD$ томъёог танилцуулав. Тэгтэл тэд хоногийн дараа үнэхээр нухацтайгаар ингэж асуулаа. Тэр томъёо чинь эмэгтэй хүнтэй танилцахад нөлөөлж чадах уу гэж. Би “Мэдээжийн хэрэг” гэж хариулсан.

Тэгээд тэр томоор мөрөөдөхөөр шийдлээ. Учрахыг хүсэж байгаа эмэгтэйгээ ийм ийм байгаасай гээд бичиж гарчээ. Анх харсан хэний ч нүдэнд тусахаар тийм эмэгтэй, ямар нэгэн

нөхцлөөр эр хүнийг сонгохооргүй нас болох хорь дөнгөж гарсан байх, удирдлагын чиглэлээр суралцдаг байх, анх танилцахаас эхлээд хуримын тухай яригдаж эхэлтэл аар саар асуудал үүсгэхгүй эмэгтэй, насны зөрүүнээс болон гэрийнхэн нь эсэргүүцсэн ч зоригтойгоор даван туулж чаддаг байх гэх мэт.

Тэр энэ нөхцлүүдээ урдаа тавиад тогтмол төсөөлж эхэлсэн байна. Өөрийн мөрөөдлийн эмэгтэйтэйгээ хувь тавилангаар учирч анх уулзсан мөчөөс эхлээд тэр бүсгүй түүнд сайн болж байгаагаар... Тэгээд залуу өөрөө эмэгтэйн гал халуун хайрыг удирдах гэж хичээж байгаагаар... Бас тэр компьютертоо “Ирээдүйн хайрын өдрийн тэмдэглэл” гэдэг файл бий болгож түүндээ өөрийн нүдэндээ харагдтал төсөөлж байгаа бүхнээ нэгд нэгэнгүй тэмдэглэж байв.

Жил ч болоогүй байхад түүний VD нь R боллоо. Тэр бүсгүйтэйгээ Cyworld клубын Off-line цуглаан дээр анх таарч, мэддэг болоод сар ч болоогүй байхад түүнээс хоол авч өг гэсэн мессеж ирж, түүнээс цааших нь мэддэг түүх шүү дээ.

Миний биеэрээ мэдэрсэн R=VD аргын үр дүнг дүгнэвэл ийм байна.

1. Нүдэндээ харагдтал төсөөлвөл үнэхээр тийм болдог. Хувилагчтай болсон болон зохиолч болж чадсан зэрэг бол гол жишээнүүд билээ.
2. Нүдэндээ харагдтал төсөөлсний дараа чин сэтгэлээсээ хүсэх хүсэл дутах эсвэл дунд нь орхих юм бол бодиттой болохгүй. Би хувилагчтай болсныхоо дараа эдийн засгийн хувьд авч чадахааргүй олон зүйлстэй болох гэж нүдэндээ харагдтал төсөөлж байсан. Гэхдээ миний хувьд тийм гол хэрэгцээтэй зүйлс биш байлаа. Байвал сайн л хэрэг гэхдээ байхгүй байсан ч болохоор л зүйлс байв. Тийм болохоор бүх сэтгэлээ дайчилж чадахгүй байсан ба томъёог хүчээр хэрэгжүүлэх гэж оролдож сүүлдээ залхаад болихоор шийдсэн. Эцсийн эцэст би тэр зүйлсүүдээ авч чадаагүй.

Миний танилууд ч бас тийм дүгнэлтэд хүрсэн байсан.

Түрүүн гарсан жишээний эзэн танилын маань хувьд
дундагийн бүсгүйгээ бүх чин сэтгэлээсээ нүдэндээ харагдтал
төгсөж байсан. Тэгээд тийм бүсгүйтэйгээ ч учирч чадсан.
Тэгдээ тэр үед ганц тэр залуу ч биш өөр олон танилууд маань
миний яриаг сонсож байлаа. Бүгд л хөөрхийлөлтэй ганц бие
залуус байсан. Тэд ч бас $R=VD$ томъёог хэрэгжүүлж эхэлсэн ч
бүгд л замын дундаас больсон. Шалтгаан нь нь янз бүр байлаа.
Маавид ингэж байж найз охинтой болох хэрэг байна уу, ямар
насан нашины үйл шиг юмаа, цаг алга гэх мэт. Харамсалтай
нь тэд одоо ч ганц бие л байгаа. Одоо ч гэсэн хүнтэй танилцах
болвоо энэ тэрд идэвхийлэн явж байгаа ч сэтгэлдээ таарсан
бүсгүйгээ олж чадаагүй л байгаа билээ.



7. БИДНИЙ ТАРХИ Ч МӨРӨӨДӨГ

Эсийг идэвхжүүлэгч систем RAS

Таны тархины гүнээс гүнд эд эсийг идэвхжүүлэгч систем буюу RAS, Reticular Activating System гэдэг нэгэн байдаг. RAS анхаарал төвлөрүүлэлтийг удирддаг мэдрэл дамжуулагч гормон болох допамин (dopamine) ба норэпинпрайн (norepinephrine)-ыг ялгаруулж тархиар дамжуулан сурах, өөрийгөө удирдах, шийдвэр гаргах зэрэг гол үйлдлүүдийг хийдэг. RAS өөрийн үүргээ гүйцэтгэж чадахаа больвол юу болох вэ? Сэтгэцийн саатал өвчний нэг болох ADHD буюу Attention Deficit Hyperactivity Disorder. Энэ нь өсвөр насныханд их тохиолддог бөгөөд анхаарал нь төвлөрдөггүй, тайван нэг байрандаа сууж чаддаггүй ийм өвчин тусах болно.

Нэг талаас харахад RAS онцгой үүрэг гүйцэтгэдэг. 1 секунд 100 орчим сая удаа цохилж байгаа мэдрэлийн пульсыг асар хурднаар ялгаж чухалыг нь хадгалан хэрэггүйг нь устгана. Ингэж RAS тархин дахь мэдээлэл замбараагүйтэх болон илүүдэл бий болох явцыг хааж тархийг чухал мэдээлэл дээр анхаарах боломжийг хангаж өгдөг.

Тархи судлаачдын үзэж байгаагаар хүн төрөлхтөний RAS сөрөг тал руугаа хувирч ирсэн байна. Тэгээд тэр нь хүн төрөлхтөн хүй нэгдлийн үеэс, эхлээд, араатан амьтан ба байгалийн гамшигаас, соёл иргэншил эхэлсэн цагаас эхлэн тасралтгүй шахам явагдах дайнаас (*хүн төрөлхтөний түүхийг 100 гэж үзэх юм бол дайнгүй байсан хугацаа нь дөнгөж 8-аас илүүгүй байсан байна.*) болон амь нас нь үргэлж аюулын дор байсан учраас үр дүнд нь хүний тархи гол тусгалыг зөвхөн амьдралын төлөөх тэмцэл дээр тавьж байсан байна.

Аюултай газар нутагт амьдрахын тулд туйлын “сэжиг” ч ба “хартай” байх хэрэгтэй. Энд тэндээс өчүүхэн чимээ сонссон ч эхлээд догшин араатан биш байгаа гэж сэжиглэх ёстой бөгөөд танихгүй хүн яасан ч гэсэн дайсанд тооцогдохоос өөр аргагүй байдаг байсан. Сонор сэрэмжээ алдах юмуу, хүнд итгэх

боломжгүй. Тэгвэл араатны идэш болно эсвэл довтолгоонд ордог байв.

Хүй нэгдлийн үед юмуу дайны үед ингэж амьдрах нь зохистой байсан юм. Харин одоо цагт бол өөр. RAS маань эерэг мэдээлэл дээр фокусаа тааруулснаар амьд үлдэх боломжтой бас хөгжин дэвжиж чадна. Жишээ нь үйлчлүүлэгчээ дайсан гэж үздэг компани байна гээд бодоод үз. Ийм компанид оршин тогтнох боломж байх уу? Өнөө үед санаатайгаар хохирлын төлбөр нэхэж байгаа үйлчлүүлэгчийг ч гэсэн хүндэтгэн сэтгэлд нь хүртэл үйлчлэх хэрэгтэй болсон цаг үе. Бас ийм сэтгэлээр нэгдэж байгаа компани л амьдарч хөгжин дэвжиж байна. Бид RAS-ийн гол фокусыг “итгэл” ба “эерэг” дээр тааруулсан бүлэг болон хувь хүмүүс л амьд үлдэх боломжтой цаг үед амьдарч байна.

Даанч харамсалтай нь бидний ихэнх нь хүй нэгдлийн үеийн RAS тайгаа байсаар байгаа. Жишээ нь биднийг байгууллагын дарга ямар ч шалтгаангүйгээр дуудлаа гэхэд “Яана аа би буруу юм хийсэн юм биш байгаа” гэж эхэлж бодно уу гэхээс “Намайг магтах байх. Эсвэл надад сайхан ажил санал болгох байх” хэмээн эерэг талаар нь бодох тохиолдол бараг л үгүй.

Хүний уураг тархи судлаачид, сэтгэл зүйчид болон өөрийгөө нээх хөгжүүлэх салбарын мэргэжилтнүүд ингэж хэлж байна. “RAS ын гол фокусаа сөрөг мэдээлэл дээр тааруулсан хүн амжилт олох нь бүү хэл амьд үлдэхэд ч хэцүү шүү.” гэж. Хэрвээ энэ амьдарч байгаа цаг үедээ амжилт олохыг хүсэж байгаа бол бодит байдал ба төсөөллийг ялгаж чаддаггүй уураг тархиныхаа онцлогыг ашиглан RAS-ыг эерэг мэдээлэлд гол фокусыг тааруулах систем рүү өөрчлөн явцгаая.

☞ Эсийг идэвхжүүлэгч систем ба $R=VD$

RAS-ийг өөрчлөхийн тулд эхлээд төсөөлөл ба бодит байдлыг ялгаж чаддаггүй уураг тархины онцлогыг зөв ойлгох хэрэгтэй юм.

Та амандаа дөнгөж сая зүссэн нимбэг нэг зүсмийг хийлээ гээд төсөөлөөд үздээ. Тэгээд түүнийгээ хазан шүүсийг нь

сорж байна гээд бас... Эрүүл хүн бол амаар дүүрэн шүлс ялгарна. Яагаад тэр вэ? Төсөөлөл бодит байдлын алийг ялгаж чадахгүй байгаа тархи жинхэнээсээ исгэлэн амт мэдэрч шүлс ялгаруулах тушаал авсан учраас тэр.

Хүний тархи бодит байдлыг ялгаж чаддаггүйг ил тод харуулсан бас нэг жишээ бол гипноз. Хүнийг гипнозонд оруулсны дараа мөсөн унжлага биенд нь хүргээд улайстлаа халсан хадаас шүү гэж хэлэхэд биенд нь хүрсэн хэсэгт цэврүү үүсдэг. Тархи гипнозонд байгаа үеийн төсөөллийг бодит байдлаар хүлээн авч, арьсыг түлэгдлээс хамгаалахын тулд цэврүү үүсгэх тушаал авч байгаа болохоор тэр юм.

Multy plepersonalty буюу нэг хүн 2 ба түүнээс дээш хүний ааш араншинтай байх нэг төрлийн мэдрэлийн гажиг өвчин байдаг бөгөөд тийм хүмүүс тархины, төсөөлөл ба бодит байдлыг ялгаж чадахгүй байгааг тодоор харуулдаг юм. Сэтгэхүйн хувьд ийм өвчтэй мөртлөө бие махбодь нь эрүүл эмэгтэй өвчтөнд өөрийг нь чихрийн шижин өвчтэй эрэгтэй хүн гэж итгүүлэх юм бол юу болно гээч? Дуу хоолой үйл хөдлөл нь эрэгтэй хүн шиг болон хувирч эрүүл гарч байсан цусны шинжилгээ нь шижин өвчтэй хүнийх болон гарах болно. Энэ бол бас л тархи төсөөллийг бодит байдлаар хүлээн авч байгаагаас үүсч байгаа байдал юм.

Уураг тархины энэ онцлогыг ашиглан та тогтмол 30 мин гаргаад амжилт олж байгаа өөрийнхөө төрхийг төсөөлвөл яаж байна? Тархи чинь таныг жинхэнээсээ амжилт олж байгаа гэж итгэх болно.

Энэ байдлыг тань RAS “амжилт”-тай холбогдох чухал мэдээлэл гэж үзэн өөрлүүгээ илгээх тушаал буулгаж болно. Тэгээд “бүтэлгүйтэл”-тэй холбоотой бүх мэдээллийг орж ирэнгүүт устгахыг тушаана. Амжилтын тухай мэдээллүүд гэж юу вэ? Өөртөө итгэх итгэл, бишрүүлэн дагуулах увидаc, ажил хэрэг болгох чадвар, үйлдэх чадвар, шийдвэр гаргах чадвар, удирдах чадвар гэх мэт... Хэрвээ та тасралтгүйгээр $R=VD$ хийх юм бол удирдагчийн сэтгэлгээ болон үйлдэх чадвар танд өөрөө л бий болох болно.

Харвардын их сургуулиас хийсэн судалгааны үр дүн VD нь өсийг идэвхжүүлэх системийг яаж үр ашигтайгаар ажиллуулж болохыг тодорхой харуулж өгсөн байдаг. Судалгааны багынхан ил жил түвшний мэдлэгтэй хүмүүсийг 2 хэсэгт хуваан дараах даалгаврыг өгсөн байна.

А хэсэг: Даалгаврыг амжилттай дуусгаж байгаагаар өөрийгөө төсөөлсний дараа даалгавраа гүйцэтгэнэ.

Б хэсэг: Зүгээр даалгавраа хийнэ.

Хариу ямар байсан бол?

А хэсгийн даалгаврын биелэлт 100% зөв байсан бол, Б хэсгийнх 55% аас хэтрэхгүй байсан байна.

Ингэхэд та ямар хцн бэ?

Байгууллагаас өгөгдсөн ажлыг ч ёсоор хийж чадахгүй сандарч мэгддэг хүн юм биш биз? Тэгвэл өнөөдрөөс эхлээд тогтмол цаг гарган компаниа гартаа оруулж байгаагаар өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлөөд үздээ. Тэгвэл RAS таны уураг тархины гол фокусыг удирдах болон ажил үүрэг гүйцэтгэх онцгой чадварт тааруулж, та өөрөө ч мэдэлгүй бишрүүлэн дагуулах чадвартай удирдагч болохоор олз руугаа дайрч буй арслан мэт нэгэн болон хувирсан байх болно.

Таны мөрөөдөл юу вэ?

Магадгүй хэдхэн жилийн дотор 1 тэрбумаар тоологдох хөрөнгөтэй болчихоод буяны үйл хийхийг хүсэж байна уу? Тэгвэл одооноос эхлээд тогтмол цаг гарган 1 тэрбумыг буяны үйлсэд зориулж байгаагаар өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлөөрэй.

Тэгвэл RAS таны тархины фокусыг 1 тэрбум болон буяны үйлсэд тохируулан, танд 1 тэрбумыг олох боломж (RAS идэвхжүүлэхээс өмнө яг хамрын дор байхад ч олж харахгүй өнгөрөөж байсан)-ийг барьж авах болно. Буяны үйлс хийх чадвар ч мөн адил. Та буяны үйлс 1 тэрбумын хөрөнгө оруулалт хийх зориг болон шийдвэр гаргах чадвартай болох болно.

Сэтгэлийг нь татахыг хэсч байгаа хүн байгаа юу?

Тогтмол тусгай цаг гарган 2 нүдээ аниад түүнийхээ сэтгэлийг эзэмдэж байгаагаар өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Тэгвэл RAS идэвхжиж тэр хүн чинь таныг харангуутаа танд л татагдахаар тийм сэтгэл татам зан чанар төрх байдлууд илрэн гарч эхлэнэ. Нэг их удахгүй л тэр хүн чинь таныг чин сэтгэлээсээ хүсэмжлэх болно (18).

☛ Ирээдүйн санамж ба $R=VD$

Жорж Вашингтоны их сургуулийн Анагаах ухааны их сургуулийн Мэдрэлийн факультетын профессор, National Geographic-ийн зөвлөх доктор Ричард Лестек уураг тархины тухай 12 боть ном бичсэн энэ салбартаа тэргүүлэгч мэргэжилтэн юм.

Түүний үзэж байгаагаар frontal lobe (духны голын ховилын өмнөд хэсэг) ирээдүйн санамж (future Memory)-ийг хариуцсан хэсэг байдаг аж. Энэ хэсэг яг уг нэрнийхээ утгаар тархиар ирээдүйг сануулах үүргийг гүйцэтгэдэг байна (19).

Өнгөрснийг биш ирээдүйг санана гэхээр энэ чинь юу гэсэн үг билээ гэж бодож магадгүй юм. Тэгэхээр Эйнштейн болон Стивен Хавкинг нарын зэрэг физикчдийн үзэж байгаагаар цаг хугацаа нь зөвхөн ирээдүй рүү урсдаг биш.

Цаг хугацаа өнгөрсөн рүү ч хичнээн бол хичнээн урсаж болох гэнэ.

Орчин үеийн шинжлэх ухааны нээснээр бид тархиныхаа чадварын 10%-ийг л ашигладаг байна. Үлдсэн 90%-д нь далд ухамсар гэсэн аятайхан нэр өгчихөөд гар хүрч чадахгүй байж байгаа билээ. Тархи судлал ба физикийн шинжлэх ухааны нээснээр бол таны тэр далд ухамсар л таны ирээдүйг мэдэж байгаа. Тэгээд тэр ирээдүйг санамж болгон сэргээж Frontale lobe хадгалдаг байна.

Амжилтын салбарт үүнийг “амжилтыг чиглэн бууж ирж байна” гэж томъёолдог.

Амжилтыг туйлаас их хүсэх нь ирээдүйн санамжаар дамжин аль эрт амжилт олсон өөрийнхөө төрхийг харсан учраас бий болдог аж. Ирээдүйн аль нэг цагт амжилт олж байгаа хүн л одоо цагт амжилтын мөрөөдөлтэй байж чадна. Үүнээс үүдээд амжилт өөд өгсөж байна гэж ярих нь тохироогүй дүрслэл юм. Нэг талаас өгсөх гэдэг нь “бүх хүчээ шавхах “чармайх” зэрэг санаа агуулж байгаа гэтэл энэ нь аль эрт батлагдсан үнэн гэдгийг мэдэж байгаа хүн хийх үйлдэл биш учраас тэр. Амжилт нь баталгаатай гэдгийг мэдэж байгаа хүн өдөр хоногийг чармайсаар өнгөрөөхгүй. Харин ч аль болох намар тайван аз жаргалтайгаар өнгөрөөнө шүү дээ. Өөрийгөө амжилтанд хүрнэ гэдгийг эргэж буцахааргүй үнэн гэдгийг маш сайн мэдэж байгаа учраас. Тэгэхээр “амжилт өөд авирах эсвэл өгсөх” гэсэн үгний оронд “Амжилтаа чиглэн уруудаж байна” гэж бичих нь зөв санагдаж байна.

“Боломжгүй зүйл гэж үгүй” хэмээх номоороо өөрийгөө хөгжүүлэх нээх салбарт мөхөшгүй алдар сууг олсон доктор Роберт Шуллер энэ үнэнд тулгуурлан амжилт олох мөрөөдөлтэй мөртлөө хөдөлж чадахгүй эргэлзээд байгаа хүмүүст хандан ийм асуулт тавьдгаараа нэрд гарсан юм.

“Хэрвээ та амжилт олно гэдгээ баттай мэдэж байгаа юм бол одоо юу хийгээд байгаа юм бэ?” (20)

Ирээдүйн санамж бодит болохын тулд тэр ирээдүйн санамжийг хариуцаж байгаа тархины хэсэг идэвхжих ёстой. Энэ хэсэг идэвхжих юм бол дараах зүйлүүд болно.

1. Уураг тархи ирээдүйн санамжийг жинхэнэ бодит байдлаар хүлээн авна.
2. Тархи ирээдүйн санамж ба жинхэнэ бодит байдлын хооронд зай завсар байгааг мэдэрнэ.
3. Тархи ирээдүйн санамж ба жинхэнэ бодит байдлын хоорондох завсрыг засвар хийх шаардлагатай алдаа гэж хүлээн авна.
4. Тархи алдааг засахын тулд далд ухамсарын хүчийг ашиглаж эхэлнэ.

5. Тархины эзэнд ирээдүйн санамжийг бодит байдал болгож чадах чадвар бий болгож эхэлнэ. Шавхагдашгүй сэтгэлийн тэнхээ, онцгой мэргэн ухаан зэрэг дотоод чадвар.
6. Ирээдүйн санамж ба жинхэнэ бодит байдал хоёрын хоорондын завсар аажмаар багасна.
7. Ирээдүйн санамж нь жинхэнэ бодит байдал болно.

Ирээдүйн санамжийг идэвхжүүлэх цорын ганц арга бол $R=VD$ -г хэрэгжүүлэх юм. Энэ бол доктор Ричард Лестек, доктор Даниел Ж.Иемэн, доктор Харуяма Сикэу нарын зэрэг дэлхийд нэртэй тархи судлаач эрдэмтдийн нийтлэг санаа юм.

Бид бүгдийн сэтгэл дотор дуурайхыг хүсэж байгаа хүний дүр төрх байж л байдаг. Хэрвээ байнга л тэр хүнийгээ нүдэндээ харагдтал төсөөлвөл тархинд юу болох бол? Frontale lobe ирээдүйн санамжийг хариуцдаг хэсэг хүчтэйгээр идэвхжиж мөрөөдлийн цахилгаан дохиогоор далд ухамсрын ертөнцийг цочроон харвана. “Саяын миний илгээсэн цахилгаан дохионд чиний эзний жинхэнэ дүр төрх орсон байгаа учир хурдхан түүнийг биелүүлээрэй.” гээд л. Тэгвэл далд ухамсар чинь сэрэн хөдөлж эхэлнэ. Ийм процесс байнга давтагдвал юу болох бол? Өөрөө ч мэдээгүй байхдаа мөрөөдлөө жинхэнэ бодит болгож чадах чадвартай болсон байх болно.

Харин юу ч мөрөөдөхгүй байвал ирээдүйн санамжийг хариуцдаг хэсэг зогсолтын байдалд орж энэ нь ч бас дохио болон хувирч далд ухамсар руу илгээгдэнэ. “Чиний эзэнд онцын шаардлагатай юм нэг их байхгүй учир өнөөг хүртэл байсан чигээрээ унтаад байж бай.” гэсэн... Ийм байдал байнга давтагдвал юу болох вэ? Энгийн бөгөөд жирийн амьдрал.

Та өөрийгөө нэг эргээд хардаа. Яг одоо та далд ухамсартаа ямар дохио илгээж байна вэ?

Vivid



Part

02

Мөрөөдөл биелүүлж өгдөг
үг шигдийн захиалга.

Ихэнх хүмүүс сайн сурт шалгалт дүр дээр хамгийн өндөр
дүн авахыг хүсдэг мөртлөө жилхэнэ амьдрал дээр тэнэг
юм шиг алдаа хийх нь олон байдаг. Хичээлдээ санаа зовж,
шалгалтанд унах вий гэж айдаг. Хичээл чнэхээр сонирхолтой
утраас түүнээсээ сэтгэлийн таашаал аван сайхан байгаагаар
хүчлээд ч төсөөлж гадгаггүй мөртлөө хичээлээсээ долоод зовж
шаналж байгаагаар өөрийгөө хялбархаан зурж орхидог.
Сургуульдаа 1-р байр, улсад 1-р байр, компанидаа
хамгийн шилдэг байгаагаар яагаад ч төсөөлж гадгаггүй
мөртлөө жирийн чнэлвээ авч байгаагаар бол амархан
гээгч нь төсөөлчихдөг. Өөрийн мөрөөдлийг сүйтгэж байгаа
VD-г дайнаа цаг мөч дүр санаандгүй хийж байгаа гэсэн үг юм.

Realization

1. БОДОЛ ЭД ХӨРӨНГИЙГ ДУУДДАГ

☛ Ямар баяныг Зөвлөгчөө болгох вэ?

Ийм тохиолдлыг бодоод үздээ. Танай гэр бүлийнхний хэн нэг нь хүнд өвчин тусчээ. Тэгээд танд доорхи 4 хүний аль нэгийг сонгох боломж олдов.

1. Хотдоо хамгийн сайн эмч.
2. Аймагтаа хамгийн шилдэг эмч.
3. Солонгосын хамгийн шилдэг эмч.
4. Дэлхийн тэргүүн мэргэжилтэн эмч.

Та энэ дөрвийн хэнийг сонгох вэ?

Энд бас нэг ийм тохиолдлыг бодоод үзье. Танд бас нэгэн сонгох эрх олдов. Энэ удаа 2 эмчээс хэн нэгнийг нь сонгох боломж. Хоёулаа дэлхийн хамгийн шилдэг эмч шүү. Эхний эмч нь мэс заслын машин л гэсэн үг. Чадварлаг боловч хайрлах сэтгэлгүй хүн. Мөнгөгүй өвчтнийг тоож ч харахгүй. Тэр зөвхөн төлбөрийн чадвартай өвчтнийг л эмчилдэг.

Харин дараагийнх нь эмч гэгээнтэн л шиг хүн. Түүнд чадвар ч бий, хайр ч байна. Мөнгийг нэг их сонирхохгүй. Ядуу хүнийг үнэгүй эмчлээд дээрээс нь амьжиргааны мөнгө хүртэл нэмж өгнө. Түүнийг 21-р зууны Швайцер гэж нэрлэдэг.

Та энэ 2-ын хэнд нь гэр бүлээ даатгах вэ?

За, тэгвэл үүнийг баян хүнээр солиод бодоцгооё. Танай гэр бүлийнхний нэг нь баян болохыг хүсэж, харин та түүнийг доорхи 4 хүний нэгтэй танилцуулах ёстой. Та хэнтэй нь танилцуулах вэ?

1. Хотын тэргүүн баян.
2. Аймагтаа тэргүүн баян.
3. Солонгосын толгой баян.
4. Дэлхийн хамгийн баян.

Магадгүй хэн ч байсан гэсэн дэлхийн хамгийн баян хүнтэй л танилцуулах байх.

За, тэгвэл энэ удаа бас нэг тохиолдлыг авч үзье. Та гэр бүлийнхэндээ дэлхийн хамгийн баян 2 хүний нэгийг багшаар танилцуулах боломжтой байна. Хоёулаа л дэлхийд хамгийн их эд хөрөнгийг хураах аргыг мэдэж байгаа. Эхний хүн бол мөнгөний машин шиг хүн. Тэр зөвхөн өөрийнхөө л төлөө мөнгө хийдэг. Тэгээд зөвхөн өөрийнхөө төлөө л мөнгөө зарцуулдаг.

Харин 2 дахь хүн нь эд хөрөнгийг урлагийн бүтээл мэт нандин зүйл болгон хувиргадаг хүн юм. Тэр бусдыг аз жаргалтай болгохын тулд мөнгө хийдэг. Тэгээд хүмүүсийн төлөө мөнгөө зарцуулна. Тэр бол дэлхийн хамгийн шилдэг ивээн тэтгэгч бөгөөд хувь тараагч юм.

Та энэ хоёрын хэнтэй нь гэрийнхнийгээ танилцуулах вэ?

☛ Санаа зовохгүйгээр танилцуулж болохоор ЭД ХӨРӨНГӨНИЙ ЗӨВЛӨГЧ

Дэлхий баячуудаар дүүрэн. Бас тэдний ярьдаг баян болох арга ч өчнөөн олон. Энэ номыг уншиж байгаа та ч гэсэн баян болгох аргыг бичсэн ном нэгийн зэргийг уншсан л байгаа.

Харин харамсалтай нь тэр “баян болгох арга”-д гарч байгаа 1 тэрбум гэсэн мөнгө нь жинхэнэ баячуудын ертөнцийнхний хувьд бол ядууд тооцогдохоор мөнгөний хэмжээ юм. Жинхэнэ баян болохыг хүсэж байвал тэргүүн баяны ярьж байгаа баяжих аргыг сурах ёстой. Дөнгөж 1 тэрбум, 10 тэрбумтай баяны яриаг сонсож болохгүй. Триллион хэмжээний хөрөнгө хураасан баячуудын яриаг сонсох хэрэгтэй. Дэлхийн хамгийн тэргүүн баячуудын мөнгө хийсэн аргыг сурах ёстой шүү.

Дэлхийн толгой баячуудын аргыг дуурайж байж л жинхэнэ том баян болж чадна. 1 тэрбум 10 тэрбумын эздийг дуурайх юм бол сайн л бол 100 сая юмуу 200–300 саяас хэтрэхгүй гэсэн үг юм шүү.

Гэтэл хичнээн баян байлаа ч гэсэн тэр хүн сэтгэл нь ядуу байж магад. Тэр хүн мөнгөний боол байж ч болох юм. Хэрвээ тийм бол тэр ядуугаас ялгаагүй.

Ингээд дүгнээд үзэх юм бол жинхэнэ баян болох аргыг зөвхөн ийм хүнээс суралцах хэрэгтэй.

1. Сохор зоос ч үгүй эхлээд дэлхийн хамгийн баян болж чадсан хүн.
2. Мөнгөнөөс илүү хүнийг дээдэлдэг хүн.
3. Ойр хавьдаа байгаа жирийн хүмүүст баяжих аргыг зааж тэрбумтан төрүүлсэн туршлагатай хүн.
4. Өөрийн хөрөнгийг эргэлзэхгүйгээр эргүүлэн хүмүүст өгөөд явсан хүн.

Тэгвэл ийм хүн байдаг билүү? Манай Солонгост ган төмрийн хаан гэж алдаршсан, дэлхийд буяны өглөгийн хаан гэгддэг Эндрю Карнеги яг ийм хүн байсан юм. Нэг үгээр хэлэхэд Эндрю Карнегийн хэлж байгаа баян болох аргад найдаж итгэж болно гэсэн үг.

Эндрю Карнеги хүн төрөлхтөний түүхийн хуруу дарам цөөхөн хэдхэн баяны нэг байв. Харин түүний амьдралын эхлэл нь тун ядруухан байсан юм. Анх нэхмэлийн үйлдвэрт ажиллаж эхэлсэн гэдэг. Долоо хоногт 1 доллар 20 центийн цалинтайгаар бүтэн өдөржин модон ээрүүл барин утас угаадаг байжээ. Үнэхээр хүнд ажил байсан учир шөнө унтаж байгаад үе үе муухай орилон хар дардаг байсан гэдэг. Харин тэр зовлонгоос салах арга ганц л байлаа. Өөрөө баян болох. Тэгээд Карнеги эрчимтэйгээр эд хөрөнгө мөрөөдөх болсон байна.

Хэн бүхний мэдэж байгаагаар Америк нь Англиас эхлэлтэй амжилт судлал цэцэглэсэн улс билээ. Өнөөдөр болон Карнегийн амьдарч байх үед тэр хүсэх л юм бол Америкчуудын хэн нь ч гэсэн амжилттай холбоотой ном хэвлэлтэй чөлөөтэй танилцаж болохоор байсан юм. Харин залуу Карнеги номонд дуртай байлаа. Тэр хүнд үйлдвэрийн ажлын хажуугаар тогтмол цаг гарган ном уншдаг, үйлдвэр амарсан өдөр бол өглөө босоод л номын сан руу гүйдэг байв. Амжилтын тухай бичсэн бүх л номон дээр R=VD аргын тухай бичсэн байдаг байсан.

Амжилтын номны байнгын гал халуун уншигч хүү мэдээжээр номноос л $R=VD$ аргын тухай олж мэдсэн юм.

Эндрю Карнеги амжилтын номнуудаас олж сурсан $R=VD$ аргаа зөвхөн түүний өвөрмөц стил болсон хожмын өдөр "Мөрөөдөлдөө хүрэх 6 зарчим" гэсэн нэрээр дэлхий дахинд тараасан юм. Түүний гар хүрсэн салбар бүр амжилтанд хүрч үр дүнд нь асар их хөрөнгө хурааж чадсан. Гэхдээ тэр "Баян чигээрээ үхнэ гэдэг хамгийн том гутамшиг" гээд нас барахынхаа өмнөхөн хөрөнгөнийхөө ихэнх хувийг сүм болон буяны байгууллагуудад хандивласан байна (21).

Ингээд дүгнэхэд Эндрю Карнеги шиг хүнийг бол бид өөрсдийн эд баялгийн зөвлөгчөөр эргэлзэхгүйгээр танилцуулж болох юм.

❖ Эндрю Карнегийн ЭД БАЯЛГИЙН ЗӨВЛӨХ

Эндрю Карнегийн нээсэн "Мөрөөдөлдөө хүрэх 6 зарчим"-ыг танилцуулъя.

1. Хүсч байгаа мөнгөнийхөө хэмжээг тодорхойлно.
2. Тийм мөнгөтэй болохын тулд юу хийхээ шийднэ.
3. Тэр мөнгө миний гарт орох өдрийг яг тодорхойлно.
4. Тийм мөнгө хийх төлөвлөгөө боловсруулж шууд хэрэгжүүлж эхэлнэ.
5. Дээр бичсэн 4 аргыг цаасан дээр буулгана.
6. Цаасан дээр бичсэнээ тогтмол 2 удаа өглөө босохдоо орой унтахдаа чанга дуугаар уншина.

Хамгийн чухал зүйл бол хүсэж байгаа мөнгөө, тэр тогтоосон өдрөө та гартаа авсан байгаа өөрийнхөө төрхийг нүдэндээ харагдтал төсөөлөх ажил юм.

Жаахан хачин санагдаж байж магад л даа. Би ч анхандаа багагүй сандарч байсан.

Яг л “Заан олоод хөргөгчиндөө чихэх арга” мэт.

- | | |
|--------------------------------------|--------------------------------------|
| 1. Заан хайж олно. | 1. Хүсэж байгаа мөнгөний тоог бичнэ. |
| 2. Хөргөгчнийхөө хаалгыг онгойлгоно. | 2. Мөнгөтэй болох өдрөө бичнэ. |
| 3. Заанаа хийнэ. | 3. Чанга дуугаар уншина. |
| 4. Хөргөгчний хаалгыг хаана. | 4. Мөнгөтэй болно. |

Ингэснээр баяжчихдаг бол бүгд л баян болсон байх ёстой биш үү гэж егөөдөж байсан маань санагдаж байх юм. Тэгэхэд дөнгөж 20 настай анх энэ аргатай танилцаж байсан үе билээ.

Эндрю Карнегийн үеийн хүмүүс ч гэсэн надтай адилхан бодолтой байсан юм шиг байгаа юм. Карнеги ядуугийн зовлонгоос болж тамаа цайж байгаа хүмүүс баяжвал сайн юмсан гэсэн сайхан сэтгэлээр өөрийн зохиосон баяжих аргыг дэлхий дахинд зарласан ч хүмүүс түүнийг нь үл тоомсорлон дооглож итгээгүй юм. Хорь орчим хүнээс бусад нь шүү.

Голдуу хамаатан садангууд болох тэдгээр хүмүүс харин түүний дүрмийг чин сэтгэлээсээ хүлээн авсан байна. Тэгэхээс ч өөр арга байгаагүй. Тэд Карнеги энэ дүрмээ 1 өдөр ч алгасалгүй хэрэгжүүлснээр дэлхийн тэргүүн баян болж байгааг хажуугаас нь нүд салгалгүй харж байсан учраас тэр. Тэгээд өөрсдөө ч гэсэн Карнегийн дүрмийг амьдрал дээр хэрэгжүүлж тэрбумтнууд болцгоосон билээ.

☛ Сэтгэлгээ ЭД ХӨРӨНГИЙГ ДУУДДАГ.

Эндрю Карнеги юмыг хойш нь тавина гэдгийг мэддэггүй хүн байсан юм. Тэгээд объектив аргаар хүмүүсийг ятгахаар шийдсэн. Ингээд Наполеон Хилл гэдэг сонин сурвалжлагчийг урин уулзаад ийм санал тавьсан байна.

“Таны амьдрал амьжиргааг би даая. Оронд нь та өөрийн хцээр хөрөнгөтэй болсон бүх хцмцэс болгон миний хэрэгжүүлсэн нийтлэг аргыг ашиглан амжилтанд хүрч

баяжсан гэдэг үнэнийг баталж өгөөрэй. Цаг хугацаа, хөрөнгө мөнгөнд санаа зовохгүй байж болно.”

Наполеон Хилл тэр саналыг хүлээн авлаа. Энэ шийдэмгий хатуу сурвалжлагч АНУ-ын өөрийн хүчээр амжилтанд хүрсэн хүмүүст тулгуурлан 20 гаруй жил судалгаа хийсэн байна. Тэгээд тэр судалгааныхаа үр дүнг гарган зарлав. Тэндээс зөвхөн баяжих аргын тухай хэсгийг нь энд бичье. Наполеон Хилл ингэж дүгнэсэн байна.

“Сэтгэлгээ гэдэг нь нэг төрлийн бодит биет юм. Хүчний сэтгэлгээ эд баялгийг дууддаг.” (22)

Ингээд Наполеон Хиллийн судалгаан дээр үндэслэн объектив баталгаа олж авсан Эндрю Карнегийн баяжих арга олны хүртээл болмогцоо л бүх Америк даяар дэлбэрэх мэт түгэн тарж тоолж барахааргүй олон тэрбумтан төрсөн юм.

Энэ амжилтын онол нь өнөөдөр ч гэсэн түүний дагалдагч нараар дамжин бүх америк даяар заагдаж байгаа бөгөөд их дээд сургуулиудад албан ёсны хичээл болон орохоор батлагдаж байна.

Амжилт судлал нэг их хөгжөөгүй манайхны хувьд дасаагүй болохоор Наполеон Хиллийн яриа мэдээж эвгүй санагдана. Шал дэмий яриа мэт сонсогдож байгаа. Харин Америкчууд өөрөөр хандаж байна. Тэд элбэг арвин объектив нотолгоогоор дамжуулан Наполеон Хиллийн амжилтын онолтой танилцаж байна. Үнэн гэдгийг нь 2 нүдээрээ харж байгаа учраас хүлээж авахдаа ч хурдан. Хэрэгжүүлэх хурд ч гэсэн мөн адил. Ингэж тэд хурдан гэгч нь баян болж байна. Яг энэ мөчид ч гэсэн дэлхийн бүх баялгийн 90%-аас дээш нь Америкт төвлөрдөг гэсэн өнөөгийн байдлын ар талд Наполеон Хиллийн баяжих арга байгаа юм шүү.

Би заримдаа ингэж боддог юм. Хэрвээ манай улсад Наполеон Хилл, Эндрю Карнеги шиг хүмүүс байсан бол өнөөдрийн Америкийн оронд манай улс байх байсан гэж.

Сэдвээсээ жаахан хазайя. Эндрю Карнеги олон нийтэд дэлгэж Наполеон Хилл олонд хүргэсэн Эндрю Карнегийн

“Мөрөөдөлдөө хүрэх 6 зарчим”-ыг арай өвөрмөц маягаар ашиглан тэрбумтан болсон нэг хүн байсан.

Онгоцны нисгэгчийн мэргэжилтэй нэг залуу байлаа. Korean Air-ийн юмуу эсвэл сөнөөгч онгоцны нисгэгч гэж битгий бодоорой. Түүнийг хэн ч танихгүй бөгөөд нэг муу хуучин онгоц жолооддог ядруухан нисгэгч байсан юм. Үгүй нисгэгчээр удаан ажиллаж чадаагүй, хамгийн доод зэрэглэлийн гэх бүхнийг хийж үзсэн байв.

Харин түүний мөрөөдөл нь зохиолч болох. Зүгээр ч үгүй дэлхийн хэмжээний зохиолч шүү. Гэвч түүний бичсэнийг хүлээн авах хэвлэлийн газар ганц байсангүй. Тийм болохоор тэр гэрийнхээ ойролцоох жижигхэн хэвлэх үйлдвэрт өөрийнхөө мөнгөөр номоо хийлгэх ёстой болов. Дараа нь хөлөө хугартал номын дэлгүүрүүдээр явж номоо тавьсан ч номыг нь тоож авах хүн олдохгүй байсан юм.

Ингээд нэг өдөр Эндрю Карнегийн “Мөрөөдөлдөө хүрэх 6 зарчим”-ыг олж мэджээ. Түүний чин хүсэл нь баян болох биш дэлхийн хэмжээний зохиолч болох байсан болохоор цаасан дээр ингэж бичив. “Миний бүтээлийг бүх дэлхий хүлээн зөвшөөрөх өдөр ирэх л болно!” гэж. Тэгээд хананд наагаад өглөө оройгүй чанга дуугаар уншиж дэлхийн хэмжээний зохиолч болсноор өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлж эхэлжээ.

Иймэрхүүгээр 1 жил өнгөрч, 3 жил өнгөрч, 5 жил өнгөрч, 8 жил өнгөрөв. 9 дэх жилийн нэгэн өдөр. Түүний ном Калифорни хавийн далайн эрэг орчмын хиппи нарын дунд бөмбөг дэлбэрэх мэт хүчтэйгээр тарж эхлэв. Хиппичүүд хар тамхинд татагдаж байгаа юм шиг л түүний номонд татагдана. Бүх америкийн хиппичүүдийг уяраасан түүний ном Нью-Йорк таймсын бестселлер болж, дэлхийн 20 улсад зохиогчийн эрх нь худалдагдан дэлхийн хэмжээний бестселлер болсон байна. Түүний нэр нь Ричард Борк номны нэр нь “Цахлайн мөрөөдөл” юм (23).

☛ Эд баялгийн ӨӨР ЗУРГААН ЗӨВЛӨГЧИД

Энгийн баячууд нь баяжих арга гэж хувьцаанд хөрөнгө оруулах юмуу, үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулах

гэх мэт материаллаг аргыг жишээ болгодог. Арай дээд зэрэглэлтэй баячууд “Эд хөрөнгийг авчирч өгдөг эрдэм мэдлэг хуримтлуулах”-ыг санал болгодог. Том баячууд “Хүний сэтгэлийг мэдэрч, амьдралын эргэж байгаа зүй тогтлыг ойлго” гэж хэлнэ. Харин дэлхийн толгой баячууд юу гэх бол? Тэд мэдээж түрүүн хэлсэн 3 зүйлийг баяжих аргууд гэдгийг хүлээн зөвшөөрнө. Гэхдээ өөр бас нэг зүйл хэрэгтэй гэж хэлэх байх. Сэтгэлийнхээ гүнд дэлхийн тэргүүн баян болж байгаа өөрийнхөө дүр төрхийг зур гэдгийг.

Хүн төрөлхтөний түүхэн дэх хуруу дарам цөөхөн баяны нэг, өнөө үеийн дэлхийн толгой баян, дэлхийн №2 баян, Японы хамгийн баян хүн болон Японы хувийн хэвшлийнхнээс хамгийн өндөр татвар төлөгч нарын яриаг сонсоцгооё.

Рокфеллер нь Карнегийн хамт хүн төрөлхтөний түүхэн дэх хуруу дарам хэдэн баячуудын тоонд ордог билээ. Гэтэл түүний эхлэл нь Карнегийнхаас дээргүй байлаа. Тэр хувийн компанид нягтлан бодогчийн туслахаар ажиллан амьдралаа эхэлсэн бөгөөд цалин нь хар ажил хийдэг хүнээс ч дор байсан. Харин тэр нэг их удалгүй хэдэн компанийн эзэн баян хүн болсон байлаа.

Рокфеллерийн намтарт бичсэнээр бол хамгийн бага цалин авдаг залуу хүүд нэгэн өвөрмөц зуршил байдаг байсан гэнэ. Тэрээр бараг л үргэлж согтуу хүн шиг харагддаг байсан нь архи ууснаас биш ганцаараа өөрийнхөө төсөөлөлд автдаг байсан учраас тэгдэг байсан гэдэг. Тэр төсөөлөл гэдэг нь юу байсан юм бол? Түүний хадгаламжийн дэвтэрт усны урсгал мэт урсан орж ирэх мөнгийг төсөөлдөг байсан гэнэ (24).

Билл Гейтс дэлхийн тэргүүн баян. Тэр компьютер үйлдвэрлэн асар их хөрөнгө хураасан гэдгийг бүгд мэднэ. Тэгвэл яаж түүний компьютерийн үйлдвэрлэл дэлхийг байлдан дагуулж чадав аа? Энэ асуултанд Билл Гейтс өнгөрсөн жилүүдийн турш залхтал нь ингэж хариулж байгаа билээ.

“Би арван хэдтэй байхаасаа эхлээд дэлхийн айл бүр нэг нэг компьютертэй болсон байгаагаар төсөөлж заавал

тийм болгох болно гэж өөртөө хэлдэг байсан. Тэр бол эхлэл байлаа.”

Уоррен Баффет нь дэлхийн №2 баян билээ. Түүний хувьцаанд хөрөнгө оруулахаар эхэлсэн анхны гарааны мөнгө нь 100 доллараас хэтрэхгүй байсан гэдэг. Харин 3 жилийн дараа 1 сая \$, 10 жилийн дараа 10 сая, 30 жилийн дараа гэхэд 1,4 тэрбум \$-той болсон байлаа. Үүнээс хойш түүний хөрөнгө хэдэн тэрбумаар өссөн. Тэрээр, Билл Гейтс компьютерийн зах зээлийг эзэгнэхээс өмнө тэр дэлхийн 1 номерын баян байсан. Түүний нэгэн сэтгүүлд өгсөн ярилцлагад дэлхийн номер нэг баян болсон нууцаа ингэж тайлбарласан байдаг.

“Бүр хцүхэд байхад миний сэтгэлийн гүнд дэлхийн №1 баян болсон байгаа дүр зураг тодоос тод байдаг байлаа. Би өөрийгөө тийм болж чадна гэдэгтээ ганц хором ч эргэлзэж байгаагүй.”

Ли Кай Шин аавыгаа уушигны өвчнөөр нас барангуут дунд сургуулиас гарч цайны үйлдвэрт ажилд орсноор идэвхтэй амьдралаа эхэлжээ. Одоо бол тэр Ази тивийн хамгийн баян хүн билээ. Түүнд Гонконгийн тэргүүлэгч аж үйлдвэрийн 1/4 хэсэг, бүх дэлхийгээр тарсан 460 том компани харьяалагддаг. Панамийн суваг болон Өмнөд Солонгосын Пусан хотын контейнерийн вокзал ч бас түүнийх. Канадын Ванкуверт гэхэд л шинэ хот барих жишээтэй. Нэг удаа түүнээс сурвалжлагчид “Та яаж жирийн ажилчнаас Азийн тэргүүн баян болж чадав аа?” гэж асуухад ингэж хариулжээ.

“Би үргэлж л өөрийгөө хамгийн баян хүнээр төсөөлдөг байсан. Нууц гэвэл энэ л байна даа.” (25)

Нэмж хэлэхэд Ли Кай Шин одоо ч гэсэн унтахынхаа өмнө дараа өдрийнхөө ажлыг амжилттай дуусгаж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлөх ёслолыг заавал хийж байж унтдаг гэнэ. (26)

Сун Масаюши нь Японы тэргүүн баян. Одоо Азийн Билл Гейтс гэгддэг тэр гараагаа нь тун өрөвдөлтэй эхэлж байсан гэдэг. Ажилтан хөлслөх мөнгөгүйгээсээ болоод цагаар ажиллах

2 оюутан олон ажлаа эхэлж байжээ. Тэгсэн нөгөө 2-ынх нь нэг цалингаа авч чадахгүй байх гэж айгаад 1 сар ч бололгүй ажлаас гарч байсан гээд боддоо.

“Би 19 настайдаа өөрийнхөө мөрөөдлийг тов тодорхой бүтээсэн байсан. 20-тойдоо салбартаа нэрд гарч, 30 насандаа бэлэн мөнгөөр 10 тэрбум иен цуглуулна...”

Эдгээр нь түүний өөрийн ном болон ярилцлаганууддаа тоогүй олон удаа дэлгэсэн амжилтын нууц юм. Тэр зөвхөн ганц төсөөлөн мөрөөдөөд зогссонгүй барилгын зураг төсөл шиг загвар бүтээж байсан гэсэн түүний энэ яриа мөрөөдөхөөсөө, төсөөлөхөөсөө айж байгаа бидэн шиг хүмүүст агуу том дуудлага болон ирж байгаа биш гэж үү?

Саито Хитори том оврын ачааны машины жолоочийн туслахаар анх ажилд орж байв. Нэр нь л туслах болохоос үнэндээ бол жинхэнэ жолооч байсан юм. Харин тэр одоо хувийн хэвшлийнхэн дундаа Японы тэргүүн баян. Өнгөрсөн 9 жилийн турш төлсөн татвар нь гэхэд 138 тэрбум давсан байна. Гэхдээ тэр гайхалтай нь “Хичээж чармайснаар хэзээ ч баян болж чадахгүй.” гэж хэлдэг аж. Хэрвээ баян болохыг хүсэж байвал тасралтгүйгээр эд баялгийг төсөөл” гэж. Тэгэх юм бол эд баялаг өөрөө л хүрээд ирнэ.

Мэдээж хар ухаанаар бодоход шал утгагүй яриа л даа. Тийм болохоор ихэнх хүмүүс чихээ таглаад сонсохыг ч хүсээгүй. Харин 10-аад хүн түүний үгэнд итгээд хэрэгжүүлж эхэлсэн байна. Тэгээд үнэхээр бүгд асар баяжиж чадсан юм. Тэд бүгд одоо ч амьд сэрүүн Япондоо амьдарч байгаа бөгөөд тэдний яриа ном болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга гарч байдаг билээ.

2. ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАГЧ ИД ШИДИЙН ЗАХИАЛГА

Жинхэнэ эмч таны сэтгэлийн гүнд байдаг.

Гиппократ

Эрүүл мэндийг хамгаалагч ХОЁР ГОЛ ЗҮЙЛ

Дэлхий дээрх хүмүүсийг 2 төрөлд хувааж болно.

Харин та аль төрөлд нь хамаарах бол?

1. Өглөө бүр хөнгөн шингэнээр эртлэн босож идэвхийлэн дасгал хийнэ, хүйтэн усаар биеэ арчина, өдөрт идэх ёстой хоолыг заавал иднэ, биенд сайн бүхнийг нарийлахгүй заавал авч иднэ, эмнэлэг тогтмол явж үзлэг хийлгэн эмчийн зөвлөлгөөг заавал авна.
2. Сэрүүлэгний дуугаар арай ядан босно, хүйтэн усаар биеэ чийрэгжүүлэх зориг огт байхгүй, дасгал хийх ёстой гэж бодохоос цаашгүй, олдсоноо л иднэ, биенд сайн хоол хүнсийг идэх нь бүү хэл сонсоноос цаашгүй, хүнд өвдөхгүй л бол эмнэлэг явдаггүй жүн.

Хэрвээ та эхний бүлэгт багтах хүн бол эрүүл хүн. Харин 2-р бүлэгт багтах хүн бол эрүүл биш хүн гэсэн үг. Ийм байх ёстой. Харин энэ ойлголт нь тэр болгон үнэн байж чаддаггүй. Хорвоогийн бүх үнэн тийм байдгийн адил эрүүл мэндийн үнэн гэсэн ойлголт хойно нь явж байдаг мэт. Яагаад гэвэл эхний бүлгийн хүмүүс өвчин тусахгүйгээр урт насладаг биш учраас тэр. Харин ч сүүлийн бүлгийн хүмүүс өвчингүйгээр удаанаас удаан амьдрах тохиолдол олонтой байдаг. Мэдээж бүгд тийм биш ч гэсэн.

Тэгвэл жинхэнэ үнэн нь энд байна. Хүний эрүүл мэндийг хариуцдаг биеийн тамир, хоол хүнс, эмч зэрэг нь физик хүчин зүйлээс хэтрэхгүй. Үүнийг анагаах ухаан ч судалгаагаараа баталчихсан. Тийм жишээ тун олон боловч гол 3-ыг нь энд бичлээ.

1. Доктор Е.Айдлер 12 жилийн турш тамхи татдаг 3000 хүнийг судалж тамхи тамхичинд үзүүлж байгаа нөлөөг судалжээ. Үр дүн нь гайхалтай байв. Тамхи татах нь зарим хүмүүст үхлийн аюултай байдаг ч, заримд нь онцын өөрчлөлт үзүүлдэггүй аж. Нас барагсдын тоо ч гэсэн ихээхэн зөрүүтэй байсан байна. Эхний бүлгийнхнээс нас барагчдын тоо сүүлийн бүлгийнхнээс 7 дахин их байв. Өөрөөр хэлбэл хүний эрүүл мэндэд тамхинаас илүү муугаар нөлөөлж байгаа ямар нэгэн зүйл байсан байна.
2. Стэнтфордийн ИС-ийн анагаах ухааны профессор Кеннет Пеллите өөрийнхөө чадах хэмжээгээр эрүүл амьдарч байгаа хүмүүсийн нууцыг судалсан байна. Анхандаа тэр мөнгө, хооллох дэглэм, дасгал хийх зэргийг эрүүл байлгадаг гол шаардлага гэж үзэж бодож байв. Гэтэл судалгааны дүн нь шал эсрэгээр гарчээ. Дээр хэлсэн физик шалтгаанууд эрүүл мэндэд нэг их нөлөө үзүүлж чадахгүй байсан байна. Профессор Кеннети Пеллитер 1994 онд эрүүл мэндийг тодорхойлогч гол шийдвэрлэгч хүчин зүйлийг дэлхий дахинд танилцуулав.
3. Мичиганы ИС-ийн Сэтгэлзүй судлалын танхимийн эрхлэгч Жеймс Хаус Мичиган мужид амьдарч байгаа 3000 насанд хүрэгчдийн эрүүл мэндийн байдлыг 10 аад жил судалсан байна. Тэгээд нэгэн өвөрмөц онцгой үйлдэл хийдэг хүмүүсийн өвчин тусч нас барах магадлал тэгдэггүй хүмүүсийнхээс 2.5 дахин бага байгааг олж тогтоосон байна.

Тэгвэл доктор Айдлерийн олж тогтоосон тэр ямар нэгэн хүчин зүйл ба Пеллите профессорын гол шийдвэрлэгч хүчин зүйл болон Хаус эрхлэгчийн онцгой өвөрмөц үйлдэл гэдэг нь юу байж болох вэ? Тэр бол $R=VD$ ба хайр юм байна.

Доктор Айдлер ингэж хэлж байна.

“Тамхи татангаа тэцнээс болж эрцл мэнд нь муудаж байгаа гэж боддог хцмцүсийн бие аажмаар муудаж хурдан нас бардаг. Харин тамхи татах биенд нь онцын

нөлөө үзцүлэхгүй гэж боддог хүмүүсийн биенд үнэхээр л онцын нөлөө байдаггүй байна.”

Профессор Пеллите ярьж байна.

“Эрцүл мэндийн гол хүчин зүйл бол сэтгэл санаа юм. Ялангуяа хүмүүсийг чин сэтгэлээсээ хайрлан үйлчлэх.”

Хаус эрхлэгч ингэж хэлж байна.

“Тэр өвөрмөц онцгой үйлдэл гэдэг нь хайр ба хүмүүст туслах. Хүнийг хайрлан идэвхтэйгээр тусладаг хүмүүц эрцүл, урт удаан насладаг.”

Арай хялбараар хэлбэл сэтгэлийн гүндээ хайр байхгүй өөрийгөө эрүүл энх байгаагаар төсөөлөх чадвар дутаж байгаа хүн бол хичнээн дээд зэргийн хоол идэж, дасгал хийгээд дээд зэргийн эрүүл мэндийн хамгаалалтанд байгаад тэр бүхэн нь хоосон зүтгэл болно гэсэн үг. Харин эсрэгээр нь эрүүл байхын тулд онцын зүтгэл гаргадаггүй ч сэтгэлдээ өвчний тухай ямар ч төсөөлөл бодол орохыг зөвшөөрдөггүй, бусдыг өөрийн бие шигээ бодож хайрладаг бол хэнээс ч илүү эрүүл байдаг байна. Өөрөөр хэлбэл хүнийг эрүүл энх байлгадаг шийдвэрлэгч бодит 2 хүчин зүйл бол төсөөлөл тэгээд хайр юм.

☞ Төсөөлөх чадвар нь хүний биед ШУУД НӨЛӨӨЛДӨГ

АНУ-ын Портер Хавдар судлалын төвийн доктор Карл Саймонтон ингэж ярьж байна.

Хэрвээ аль нэгэн бцлэг хүмүүц ямар нэг шалтгаанаар хорт хавдар тусвал шууд л үхдэг гэж үздэг тэгээд санаатай ч юмуу эсвэл санаандгүйгээр хорт хавдраар өвчлөгчдийг нас барж байгаа байдлаар бцлгээрээ төсөөлж эхлэх юм бол тэр бцлгийнхнээс нас барагчдын тоо огцом өсдөг. Тийм учраас хорт хавдрыг эмчлэхийн тулд эхлээд тэр бцлгийн гишүүдийн хорт хавдарын тухай сөрөг төсөөллийг эхлээд үгүй хийх ёстой.”

Техасын ИС-ийн судалгааны үр дүн ч гэсэн төсөөлөх чадварын өвчинд үзүүлэх нөлөөний тухай сонирхолтой үзэл бодлыг танилцуулсан байна. Шинжилгээний багийнхан Америк, Англи, Грек, Румын зэрэг улсуудын сэтгэцийн өвчтөнүүдэд тулгуурлан өргөн хүрээтэй судалгаа явуулжээ. Тэгээд сэтгэцийн хүнд өвчтэй хүмүүс хорт хавдар, цусны өвчин зэрэг хүнд өвчнөөр өвчилдөггүй болохыг олж илрүүлсэн байна. Судалгааны баг нь түүний шалтгааныг төсөөлөх чадвар гэж үзэж байгаа аж.

Эрүүл хүмүүс хэвлэл мэдээллээр дамжуулан өвчний тухай мэдээллийг хүлээн авч өөрөө ч мэдэлгүй тасралтгүйгээр өвчний тухай төсөөлөн түүнийхээ үр дүнд хорт хавдар мэтийн өвчин амархан тусдаг байхад, сэтгэцийн өвчтөнүүд тийм өвчин байдаг гэдгийг ч мэддэггүй болохоор санаатай санаагүй тийм өвчнийг төсөөлөх боломжгүй учир тийм хүнд өвчин тусдаггүй байна.

Төсөөлөх чадвар хүний биед томоохон нөлөө үзүүлдэг. Санаатай санаагүй тасралтгүйгээр өвчнийг бодож төсөөлөөд байвал өвчин тусч, харин эрүүл мэндийг үргэлж төсөөлвөл эрүүлжих болно. Хүн өвчнийг төсөөлөөд байвал бие нь стрессэнд автана. Тэгэхэд стрессийн гормон ялгарч дархлааны системийг устгана. Эсрэгээр нь эрүүл энх байгаагаар төсөөлвөл мэдрэлийн пептид хэмээх гормон ялгарч дархлааг улам сайжруулдаг. Үүнийг PET юмуу fMRI шинжилгээгээр шууд өөрийн нүдээр харж болно.

Зөвхөн энэ ч биш. Хүн түр зуур 2 гараа бариад хүний биенд сайн тархины долгион болох альфа долгионыг төсөөлөх юм бол жинхэнээсээ тийм долгион ялгардаг байна. Зүрхний цохилт, цусны даралт, биеийн халуун, ходоодны хүчил зэргийг ч гэсэн төсөөллийн хүчээр удирдаж болно. Жишээлбэл зүрх хурдан цохилж байгаагаар төсөөлвөл үнэхээр зүрхний цохилт хурдасч, халуун бууж байгаагаар төсөөлөхөд биеийн температур буурдаг байна. Энэ бүхэн Нью-Йоркийн Рокфеллер ИС-ийн судалгаагаар батлагдсан үнэн юм. Төсөөлөх чадвараар дархлааны эс болох цагаан бөөмний тоог ч удирдах боломжтой. Жишээ нь одоо интернэтээр цусны цагаан бөөм юмуу Т-лимф

гэсэн хайлт хийгээд үзээрэй. Тэгээд гарч ирэх имижийг хараад толгойндоо цусны цагаан бөөм болон лимфийг төсөөлөөрэй. Тэгэхэд таны цусан дахь цагаан бөөм болон лимфийн тоо маш хурднаар нэмэгдэнэ. Үүнийг Техасын ИС судалгааныхаа дүнгээр баталсан юм. Нэмж хэлэхэд цусны цагаан бөөм болон Т-лимф нь хүний биен доторх хорт хавдарын эс болон вирусээс эхлэн олон төрлийн муу нян бактериудыг устган зайлуулж өгдөг бидний бие доторхи эмч гэхэд болно.

☛ Эрүүл байхыг хүсэж байвал ХАЙРЫН VD ХИЙ

Гэлээ гээд байнга цагаан бөөм эсвэл алфа долгионыг байнга төсөөлөх хэцүү. Хичнээн биенд сайн гэсэн ч энэ жаахан зохиомол гэх үү дээ. Бас байнга энэ тал руу хазайгаад байвал эрүүл байхын бас нэг үндэс болсон хайр мартагдах болно. Хайр бол зүгээр ч нэг хэсэг нь биш эрүүл мэндийн эхлэл ба төгсгөл. Эрүүл мэндийн бүхий л зүйл гэсэн үг.

Хэрвээ бид жинхэнээр хайрыг “хэрэгжүүлэх” юм бол тэгж алфа эсвэл цагаан бөөмөө олшруулах гэж “зовохгүйгээр” бас ядартлаа дасгал хийхгүйгээр, янз бүрийн юм идэхгүйгээр эрүүлээс эрүүл сайхан амьдарч чадна.

Үнэхээр эрүүл баймаар байвал сэтгэлийнхээ гүнд хайрыг нүдэндээ харагдтал ургуулан бодож төсөөлж чаддаг байх ёстой. Ямар ч хариу нэхэхгүйгээр бусдад үйлчилж байгаагаар төсөөлөхгүй байж болно. Зүгээр хайр гэдэг үг урсаад орж байгаагаар төсөөлөхөд л хангалттай. Тэгэхэд тархины Limbic system-ээс хүний бие сэтгэлийг тайвшруулж, хоол шингээлтийг сайжруулан, цусыг цэвэрлэн тунгалаг болгодог гормон ялгарч тархин дахь цусны судсаар дамжин бүх биеэр тархана. Дархлаа сайжруулдаг гормон хязгааргүй ихээр ялгарна. Дараагийн яриаг сонсоцгооё.

“Хайр талархлаар дүцрэн сэтгэл бидний биенд цагаан бөөм болон эндропинийг маш их хэмжээгээр үйлдвэрлэдэг.”

Доктор И Сан Гү (Хавдар судлаач эмч)

Мөрөөдөл биелцүлж өгдөг ид шидийн захиалга

“Сэтгэлийнхээ гүнд үргэлж баяр хөөр сайхан зүйлсийг төсөөлж бусдыг жинхэнээсээ хайрлаж чаддаг хүн хэзээ ч өвчин тусдаггүй.”

Дэвид Совел (Калифорни Сан-Хосе Кайзер Пернамент эмнэлэг урьдчилан сэргийлэх тасгийн эрхлэгч)

“Сэтгэлийн тань гүнд хайр баяр хөөр талархал байх юм бол эндропины ялгаралт нь стрессийн гормоныг барьдаг. Түцний үр дүнд дархлаа улам сайжирна.”

Ром Линда АИС ЭШ баг, Стэндфорд АИС ЭШ баг.

“Юу ч болсон эерэгээр бодож, ямар ч цед талархаж, хэнийг ч гэсэн хайрлах сэтгэлээр хандан амьдардаг хүн ямар ч өвчин тусдаггүй.”

Харуяма Сикэу (Япон Чонвонхүсээн эмнэлэг дарга)

“Хайр хүний бие сэтгэлийг эрцүлжүцлэн бүх өвчнөөс урьдчилан сэргийлж өгдөг.”

Эндрю Вайл (Аризона АИС орлогч декан)

“Хайрыг зөвхөн ургуулан бодоход л стресс болон вирус халдахаас хамгаалагдаж хүний дархлаа ба эдгэх чадвар нүдэнд мэдэгдэхүйц сайжирдаг.”

Харвард ИС, Жонс Хопкинс АИС судалгааны баг

“Дэндүц ихээр хайрлаж талархсан сэтгэлтэй байдаг хүн яагаад ч өвчин тусдаггүй.”

Р.Хармони (АНУ сэтгэл судлаач)

Хайр ямар ч болзол тавьдаггүй. Зүгээр л өгдөг гэсэн үг. Хэрвээ та сэтгэлийн гүнд “хайр” гэдэг үг бичээд байгаа мөртлөө түүнийгээ тоохгүй орхисон ч хайр таны дархлааг сайжруулж эрүүл байлгаж өгнө. Томоохон жишээ нь Тереза эх байна.

Есүс Христийн хайрыг харуулан амьдарч байсан Тереза эхийн тухай кино юмуу ном үзэх юм бол шууд нэг хэсэг эсрэг биет буюу глобин нэмэгдээд л ирэх болно. Өөрөөр хэлбэл дархлаа сайжирч бие тань эрүүлжинэ гэсэн үг. Бүр гайхалтай нь Тереза гэдэг хүний тухай мэдээллүүдийг хараад “Надад огт хамааралгүй юм байна. Мэдээд байх шаардлага алга.” гэдэг

юм уу. “Энэ хүн бол тусгай хүн” гэж хандаж байгаа хүний биед ч глобин нэмэгддэг. Энэ бол жинхэнэ хайрын хүч юм. Гэхдээ ийм хайрын хүч ч гэсэн нөлөөлж чадахгүй болох үе байдаг. Таны сэтгэлд уур хилэн ба өшөө хорсол байгаа цагт. Хайр уур хилэн өшөө хорслыг хайлуулахад хүч хүрэхгүй учраас тэр биш. Тийм сөрөг сэтгэлгээнд баригдсан үедээ хайрыг бүрмөсөн эвдээд хаяж байгаа учраас тэр юм. Таны сэтгэлд хайр байрлах зай огт байхгүй болохоор тэр. Тэхээр хайрын VD хийхийн өмнө эхлээд уур хилэн өшөө хорслоо өөрчлөх WD хийх шаардлага гарч ирж байгаа юм.

Дотор, мэдрэл, урьдчилан сэргийлэх, сэтгэл зүй, хавдар судлалын салбар, ерөнхий анагаахын салбаруудад дэлхийд нэртэй эмч нар энгийн эмч нарыг бодвол өвчтөний сэтгэл санааг эмчлэх тал дээрээ тэргүүлж байгаа бөгөөд тэдний заадаг VD-г товчоор энд буулгая.

1. Нам гүм газар ороод 2 нүдээ анина.
2. Сэтгэлийн гүндээ төсөөллийн тайзыг бий болгоорой.
3. Тэр тайзан дээрээ таны сэтгэлийг шархлуулсан хүн, таныг уурлуулсан хүн, танд өширхөж байгаа хүн... зэргийг уриад авчир.
4. Тэдэн рүү өөрийнхөө сэтгэгдлийг илгээхээсээ өмнө энэ талаар бодоод үз. Та хэн нэгэнд өөрөө мэдэлгүй сэтгэлийн шарх өгсөн байж болохыг, хэн нэгэн өширхөх ажил хийсэн байж болохыг, хэн нэгнийг уурлуулсан байж болохыг. Тэгээд тэр үнэнээ хүлээн зөвшөөрөөрэй. “Хүн гэдэг төгс төгөлдөр байж чадахгүй. Би ч, тэр хүмүүс ч.”
5. Тэр тайзан дээрээ та өөрийгөө уриаарай.
6. Таныг зовоосон тэр хүмүүстэй нэг нэгээр нь гар барьж “Таныг уучилж байна. Танд амжилт хүсье.” гэж хэлээрэй. Энэ үедээ халуун дулаанаар тэврэх юм бол бүр сайн.
7. Гар барьж дуусаад сайхан инээмсэглээрэй. Энэ үедээ болж өгвөл жинхэнээсээ ч гэсэн инээх ёстой шүү.

Дээрх VD-г байнга хийх юм бол нэг их удахгүй сэтгэлд тань байгаа уур хилэн өшөө хорсол тань хаврын цас мэт хайлан алга болох болно. Би өөрөө ч гэсэн ийм VD-г хийж үзэхэд үр дүн нь гайхалтай сайн байсан. Миний дотор нуугдаж байсан хэн нэгний талаарх сэтгэл дундуурхан байсан бөөн юм бага багаар тайлагдаж эцэст нь бүр тэр хүнтэй тэврэлдэж чадахаар болж байв. Бодит байдал дээр яадаг бол? Анхандаа бага зэрэг эргэлздэг ч аажмаар зориг орж тэр хүн дээрээ өөрөө очоод "Таныг уучилж байна. Таны ирээдүйн ажилд амжилт хүсэн өрөөж байна." гэж хэлээд гар барьж чадахаар болох итгэл төрнө. Хэрвээ тэгэхгүй бол надад өөрт хэцүү байх юм шиг санагдаж байсан билээ. Уур хилэн, өшөө хорслоо хайлуулах VD-гээр дамжуулан сэтгэлээ цэвэрлэн ариутгасны дараа хайрыг санал болгож байна. Өглөө босоод нэг удаа, тэр өдрийн ажлаа дуусгаад нэг удаа, тэгээд шөнө унтахын өмнө нэг удаа хайрын VD хийгээрэй.

Зарчим нь амархан. Гүнзгий амьсгаа авч дэлхийгээр дүүрэн байгаа "хайр" энэ агаартай хамт орж цээжийг чинь дүүргэж байгаагаар төсөөлнө. Удаанаар амьсгалангаа тэр "хайр" бүх биеэр тарж байгаагаар төсөөлөөрэй. Энэ үед хайрыг дулаахан гэрлэн бөөрөнхийгөөр төсөөлөх юм бол бүр сайн. Хэрвээ тэгэх хэцүү байвал хэн нэгэн таныг хайрлаж байх үеийн дурсамжийг давтан дурсах юм уу эсвэл амьдралынхаа хамгийн аз жаргалтай баяр хөөртэй байсан мөчүүдийг дурссан ч болно. Гэхдээ ингээд ч болохгүй бол зүгээр л сэтгэлийн гүндээ "хайр" гэдэг үгийг бичсэн ч болно.

Ийм энгийн VD байнга хийхэд л та эрцл амьдрах боломжтой билээ.

3. СЭТГЭЛ САНАА ӨӨРӨӨ ЭМЧ

Бүх өвчтөний бие байгалийн өөрөө эдгэрэх чадвар гэсэн эмчтэй байдаг. Өвчтөний дотор оршин байгаа тэр эмчид ажлаа хийх боломж олгох нь эмч нарын хийх ёстой хамгийн дээд цүрэг юм.

Алберт Швейцер

☛ Өвчнийг эдгээх VD

Нэг ийм нөхцлийг бодож үзэцгээе. Та мэргэжлийн зүрхний эмч. Нэг өдөр та өвчтөн үзэж байна. Онош нь *angina pectoris* (цээжний бах). Эм ч бараг үйлчлэхээргүй шатандаа орж байгаа өвчтөн. Ингээд орхих юм бол хэзээ ч зүрх нь зогсож үхэж магадгүй. Та сургуульд заалгасан ёсоороо мэдээж зүрхэндээ мэс засал хийлгэх санал тавина. Гэтэл өвчтөн өөдөөс тань нэг тийм сонин юм ярина. “Бясалгалын аргаар өөрийнхөө өвчнийг эдгээнэ ээ. Мэдээж хоолны дэглэм барина, дасгал ч хийх болно.” хэмээн.

Танд хэлэх үг олохгүй болоод ингэж асууна.

- “Ингэхэд та юуг бясалгах гээд байгаа юм бэ? Одоохон мэс засал хийхгүй бол юу ч болж магадгүй байхад чинь...”

Өвчтөн:

- “Хайр амар тайвныг бясалгах болно. Зэрэгцүүлээд миний зүрхний боогдож хаагдаад байгаа судсаар 20 настай байх үеийнх шиг чөлөөтэй цус гүйж байгааг нүдэндээ харагдтал төсөөлөх болно.” гэж хариулна.

Ийм үед эмч биш хүн ч гэсэн ч гайхах байх. Юун солиотой юм яриад байна аа гэж. Эмээр ч эмчлэгдэхгүй хүнд өвчин байхад бясалгалаар эдгээнэ гэнэ үү. Бас юу нүдэндээ харагдтал төсөөлөх вэ?

Нүдэндээ харагдтал төсөөлөөд яана гэнэ ээ? Нэг бол мэдрэл муутай хүн эсвэл ямар нэг шашны нөлөөнд автсан хүн үү гэсэн сэжиг төрөх байх.

Яг одоо энэ мөрийг бичиж байгаа надад ч мөн адил. Шулуухан хэлэхэд ухаан санаа нь эрүүл хүн шиг харагдахгүй байна. “Тэгээ тэг, VD-ээр өвчнөө эдгээж чадах болно. Маш сайн.” гэхээс урдаар “Амь нас нь дээсэн дөрөөн дээр байхад юун VD вэ?” гэсэн бодол түрүүлэх байх.

Харин доктор Дин Онис арай өөрөөр боддог бололтой. Тэрээр дээр хэлсэн аргаар зүрхний өвчнөөр зогсохгүй цаашлаад хорт хавдар, хэт таргалалт, тархинд цус харвах, чихрийн шижин, даралт ихсэх болон чулуужилт үүсэх зэрэг өвчнүүдийг бүрэн эдгээж чаддаг учраас тэр гэнэ.

Ялангуяа зүрхний өвчин гэхэд титэм судас бөглөрөхөд голдуу мэс засал хийгээд 6 сар болоод л дахин бөглөрч давтан мэс засал хийлгэх тохиолдол түгээмэл байдаг байна. Харин доктор Дин Онисийн аргаар зүрхээ эмчлүүлсэн өвчтөнүүдэд дахин өвдөх тохиолдол бараг байдаггүй гэнэ. Нэмж хэлэхэд Дин Онис эмч Билл Клинтоны хувийн эмч билээ.

Хавдар судлаач, цацраг туяаны мэргэжилтэн Карл Саймонтон доктор Диний эмчилгээнээс нэг алхамаар түрүүлж яваа аж. Тэрээр хорт хавдар нь сүүлийн шатандаа орсон 159 өвчтөнд цацраг эмчилгээ хийхийн зэрэгцээ дараахь 8 төсөөллийг хийхийг шаарддаг байжээ.

1. Хорт хавдарын эсийг хоол гэж төсөөлөх.
2. Хорт хавдарын эсийг барьж иддэг хүний биед байдаг НК гэдэг эсийг хоолонд сайн матар гэж төсөөлөх.
3. НК эс нь хорт хавдарын эсийг идэн устгаж байгаагаар төсөөлөх.
4. Бондгор хорт хавдарын хэмжээ багасан багассаар бүрмөсөн үгүй болж байгаагаар төсөөлөх.
5. Эмчээсээ хорт хавдар нь бүрмөсөн байхгүй болсон байгааг сонсож байгаа мөчийг төсөөлөх.
6. Эмчийн хэлснийг сонсоод сэтгэл сэргэн нисмээр санагдах мөчийг төсөөлөх.
7. Гэртээ оронгуутаа гэрийнхэндээ бүрмөсөн эдгэрсэн тухайгаа хэлж бүгд баярлан алга ташиж байгаа байдлыг төсөөлөх.

8. Шинэ хүсэл мөрөөдөлтэйгөөр ажилдаа дахин явж эхэлж байгаагаар төсөөлөх.

Ямархуу дүн гарсан бол? Дээрхи 8 үзэгдэл буюу дүр зургийг үнэхээр нүдэндээ харагдтал, бодит байдлыг ялгахгүй болтлоо ургуулан төсөөлж байсан өвчтөнүүдийн 22.2% нь бүрмөсөн эдгэрсэн байна. Бусад нь тэр хэмжээнд хүрч чадаагүй ч зөвхөн цацрагийн эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдээс 2 дахин удаан амьдарч чадсан байна. Бүр хорт хавдар нь нүдэнд харагдахаар том хэмжээтэй болсон байх үедээ шүү.

Эрүүл энхийг хариуцдаг VD ЖИШЭЭНҮҮД

$R=VD$ нь өвчнийг эдгээхэд ашиглагдаж болох болов уу? “Хэрвээ $R=VD$ нь жинхэнэ өөрчлөлтийн арга юм бол өвчнийг ч гэсэн өөрчлөх боломжтой л байх ёстой доо.” гэсэн бодлоор үүнд хамааралтай материалуудыг хайж эхэлсэн зохиогч маань Дин Осин ба Кал Саймонтоны VD эмчилгээний аргатай танилцаад багагүй гайхсан байна. Гэхдээ шууд л сэжиг төрсөн. Тэгээд өөр жишээнүүдийг хайж эхлэв. Ингэхэд сэжиг улам нэмэгдсэн. Одоогийн байдлаар зохиогч эрүүл мэндийн VD-г болгоомжтойгоор хэрэгжүүлж байгаа үе юм. Энэ яриаг дараа үргэлжлүүлэхээр орхиод бусад жишээнүүд рүү орцгооё.

АНУ-ын дотрын эмч Д.Чопра уушигны хорт хавдартай өвчтнүүддээ өдөрт хэд хэдэн удаа “Би эдгэж байна. Миний өвчин бүрмөсөн эдгэж байна.” хэмээн чанга дуугаар хэлж эдгэж байгаа өөрийн төрхийг нүдэндээ харагдтал төсөөлөн бодохыг хүссэн байна. Түүний хэлж байгаагаар бол энэ арганд итгэн хэрэгжүүлсэн өвчтөнүүдийн өвчин бүрмөсөн эдгэсэн гэнэ.

Массачисто АИС-ийн арьс өнгөний өвчний тасгийн өвчтнүүдийг 2 хэсэгт хуваан ийм эмчилгээний туршилт хийсэн байна. А хэсгийнхэн нь үндсэн эмчилгээний арга болох гэрлийн эмчилгээ хийжээ. Б хэсгийнхэнд үндсэн эмчилгээтэй зэрэгцүүлээд төсөөллийн эмчилгээг хийв. Б хэсгийн өвчтөнүүдийн өвчнийг үүсгэгч устгагдахын зэрэгцээ эрүүл эсүүд шинээр ургахад туслах төсөөллийг тогтмол хийлгэсэн байна. Үр дүн нь ийм байлаа. А хэсэгт 10 хүн байснаас дөнгөж

2 нь л сайжирсан байв. Харин Б хэсэгт байсан 13 хүнээс төсөөллийн эмчилгээг сайн хийсэн 10 хүн нь маш хурдан өдгэсэн гэнэ. Тэгж чадаагүй 3 нь сайн эдгээгүй байна.

Калифорни АИС-ийн профессор Мартин Россман 1972 оноос эхлэн өвчтөнүүддээ VD эмчилгээний аргыг зааж эхэлсэн бөгөөд өчнөөн мянган өвчтөнүүдийн өвчин нь угаагдсан мэт өдгэх юмуу эсвэл илтэд сайжирсан байна.

Сан-Францискогийн Нэгдсэн эмнэлгийн зүрхний хүнд өвчтэй 400 хүнд ийм туршилт явуулсан байна. А хэсгийн 200 өвчтөнд өөрсөд нь мэдэгдэхгүйгээр тэдэнд залбирлаар туслах олон хүмүүс гаргаж өгчээ. Тэдгээр туслагч нар нь Бурхан өвчтөнүүдийн өвчнийг эдгээж байгаагаар нь төсөөлөн залбирцаасан байна. Харин Б хэсгийнхэнд тийм хүмүүс гаргаж өгсөнгүй. 6 сарын дараах үр дүн нь ийм байлаа. Б хэсгийнхэнд хэрэглэсэн антибиотекийн хэмжээ А хэсгийнхнээс 5 дахин их байжээ. Бас Б хэсгийнхэнд уушигны үрэвсэл А хэсгийнхнээс 3 дахин илүү илэрсэн байна.

Харвард ИС-ийн эмнэлэгт 54 үргүй эмэгтэйд 10 долоо хоногийн турш өөрийг нь жирэмсэн болж байгаагаар нүдэнд нь харагдтал төсөөлүүлсэн байна. Үүний үр дүнд үнэхээр чин сэтгэлээр төсөөлж байсан өвчтөний 34% нь 6 сарын дотор жирэмсэлсэн байна.

Нью-Йорк Мемориал Слон-Кеттеринг Хавдар судлалын төв “Хорт хавдартай өвчтөнүүдийн ихэнх нь 6-8 сарын өмнөөс эхлэн асар том сэтгэл зүйн цохилтонд орж, үхмээр санагдах төсөөллийг санаандгүйгээр тогтмол хийх болж байгаагаасаа болж хорт хавдар нь улам газар авдаг байна.” хэмээн мэдэгдэж байна.

АНУ-ын Дюк ИС-ийн эмнэлэг ба Английн Бристол Хавдар судлалын төвд төсөөллийн эмчилгээний албан ёсны эмч ажилладаг.

Дээр яригдсан зүйлс бол мөсөн уулын орой л гэсэн үг. Өнөөдрийн өдөр VD эмчилгээний арга нь ерөнхий эмчилгээний арга, энгийн эмчилгээний арга, төсөөллийн эмчилгээний арга, имиж эмчилгээний арга, мэдрэлийн хэлзүйн программ, ФРТ программ зэрэг төрөл бүрийн мэргэжлийн хэллэгээр нэрлэгдэн

дэлхийн улс бүхэнд тоолж баршгүй олон өвчтөнийг эмчилж байна. АНУ-ын 80 гаруй их дээд сургуулиудад VD эмчилгээний аргыг албан ёсны хичээл болгон зааж Улсын эрүүл мэндийн төвд ОАМ гэдэг байгууллагаар дамжуулан мэргэжлийн түвшинд судалж байгаа бөгөөд эмчилгээнд ч өргөн хэрэглэж байгаа болно.

☞ Эмчилгээний VD ДАВУУ ТАЛУУД

БНСУ-д VD эмчилгээний арга нь эмчилгээний болон сувилагчийн салбарт заагдаж байгаа, ардын эмчилгээнд ч идэвхтэйгээр эмчилгээнд хэрэглэж байна. Гэтэл Европ талын анагаахад зарим нэг газрыг эс тооцвол бүхэлдээ үл итгэх байдлаар хандаж байгаа юм. Тиймээс хэрвээ та эмчдээ энэ талаар ярьвал жаахан гажигтай хүнд тооцогдох магадлал өндөр.

Яагаад Европ эмнэлэг VD аргаас татгалзаж байна вэ? Европ эмнэлгийн үндэс суурь ба VD аргын үндэс суурь тэс өөр учраас тэр юм. Европ анагаах ухаан нь нүдэнд харагдаж байгаа бүхнийг дагадаг уламжлалт Ньютоны физикт тулгуурладаг. Та бүхний мэдэж байгаагаар Ньютоны физик ертөнцийг машин техник гэж үздэг. Хүнийг ч мөн адил. Эвдэрхий хэсэг байвал тайрч салгаж хаяад өөр хэсгээр сольчихвол болох нь тэр. Тийм учраас өнөөгийн эмнэлгүүд өвчтөнийг хүн биш өвчний түүх бичсэн картнаас илүүгүй үздэг.

Нөгөө талд байгаа VD томъёо маань нүдэнд харагдахгүй зүйлийг хөнддөг орчин үеийн квант физик дээр тулгуурладаг. Орчин үеийн Квант физик нь орчлон ертөнцийг энерги гэж үздэг билээ. Эндээс энерги нь сэтгэл судлалын нэр томъёогоор илэрхийлэх юм бол “Оюун ухаан”, шашин талаас нь үзэх юм бол “Сүнс” гэгддэг.

Квант физикийн үүднээс үзэхэд хүний бие махбоди нь энергийн нэгдэл бөгөөд тэр энергийн урсгал тэнцвэрээ алдахад өвчин бий болдог. Өөрөөр хэлбэл өвчнийг эдгээхийн тулд тэр тэнцвэрийг барих ажил хийх ёстой. Жишээ нь VD эмчилгээний арга мэтийн зүйл хэрэгтэй гэсэн үг.

Удирдахуйн ухаан, эдийн засаг, цахилгаан хэрэгсэл, компьютер, биологи, хими, сэтгэл зүй зэрэг орчин үеийг авч явж байгаа салбар бүр нь уламжлалт Ньютоны физикээр цаашдаа хорвоо дэлхий болон хүн төрөлхтөнийг тайлбарлаж болохгүй болохыг ухааран орчин үеийн квант физик рүү хурднаар иргэж байна. Онолоос эхлээд уг үндэс нь хүртэл өөрчлөгдөж байна.

Гэвч харамсалтай нь Европ эмнэлэг нь хуучин сэтгэлгээгээ хатуу мөрдсөн хэвээр байгаа юм. Шалтгаан нь юунд байна вэ? Эмч өвчтөнийг өвчний түүх биш хүн гэж үзэх ёстой болж, эмчилгээнд зөвхөн материаллаг аргыг биш сэтгэл зүйн аргыг нэмж хэрэглэх, өвчтөнтэй нэгэн сэтгэлээр нэгдэж өвчинтэй нь тэмцэх ёстой гэдгийг дарамт гэж үзэж байгаа юм болвуу? Үгүй бизээ. Бидний мэдэхгүй арай өөр гүн шалтгаан байгаа биз. Тэгж итгэхийг хүсэж байна.

Дүгнээд үзье. VD хүний өвчнийг эмчлэхэд онцгой нөлөөтэй. Хэрвээ хэн нэгэн VD төгсөөр хийж чадах юм бол эмнэлэг хэзээ ч явахгүйгээр өөрийгөө эмчилж чадна. Эсвэл эмнэлэг явангаа эмчилгээний VD хийх юм бол тэгээгүй хүнээс 2 дахин хурдан өдгөх боломжтой.

Эмчилгээний VD ын сайн тал нь сэтгэл зүйн онцгой нөлөөтөйд байгаа юм. Хүн сэтгэлийнхээ гүнд өвчнөө аль эрт эдгэснээр өөрийгөө харахад л харагдахуйцаар бие нь сайжран тайвшрах болно. Ийм сэтгэл зүйн байдал нь өвчний байдлыг огцом сайжруулан дээшлүүлдэг юм.

Эмчилгээний VD хийхэд мөнгө шаардагдахгүй. Илүү дутуу үйл хөдлөл ч хэрэггүй. Зүгээр сэтгэлийн гүндээ чимээгүйхэн төсөөлөөд л болоо. Ийм сайн эмчилгээний арга хорвоо дээр өөр байна уу? Хэрвээ та өвчтэй байгаа бол, хэрвээ таны ойр орчинд өвчтэй хүн байгаа бол эмнэлгээс хийж байгаа эмчилгээтэй хавсруулан VD эмчилгээг хийхийг санал болгож байна. Сайхан үйл тохиолдох болно. Үнэхээр сайхан зүйл шүү...

VD эмчилгээний аргын тухай интернэтээс маш их мэдээлэл олж уншиж болно. Хайлтын цонхонд “төсөөллийн эмчилгээ”, “сэтгэл зүйн эмчилгээ”, “имиж эмчилгээ” гэж бичээд ороод үзээрэй. Маш олон материалтай танилцах болно.

4. БОДИТ БУС ҮЙЛДЭЛ БОДИТ БУС ҮР ДҮНГ БИЙ БОЛГОНО

☞ Гоц авьяастнуудын VD ӨӨР БАЙДАГ

Доктор Хукуи Кажсикээ өөрийн нээсэн уураг тархи өөрчлөх программаараа жирийн хүний суралцах чадварыг гоц авъяастны хэмжээнд хүргэн дээшлүүлдгээрээ алдаршсан хүн юм. Токиогийн АИС-ийн эмнэлэгт ажиллаж байх үеэсээ эхлэн тархи ба сурах чадварын талаар бусдаас илүү их сонирхож судалж энэ талаараа олон ном бичсэн байна. Түүний заадаг сурах чадвар сайжруулах тусгай арга нь хялбар юм (28).

“Хичээл шалгалтын талаар эерэг VD хийгээрэй. Тэгвэл сурах чадвар чинь гайхамшиг гэмээр сайжрах болно.”

Амьдрал гэдэг үргэлжилсэн шалгалтууд. Бага сургуулийн 1-р ангиас эхэлдэг шалгалт дээд сургууль төгсөөд ажилд ортол үргэлжилнэ. Ажилд орсны дараа арай өөр хэлбэрийн шалгалт эхэлнэ. Бараг үхтлээ шалгалт өгөх тавилантай оршихуй бол хүн ч юм шиг. Бидний өөрсдөө өгөх шалгалт хэзээ нэгэн цагт дууссан ч хүүхэд маань сургуульд ормогц шууд бусаар өгөх шалгалт эхэлдэг болохоор тэр юм. Ихэнх хүмүүс шалгалт гэхээр стрессэнд ордог. Шалгалт өгөх өдөр ойртох тусам айж бушуухан дуусахыг тэсэн ядан хүлээнэ. Гэтэл шалгалтнаас стресс огт авдаггүй хүмүүс байдаг байна. Тэд шалгалт өгөх дуртай. Шалгалт тэдний хувьд чадвараа баталдаг, бусдаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх боломж гэж ойлгодог байна. Улсын хэмжээгээр тэргүүн байранд ордог сурагчид, онц төгсөгчид, эхний байранд орж дээд сургуульд элсэгчид болон зэрэг ахиулах шалгалтанд орж албан тушаал ахигчид юм.

Би нэг үе номоо бичихийн тулд 1500 орчим хүмүүсийн материалтай танилцаж байсан удаа бий. 1000-аад нь сурагчид үлдсэн нь албан хаагчид байв. Түвшин тогтоох болон зэрэг ахиулах шалгалтанд тэнцэгсдийн гар бичмэл, ярилцлага, ном зэргээс харахад тэдний түгээмэл нууц нь “Хичээл хийж

дугаацдаг” гэдэгт байв. Арай тодорхой хэлбэл “Уйтгартай хичээлийг хөгжилтэй зугаатай хийхийн тулд их чармайлт гаргах болдог. Тэгвэл хичээл хийх үнэхээр сонирхолтой болох болно. Дагаад сурлага ч сайжирна.” гэж ярьцгааж байна. Би энэ нээлтээ ном ба лекц, мөн сонин хэвлэл олон нийтийн хэвлэлээр өргөн мэдээлсэн.

Тэгтэл зохиогч нэг удаа ийм асуулттай тулгарав.

“Ингэхэд тэд яаж хичээлийг зугаа болгох чармайлтыг тасралтгүй хийж чаддаг байна аа?”

Хариулт олохын тулд тэдний материалыг дахин дахин ухлаа. Ингээд хариултаа олж чадсан юм. Тэдний VD арай өөр байв.

Жишээ нь зохиогчийн хувьд сурч байх үеийн хичээл хийх болон шалгалтын VD нь сөрөг загварын нэг байсан. Би хэзээ ч хичээл хийх дуртай байгаагүй бөгөөд шалгалтаас айдаг. Хичээл хийх болохоор аав ээжийн бачимдсан царай, багшийн бухимдсан нүүр, тэгшитгэл орсноос хойш ахихаа больсон тооны хичээл, интеграл энэ тэр, дотор хүйт оргиулдаг дүнгийн хүснэгт санаанд орно. Тэдгээр дүр зургууд намайг хичнээн довоодог байсан нь сургууль төгсөөд арван хэдэн жил өнгөрсөн өнөөдөр ч гэсэн кино гарч байгаа мэт нүдний урдуур урсан өнгөрч байгааг бодоход ойлгогдох байх. Харин дээр гарсан 1500 хүний VD өөр байлаа. Тэд “хичээл”, “шалгалт” гэхээр эцэг эхийнх нь юмуу эхнэрийнх нь гэрэлтсэн инээмсэглэл, багш болон даргынх нь найдвар дагуулсан нүдний харц, гартаа барилаа л бол гялалзтал дуусдаг номнууд, сэтгэл догдлуулдаг шалгалтын дүн зэрэг сэтгэлд нь буудаг гэсэн.

Тэд угаасаа сурлага сайтай учраас тийм VD тэдний хувьд мэдээжийн хэрэг юм биш үү гэсэн асуулт гарч ирж магад юм. Тийм биш ээ. Тэр 1500 хүнээс угийн сурлага сайтай байсан нь 1100 орчим нь, үлдсэн 400 орчим нь жирийн л эсвэл бүр доогуур сурлагатангууд байсан юм. Өөрөөр хэлбэл 1100 хүн нь анхнаасаа эерэг VD хийж хичээлээсээ таашаал авах аргыг өөрсдөө ухаарсан, үлдсэн 400 хүн нь зориудаар эерэг VD хийж хичээлээсээ таашаал авахыг ойлгосон байлаа.

Эгэл жирийн хүмүүст ч бас найдвар байдаг юм шүү.

VD нь гормонийн ялгаралтад НӨЛӨӨЛДӨГ

Бетаэндропин хэмээх гормони нь hippocampus болон frontal lobe байрлаж байгаа A10 гэдэг мэдрэлийг идэвхжүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Бетаэндропин нь эерэг зүйл бодох бүрд ялгардаг бөгөөд hippocampus-ыг цочроон санах ойг сайжруулж, frontal lobe-ыг цочроон сурах чадварыг дэмжиж өгдөг.

Арай ойлгомжтойгоор хэлбэл гоц ухаантан, суут ухаантан гэж нэрлэгддэг хүмүүсийн уураг тархинд бетаэндропин бүрэн гүйцэд ялгарч тархдаг гэж үзэж болно.

Үнэхээр Нобелийн шагналтнууд болон дэлхийд нэртэй номын хүмүүс эрдмийн ажилдаа бүх анхаарлаа хандуулах үед тэдний тархинд бетаэндропин асар ихээр ялгардаг гэдэг. Тийм учраас бетаэндропинийг заримдаа “суутны гормон” гэж нэрлэдэг.

Харин норадреналлин хэмээх гормон бетаэндропины эсрэг үүрэг гүйцэтгэдэг. Норадреналлин нь сөргөөр бодох бүрд ялгарах бөгөөд тархинд бетаэндропин ялгарахыг зогсоож A10 мэдрэлийн ажиллагааг удаашруулан ажил хийдэг байна.

Тархинд нь норадреналлин ихээр ялгардаг хүний онцлог нь сурах сонирхол байхгүй хичээлд дургүй, ойлгохгүй тэгээд шалгалтанд итгэлгүй ханддаг зэрэг. Сонирхуулж хэлэхэд норадреналлин нь кобра могойн хорны найрлаганд ордог бөгөөд архичин, хар тамхичин хүний тархинаас ихэвчлэн илрүүлдэг байна.

Уураг тархи судлаачид ба тархины физиологи судлаачид бүх хүн фотограф ой тогтоолттой байдаг гэдгийг нээсэн байна. Фотографик ой тогтоолт гэдэг нь нэг харсан зүйлээ дижитал аппаратаар зургийг нь авсан мэт тархиндаа хадгалах чадварыг хэлнэ.

Тэгвэл энгийн хүмүүс ийм чадварыг ашиглах боломж байхгүй юм болов уу? Яагаад математикийн эсвэл физикийн суут ухаантнууд л ийм чадварыг ашиглаж чаддаг юм бол? Ингээд тархи судлаачид болон тархины физиологич эрдэмтэд

энэ сэдвийг нухацтай судласны дүнд хариултыг нь олсон байна. Суутнуудаас ялгаатай нь жирийн хүмүүсийн тархинд очүүхэн алдаа гардаг нь тэдний фотографик ой тогтоолтоо ашиглах замыг нь хаадаг байна.

Ихэнх хүмүүс хичээлээ сайн хийж шалгалт тус бүрт дээд амжилт үзүүлэхийг хүсдэг ч яг жинхэнэ амьдрал дээр болохоор инэл тэнэг юм хийчихдэг. Хичээлдээ санаа зовж, шалгалтанд унахаас айна. Хичээл хийх үнэхээр сайхан учраас дуртайяа хичээл хийж байгаагаар өөрийгөө хүчлээд ч төсөөлж чаддаггүй мөртлөө хичээлээс болж зовж байгаагаар бол амархан гэгч нь зурж орхино. Сургуульдаа 1-р байр, улсад 1-р байр ажилдаа тэргүүн байр эзэлж байгаагаар яагаад ч төсөөлж чадахгүй мөртлөө энгийн нэг дүн авч байгаагаар эсвэл шалгалтанд унаж байгаагаар төсөөлөх тун хялбар. Өөрийнхөө амьдралын хүсэл мөрөөдлийг сүйтгэж байгаа VD байнга цаг мөч бүр санаатай бишээр хийгээд байдаг.

Ингэж л хүмүүс өдөр бүр өөрсдийн уураг тархинд кобрагийн хорны найрлагатай хорт бодисыг бүр асгаран орох боломж олгоод байдаг. Норадреналлины ялгаруулалтыг нэмэгдүүлж hippocampus ба frontal lobe үйл ажиллагааг удаашруулна. Үр дүнд нь анхаарал төвлөрөлт, ой санамж хязгаарлагдаж эцэст нь сөрөг VD нь бодит болно. Жинхэнээсээ хичээлээ ч хийж чадахгүй шалгалтандаа унана.

Норадреналлин нь фотографик ой тогтоолтонд бүр үхлийн цохилт өгдөг. Та магадгүй хийсэн хичээл чинь нэг л цэгцэрч ойлгогдохгүй, чадлаараа хийгээд ч гол утга нь тас мартагдаад ч юмуу байгаа юм биш биз? Нэг удаа унших нь хангалтгүй тусгай тэмдэглэж олон дахин бичиж байж нэг юм цээжилдэг юм биш биз?

Хэрвээ тийм бол фотографик ой тогтоолтонд тань том хязгаар байгаа гэсэн үг бөгөөд таны сөрөг VD энд ямар нөлөөтэй байгаа гэж бодож байна? Магадгүй та өөрөө ч мэдэхгүй өөрийгөө жирийн нэг чадвартай эсвэл тааруухан нэг сурлагатай нэгэн болгоод байгаа ч байж магад юм.

Адъяагч/агч.

ЕЦ-т хороолох
ага

•e• VD гээ өөрчилвөл УУРАГ ТАРХИ Ч ӨӨРЧЛӨГДӨНӨ

Хичээлдээ сайжирмаар байвал эсвэл шалгалтанд гайхамшиг гэмээр амжилт үзүүлмээр байвал юу юунаас түрүүнд VD-гээ өөрчлөх хэрэгтэй. Дүн чинь дунд бүр муу байх нь хамаагүй. Өөрийгөө дээд зэргээр хичээлж шалгалтанд өндөр дүнтэйгээр тэнцэж байгаагаар төсөөлөн бодоод байвал уураг тархи ч өөрчлөгдөнө. Норадреналлинаар дүүрэн байсан тархи бетаэндропиноор дүүрч тархины долгион альфа долгион болно.

Агуу Эйнштейн судалгаагаа хийж байх үед тархинд нь ялгардаг долгион, шатрын их мастеруудын өрөг тавих үеийн долгион, компютероос сайн ой тогтоолтоороо бахархдаг хүмүүсийн долгион тэгээд жирийн хүмүүсийн унтаа байдалтай байгаа фотографик ой тогтоолтыг сэрээх үе ялгарах тэр альфа долгион.

Шууд Хэрэг Нилл

Хэрвээ та сурагч бол зав гарах бүрдээ бүх хүчээ дайчлан энэ төсөөллийг хийгээрэй.

1. Хичээлийн цагаар багшийн зааж байгааг сонсоод шууд ойлгон цээжилж байгаагаар өөрийгөө төсөөлөх.
2. Сурах бичиг болон нэмэлт материалыг нэг уншаад л агуулгыг нь бүрэн дүүрэн ойлгож байгаагаар өөрийгөө төсөөлөх.
3. Сургууль дээрээ шалгалт бүрд дүн нь огцом дээшилж цаашлаад өөрийгөө 1-р байранд орж байгаагаар төсөөлөх.
4. Сайжирч байгаа сурлагыг тань харан таниар бахархан алга ташиж байгаа эцэг эх болон багш. Тэгээд сурлагын тань амжилтын нууцыг мэдэхийг хүсэж араас тань дагах олон түмэн. Таны сурлагын нууц хүмүүсийн гайхлыг төрүүлж хэвлэл мэдээллээр цацагдан ном болон хэвлэгдэж байгаа байдал.

Хэрвээ та элсэлтийн шалгалтанд бэлдэж байгаа сурагч бол өдөрт нэг удаа цаг гарган ийм дүр зургийг нүдэндээ харагдтал ургуулан бодоорой. Хичээл хийх хэцүү байх тусам илүү их төсөөлөөрэй. Тэгвэл сэтгэл тайвширч анхаарал сэргэдэг.

1. Таны сайн мэддэг сэдэв шалгалтанд ирж байгаагаар.
2. Таны орохыг хүсэж байгаа сургууль эсвэл ажлын газраас “Та тэнцлээ. Баяр хүргэе.” гэсэн хариу авч байгаа байдал. Энэ үедээ “Бурхан минь намайг үнэхээр тэнцүүлсэнд баярлалаа” гэж хашгирч байгаагаар.
3. Тэнцсэнд баяр хүргэж байгаа таны эцэг эх, багш, найз нөхөд, тэгээд “Чамайг тэнцэнэ гэж мэдэж байсан юм” гэж хэлж байгаа байдал.
4. Та тэнцсэний баяр хийж найз нарыгаа хоолонд оруулж байгаа байдал. Гайхалтай сэтгэл өндөр орчин, хоолны мөнгөө төлж байхдаа бага зэрэг харамссан ч баяр хөөртэй байгаа байдал.

Зэрэг ахиулах шалгалтанд бэлтгэж байгаа бол “Тэнцсэн” гэдэг үгийг “Зэрэг ахих” гэдэг үгээр орлуулаарай. Бүх сэтгэлээ дайчлан чин сэтгэлээсээ зурсан төсөөлөл бодит болно. Та одоо ямархуу байдалд байгаа огт хамаагүй. Та чин сэтгэлээсээ хүсэж ургуулан бодож байгаа дүр зураг л хамгийн чухал.

Шалгалт ойртоод байдаг хийсэн хичээл байхгүй урьдчилсан шалгалтын дүн огцом доошилсон ирээдүйгээ бодохоор нулимс болон санаа алдах л үлдээд байгаа бол тэгэх тусам өөрийгөө тэнцэж байгаагаар төсөөлөөрэй. Таны ажиллахыг хүссэн газартаа орохоор өргөдлөө өгсөн боловч одоо хийж байгаа ажлаасаа болоод шалгаруулалтанд бэлдэх цаг зав гардаггүй бол, тэгээд түүнээсээ болоод зовж шаналж байгаа бол тэгэх тусам тэр хүссэн газартаа ажиллаж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Нулимсаа гартал итгэлтэйгээр бүр чин сэтгэлээсээ төсөөлөөрэй.

Үнэхээр хүссэн сургуульдаа тэнцээд орсон байгаагаар, ажилдаа орсон байгаагаар, тушаал ахисан байгаагаар харин одоо тэр өнгөрсөн үеийг дурсаж байгаа гэж андуурхаар тэгж бүх хүчээ дайчлан төсөөлөөрэй.

Та өдөр хоногийг ингэж амьдран өнгөрөөж байтал нэг л өдөр гайхамшиг таны амьдралд өөрөө ороод ирэх болно. Таны мөрөөдөл бодит болж, таны сэтгэлдээ зурсан зураг жинхэнэ цнэн болно.

☛ Профессор Пээ Жүн Сү ба VD

Сөүл ИС-ийн багш, АНУын бага сургуулийн тооны хичээлийн сурах бичгийг зохиосон, тооны хичээл заах аргаараа дэлхийд тэргүүлдэг Пээ Жүн Сү, дэлхийд хамгийн том хятад хоолны рестораны Харимгаг сүлжээний эзэн Нам Сан Хээ нар нь үнэхээр хамгийн гарцгүй гэж болохоор нөхцөлд агуу VD хийж хэрэгжүүлэн огт боломжгүй шалгалтанд тэнцэж чадсан томоохон төлөөлөгч нар юм.

Пээ Жүн Сү багш тэр үед 28 настай байсан гэсэн. 6 жилийн турш ажилласан газраасаа гарч багш болох мөрөөдлөө биелүүлэхээр хичээллэж эхэлсэн байна. Эхний зорилго нь дунд сургуульд тооны багш хийх эрх авах явдал байв. Гэхдээ энэ нь тийм амар биш асуудал байлаа. 4 жил их сургуульд тоо заалган төгссөн оюутнуудад ч хүнд санагддаг энэ шалгалтанд тэнцэх хүн улс даяар нэг л байдаг байсан юм.

Залуу Пээ Жүн Сү яг одоо байгаа бодит байдлаа нэг харлаа. Тэгэхэд толгойд нь “Огт боломжгүй” гэдэг үгнээс өөр юу ч гарч ирсэнгүй.

1-рт тэр утга зохиолын чиглэлээр төгссөн болохоор интеграл дифференциал үзэж байсан удаа байхгүй.

2-рт шалгалтанд бэлдэх хугацаа дөнгөж 6 сар. 6 сарын хугацаанд ахлах сургуулийн программыг дээд сургуулийнхтай хамт үзэж дуусгах ёстой байлаа.

Тэхээр үзээд алдахаас өөр арга байсангүй. Бодит байдал дэндүү хатуу байлаа. Бодлого бодох нь бүү хэл асуултыг нь ч ойлгохгүй. Залхаж цөхрөн математикчдийг хараан номоо тэврээд хэнгэнэтэл уйлна. Иймэрхүү байдлаар 4 сарыг өнгөрөөлөө.

Гэхдээ өөрийн мөрөөдлөөс ухарч орхиж чадахгүй гэдэг дүгнэлт хийгээд зориудаар шалгалтын эерэг VD хийж эхэлсэн байна. Шалгалтанд тэнцсэн, тэгээд багш болсноор өөрийгөө төсөөлж сэтгэлээ тийм зургаар дүүргэсэн байна. Чин сэтгэлээсээ, үнэн зүрхнээсээ, яаран байж, нүдэндээ харагдтал

өрийн хүссэн дүр зургийг зураад л зураад л байж. Намайг прилцлага авч байх үед Пээ Жүн Сү профессор тэр үеийн сэтгэл санааны байдлыг “Амьдралаараа дэнчин тавьсан гэдэг нэр томъёо бүгдийг илэрхийлж чадахгүй. Би амиараа дэнчин тавин байж VD хийж байсан.” хэмээн дүрсэлсэн юм.

Залуу Пээ Жүн Сүгийн зэрэг VD нь түүний тархийг бетаэндропин болон альфа долгионоор зайгүй дүүргэсэн байна. Бетаэндропин ба алфа долгион нь хүний тархинд унтаа байдалтай байдаг суут ухаантны сурах чадварыг сэрээж фотографик ой тогтоолтыг хязгаарладаг тархины бяцхан алдааг засаж өгнө. Ингээд Пээ профессорын уураг тархи зэрэг VD хийж эхлээд 1 сар ч болоогүй байхад суутны тархи болон хувирсан байна. Тэгээд үлдсэн 1 сарын хугацаанд нь ер бусын чадвартай болж шалгалтын бэлтгэлээ амжилттай дуусган мөрөөдөж байсан дунд сургуульд математик заах эрхээ гартаа оруулсан байна.

Пээ Жүн Сү профессорын яриаг сонсоцгооё. “Амь аврагч математик” гэдэг номноос нь хэсэглэн авлаа.

“Би дарж унагаахаар ирж байгаа бүхнийг зогсоох гэж бүх л юмаа дайчлан гэгээлэг зэрэг дүр зураг зурахыг хичээсэн. Тэр нь урт удаан хугацаа өнгөрсний дараа тэтгэвэртээ гарах гэж байгаа би Пээ Жүн Сү байлаа. Унасан навч эргэлдэх зуслан, цал буурал өвгөн багш Пээ Жүн Сү, миний хичээлд идэвхтэй оролцож байгаа сурагчид... Тэгтэл чармайлт маань талаар болоогүй юм уу 1 сар хүрэхгүй хугацаа цлдэж байх цезс эхлэн бага багаар найдвар харагдаж эхэлсэн. Шалгалтнаас 20 хоногийн өмнөөс би өөрөө ч гайхмаар тайвширч эхэлсэн. Нүдний өмнө байгаа асуултуудыг ойлгож эхлэв. Аниатай байсан нүд нээгдэх мэт математик тодроод ирж эхэлсэн. Тэгээд тэр жилийн 12-р сард би тэнцсэн гэрчилгээгээ авсан юм.”

Одоо тэр 28-тайдаа амиа дэнчинд тавин төсөөлж байсан тэр VD-ээрээ амьдарч байна.

Ур чадварын шалгалт өгөхөөр бэлдэж байгаа хүмүүс Харимгаг-ийн захирал Нам Сан Хээ захирлын VD яриаг анхааралтай сонсоорой. Залуу Нам Сан Хээ Олон улсын жуулчны газарт тогооч шалгаруулж авах гэж байгаа тухай сонсох үед тэрээр захиалгын жантай гоймон хүргэгчээр ажилладаг байлаа. Тэр ажилд 5 хүнийг авна гэж байхад орохыг хүссэн 300 гаруй хүн байсан байна. Тэд бүгд хятад хоолны мэргэжлийн тогооч нар байсан гэнэ.

Харин манай Нам Сан Хээ албан ёсоор хоол хийхийг заалгаж байсан удаа ч үгүй байлаа. Тэгээд шалгалтын хугацаа тулчихсан бас амьжиргааныхаа төлөө жантай гоймонгоо зөөх ёстой байдаг. Хоол хийхийг заалгах зав байхгүй, боломж ч байхгүй. Зүгээр л мөрөөдөхөө болихоос өөр зам байгаагүй юм. Харин тэр ашгүй энэ бүхнийг орхих замыг биш VD хийх аргыг хэрэглэн мөрөөдлөө биелүүлэх замыг сонгосон юм.

Залуу Нам Сан Хээ сэтгэлийнхээ гүнд гал тогоо бий болгож түүндээ хоол хийх дадлага хийж байгаа VD хийж эхэлсэн байна. Тэр үед тэр хичнээн үнэмшилтэй VD хийснийг нь хоолонд нь орж байгаа хатсан жараахай хэдэн ширхгийг хийх ёстой тоог хүртэл яг тааруулж байсан гэдэг. Дээрээс нь өөрийгөө тогоочийн шалгалтыг амжилттай дуусгаж байгаагаар түүний хоолны амтанд уярч байгаа шалгалтын комиссынхон, тэгээд шалгарсан 5 хүний тоонд орж байгаа өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлөн зурж байсан гэнэ.

Бодит бус цйлдэл, бодит бус цр дцнг бүтээдэг жамтай. Хувь тавилан шийдэх хариу гарах тэр өдөр ёсоор нь дадлага хийж үзээгүй зөвхөн VD хийж байсан Нам Сан Хээ зөвхөн хоол хийх дадлага хийж VD хийгээгүй бусад 295-ыг ардаа орхин тэнцсэн байлаа.

Олон улсын жуулчны газарт орсныхоо дараа ч гэсэн дадлагын хажуугаар VD-ээ хийсээр 1-р зэргийн төгсөгч болж, төгсмөгцөө л Уолкерхилл зочид буудлын дэд тогоочоор томилогдсон байна. Харин VD хийдэггүй юмуу түүний хэмжээнд хүртэл VD хийж байгаагүй бусад 4 төгсөгч нь түүний удирдлаганд дор ажилладаг туслахууд болсон гэсэн.

Бодит амьдралын шаардлагаас болоод мөрөөдлөө орхин амьдарч байгаа хүмүүст тэрээр ингэж зөвлөж байна.

“Хийгээд хийгээд болохгүй, яагаад ч байдлыг өөрчлөх боломж харагдахгүй байгаа үе ямар байдгийг би сайн мэднэ. Зугтаах газар, нуугдах боломжгүй цөхрөл гэж юу байдгийг ч сайн мэднэ. Тэгэх тусам бодит байдалтай нүцр тулан тэмцээрэй. Найд. Найдвар цөхрөх үеийг даван туулах хүч зоригийг өгнө. Захиалгын жантай гоймон хүргэгч байхдаа би өглөө бүр төсөөллийн “вааран дээвэртэй байшин” барьдаг байлаа. Би тэр байшин дотроо миний ажиллаж байсан хятад хоолны газраас том хоолны газартай түүнийхээ эзэн нь болдог байсан юм. Аюул гэдэг бол боломж бөгөөд хадан цохионы ирмэг дээр зогсож байгаа хүн хамгийн хүчирхэг байдаг нь хууль билээ.” (29)



5. МӨРӨӨДСӨН ТЭР ЗҮЙЛЭЭ Л АВДАГ

☞ Тэдэнд ч НУУЦ БАЙГАА

Хаана ч гэсэн тэр нэг ийм хүн заавал байдаг. Өөрөө нэг их царайлаг биш мөртлөө нүдэнд туссан сайхан залуу дагуулан явдаг бүсгүй, эсвэл өөрөө шалихгүй мөртлөө дагуулж яваа хүүхэн нь ойр орчноо гэгээ оруулдаг сайхан бүсгүйтэй үерхдэг залуу.

Царайлаг эсрэг хүйснийхээ хүнтэй үерхэхийн тулд яаж ч хөл алдан гүйгээд нэмэргүй байдаг хүмүүсийн гэдсийг байнга өвтгөж байдаг ийм төрлийн хүмүүсийн онцлог нь онцын хичээл зүтгэл гаргадаггүйд байдаг. Зүгээр л байж байхад нь хэн нэгэн сайхан эсрэг хүйстэн нь ойртон ирж хайраа илчилнэ. Тэдэнд ямар нэгэн нууц байгааг олж нээсэн хүмүүс байна.

Америкийн алдартай нийтлэлч, редактор Марк Майус ба Английн Хартфордшер ИС-ийн сэтгэл зүйч доктор Ричард Визмэн нар.

Ялангуяа Английн хааны нийгэмлэгийн урилгаар хичээл заадаг Ричард Визмэний судалгааны дүн анхаарал татаж байгаа юм. Тэрээр эсрэг хүйстнээсээ хөндий байдаг аз муутай хэсэг хүмүүс ба эсрэгээр нь астангуудад тулгуурлан 10 гаруй жилийн судалгаа хийсэн байна. Түүний үр дүнд азын тэнгэр нь ивээдэг хүмүүст ба азгүйчүүдэд байдаггүй нэгэн сэтгэл зүйн “зуршил” байдгийг олж нээсэн байна.

Доктор Визмэн азгүйчүүдэд зориулан азын хичээл гэдэг юм уу даа нээж тэдэнд азтайчуудад байдаг тэр зуршлыг заасан байна. Үр дүн нь гайхалтай байлаа. Нөгөө эсрэг хүйснээсээ үргэлж хөндий байсан хүмүүс маань тэдний маш ихээр анхаарлыг нь татдаг болж хувирчээ. Нэмж хэлэхэд доктор Ричард Визмэний төлөвлөсөн ба аз ба азгүйдлийн тухай туршилтууд нь BBC-ийн шинжлэх ухааны нэвтрүүлгээр гарч байсан ба “Nature”, “Science”, “Psycho logical Bulletin” зэрэг дэлхийд алдартай шинжлэх ухаан танин мэдэхүйн

сэтгүүлүүд болон “Times”, “Guardian”, “Daily telegraph” зэрэг хэвлэлүүдээр удаа дараа хэвлэгдэж байсан билээ.

Дээр 2 хүний нээсэн нууц нь энэ номонд гарч байгаа сэдэвтэй яг адилхан. Тэр нууц гэдэг нь өрөөсөн нүдээрээ харахад л зүрх цохилон халуун оргиод ирэхээр тийм хүн танд ухаангүй дурлаж таны араас хөөцөлдөн, тантай байхдаа л аз жаргалтай болж байгаагаар санаатай санаандгүйгээр нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол үнэхээр тэр нь амьдрал дээр тохиолддог гэдэг зүйл.

Марк Майусийн яриаг “хайр” сэдэвт оруулая гэвэл ийм байна.

“Азыг та өөрөө бий болгодог. Мөрөөдөж байгаа тэр хүнтэйгээ уулзаж хайрлан хуримламаар байвал тогтмол цаг гарган сэтгэлийнхээ гүнд кино хийгээрэй. Та мөрөөдлийн хүнтэйгээ байгаа тийм үзэгдэлтэй кино шүү.”

Марк Майос “Азтай хүнийг бүтээх энгийн зуршлууд” гэдэг номондоо ингэж хэлж байна.

“Иймэрхүү байдлаар өөрийгөө төсөөлөх нь тэнэг санагдаж болох юм. Гэхдээ ингэж төсөөлөөд байвал та эцсийн эцэст хүссэн зүйлээ олж авч чадна.”

Доктор Ричард Визмэн “Азын хууль” номондоо ингэж бичсэн байдаг.

25 настай Калифорнийн оршин суугч Андреагийн яриаг сонсоорой.

“Би хайр дурлалын тал дээр хэзээд азтай байсан. 15 настайгаасаа эхлээд л тийм байсан. Миний гадаад төрх тийм гоц гойд биш ч мөрөөдөж болохоор залуустай уулздаг байсан. Ямар нэг ноухау байхгүй ээ. Зүгээр л сууж байгаад юм яриад эхэлмэгц л цуутай царайлаг залуус бүгд л надад унаад ирдэг юм.” хэмээн ярьж байна.

Андреагийн хүнийг өөртөө татаж чаддаг нууц гэвэл нүд гялбуулсан гадаад төрх юмуу агуу чадвар биш харин азанд

тулгуурласан сэтгэл зүй юм. Миний судалгаанд оролцсон азтай хүүхдүүдийн дунд толгойдоо азыг төсөөлөх дасгал хийдэг хүн олон байсан юм. Та ч гэсэн нэг хийгээд үзээрэй. Чимээгүйхэн өрөөнд тохилог сандал тавиад нүдээ анин суух тэгээд хэдэн удаа гүнзгий амьсгалсны дараа та хүсэж байгаа хүнээ нүдэндээ харагдтал төсөөлөөд үзээрэй.

Азтай хүмүүс нэг их хичээхгүйгээр амьдралын хүсэл мөрөөдлөө биелүүлдэг. Нөгөө талаас азгүйчүүл яаж ч хичээгээд хүссэн зүйлээ гартаа оруулж чаддаггүй. Энэ 2 хэсэг хүмүүсийн хооронд ямар ялгаа байгаа хэрэг вэ? Миний судалгааны дүнгээр бол азгүй хүмүүс гэрэл гэгээгүйгээр ирээдүйгээ төсөөлж өөрийн хүчээр юу ч хийж чадахгүй хэмээн боддог. Гэтэл астангууд шал эсрэгээр төсөөлдөг. Гайхалтай сайхан ирээдүй, царайлаг эсрэг хүйстэн өөрийг нь хүлээж байгаа хэмээн төсөөлнө.

Азтай хүмүүс санаандгүйгээр мөрөөдлөө биелүүлдэг гэсэн үг биш. Азгүйчүүд хүссэнээ авах хувь тавилангүй төрсөн гэсэн үг бүр ч биш. Тэдний ирээдүйн тухай төсөөлөл нь тэдний ирээдүйг бүтээж байгаа юм.

☞ Хуримын VD ТУСГАЙ АРГА

Марк Майус болон Ричард Визмэн нар $R=VD$ эсрэг хүйстэнтэйгээ танилцах ба хуримлахад нөлөөлөх нөлөөг сайн тайлбарлан танилцуулж байна. Гэхдээ энэ томъёог шууд хэрэгжүүлснээрээ алдаршсан хүмүүс бас байдаг гэнэ. “Сэтгэлээ нээсэн 101 яриа” гэдэг номоороо нэрд гарсан Марк Хансен ба Жек Кэнфилд, дэлхийн хэмжээний сэтгэл зүйч Энтони Роббинс, хүний сэтгэлгээний хэв маяг тухайн хүний жинхэнэ амьдралд хэрхэн нөлөөлж байгааг 25 жилийн турш судлан тэр тухайгаа 20 жилийн турш лекц болгон уншиж байгаа Жон Кехо нарыг дурдаж болно. Тэд $R=VD$ -г ашиглан мөрөөдлийн эмэгтгэйгээ жинхэнэ амьдрал дээр учран хуримласан аж.

Тэд 1 цагт багаар бодоход хэдэн сая, бүр жэдэн арван саяар нь хөлс авч эсрэг хүйстэнтэйгээ харьцах болон хуримын VD -ын тухай хичээл заадаг бөгөөд агуулга нь ийм юм.

1. Хараахан сэтгэлдээ таарсан хүнээ олоогүй байгаа бол учрахыг хүсэж байгаа эсвэл хуримлахыг хүсэж байгаа хүнийхээ зан араншин, гадаад төрх, мэргэжил, хөрөнгөний хэмжээ, шашин зэргийг тодорхойлоорой. Тов тодорхой байх ёстой. Одоохондоо уулзаж чадаагүй л байгаа болохоос жинхэнэ амьдрал дээр тийм хүн байж л байгаа.
2. Та хайрладаг хүнтэй бол тэр хүнтэйгээ хувь тавилангаар учирч хуримлах шалтгаанаа тодорхойл. Жишээ нь өглөө бүр ажилдаа явахдаа тааралддаг ч ганц ч удаа мэндэлж үзээгүй түүнтэйгээ танилцах болзоонд уулзаж дотносох гэх мэт нөхцөл байдал...
3. 1 ба 2-рт гарч байгаа бүхнийг гоё цаасан дээр тэмдэглэх.
4. Тусгай цаг гарган бичсэнээ чанга дуугаар унших.
5. Чанга дуугаар уншсаныхаа дараа сандал дээр суух юмуу хэвтээд нүдээ анин тайван төсөөлөх. Бичсэн бүхэн чинь биелж байгаагаар...
6. Нүдээ аниад төсөөлөх хэцүү байвал VD зургийн альбом хийх. Сонин сэтгүүлээс тэр хүнтэй чинь төстэй хүмүүсийн зургыг цуглуулан наах. Түүнээсээ бэлэг болгон авахыг хүсэж байгаа зүйлсийн зураг, түүнтэй хамт аялахыг хүсэж байгаа газрын зураг, хамтдаа хуримаа хийхийг хүсэж байгаа газрын зураг, хуримын аяллаар очихыг хүсэж байгаа газар, хамт амьдрахыг хүсэж байгаа байшингийн зураг зэргийг цуглуулан альбом хийх. Заавал ийм дараалал байх шаардлагагүй. Өөрийн сонирхолд тааруулан чөлөөтэй хийгээрэй. Түүнтэйгээ учирч хайранд умбан альбоманд байгаа бүхнийг үзэж эдэлж байгаагаар...
7. Таны VD биелнэ гэдэг бат итгэлтэй байх. Эргэлзэж огт болохгүй. Ойр орчмынхон чинь юу ч гэж байсан, таны дотоод хүн юу ч гэж хэлж байсан битгий тоогоорой. Зөвхөн итгэл дээр нэмэх нь итгэл.

☛ Глена Шульзбергийн VD

Та өнөөг хүртэл амьдрахдаа энэ л миний хувь тавилан гэхээр сэтгэлийг тань хөдөлгөсөн тийм хүнтэй учирч байсан удаа байгаа юу? Тийм хүнтэй дотносож байсан удаа бий юу? Тийм хүн танд халуун хайраа илчилж байсан уу? Хэзээ ч ийм зүйл тохиолдож байгаагүй бол яагаад гэж бодож байна? Та өөрийн VD-ээ нэг шалгаад үздээ.

Магадгүй хувь тавилангийн учрал тань руу өөрөө ирэхийг хүлээгээд мөрөөдөөд л байгаа юм биш биз? Кино, номон дээр гардаг тийм учрал надад тохиолддог бол мөн сайхнаа гэсэн маягаар. Тэгвэл таны VD-г зөвхөн хөнгөн мөрөөдлийн VD гэж үзэхэд болно.

Жинхэнэ $R=VD$ ёсоор бол, таны мөрөөдсөн зүйл бодит болно. Өөрөөр хэлбэл зүгээр тэгвэл сайхнаа гээд өнгөрч байгаа VD нь яг л тийм үр дүнг дагуулна. Та өнөөг хүртэл хувь тавилангийн учрал гэж юу байдгийг мэдэхгүй тиймэрхүү уулзалт байвал сайхнаа гэсэн бодлоос илүү гарч чадахгүй байгаа нь одоогийн TA г бий болгоод байгаа юм. Өөр хэн ч биш зөвхөн та өөрөө ч мэдэлгүй тийм VD хийж байгаа болохоор тийм л бодит байдал бий болчихсон байгаа юм шүү дээ.

“Бусад найзууд маань сайн хүмүүстэй таараад л байх юм би яагаад дандаа болохгүй хүнтэй учирчихдаг юм болоо?” эсвэл “Би хэзээ нэг сэтгэлдээ таарсан хүнтэй болох юм бол?” хэмээн тавгүйдэж, гомдож, эргэлзэж, харамсан халаглаж байгаа хүн ч мөн адил. Тийм хүн санаатай бишээр иймэрхүү тааламжгүй байдлуудын VD хийж байдаг. Тийм учраас түүнийгээ л бодит байдал дээр хүлээн авахаас өөр аргагүй.

Глена Шульзберг яг л ийм хүн байлаа. Зөвхөн хүсэхээс цаашгүй VD болон сөрөг VD-г ээлжлэн хийдэг хүн байлаа. Үнэхээр ийм VD хийхээс ч өөр аргагүй байдалд амьдарч байсан юм. 3 охин ганцаараа өсгөж байгаа, нөхрөөсөө салсан, төлөх ёстой өрнийхөө төлөө бөгтийтлөө ажиллахаас өөр аргагүй байдалтай байлаа. Түүний хувьд хурим, хайр сэтгэл гэдэг бол тансаг үг төдий байсан юм. Түүний хувьд амьд үлдэх л хамгийн чухал зүйл байсан.

Гэтэл түүнд хайртай хүнтэй хэрэгтэй байгааг сайн ойлгож байв. Бас энэ хорвоогийн ямар ч залуу түүнийг сонирхохгүй гэдгийг. Тийм болохоор тэр зөвхөн хүсэхээс цаашгүй VD болон сөрөг VD хоёрын хооронд эргэлдэж байлаа.

Нэгэн өдөр Глена санаандгүй нэгэн семинарт суужээ. Лекц уншигч R=VD ба дээр дурдсан 7 үе дамжлагын тухай тайлбарласан байжээ. Тэгээд гэртээ хариад туршаад үзэхээр шийдсэн гэнэ. Тэглээ гээд алдаад байх юм ч алга, хохироод байх юм ч байхгүй гэж бодсон байна.

Маргааш өглөө нь тэрээр шууд гоё цаасан дээр хүсэж байгаа хүнийхээ тухай ерөнхийд нь бичлээ. Тэгээд сэтгүүлүүдээс зурагнууд цуглуулж эхлэв. Глена ийм зурагнууд цуглуулсан байна.

1. Маш царайлаг залуу.
2. Цасан цагаан хуримын дашинзтай бэр бүсгүй, сайхан смокинг өмссөн хүргэн.
3. Цэцгийн баглаа.
4. Очир алмаазан бөгж.
5. Нүд гялбам цэв цэнхэр Карибын тэнгис дэх арал.
6. Хайр хүрэм сайхан байшин.
7. Үнэтэй тавилгууд.
8. Том компанийн орлогч захирал эмэгтэй.

Эдгээр зургуудаа үнэтэй альбомонд байрлуулаад цаг гарган чин сэтгэлээсээ үздэг болсон байна. Тэгээд тэр зурганд байгаа үзэгдлийг яг жинхэнэ болж байгаа юм шигээр бүх хүчээ дайчлан төсөөлөх болов.

Энэ явдлаас хойш яг 2 жилийн дараа нэг залуу түүнд гэрлэх санал тавилаа. Хаана ч явсан хүмүүсийн анхаарлыг татахаар сайхан залуу найз бөгөөд бүсгүйдээ цэцэг бэлэглэх дуртай, очир алмаз цуглуулах хоббитой хүн байв.

Тэд Гленагийн альбомонд байгаатай бараг адилхан дашинз, смокинг өмссөн хуримаа хийж Карибын тэнгисийн Сентзон хэмээх арал дээр бал сараа өнгөрөөсөн гэнэ.

Энэ нь Глена нөхөртөө мөрөөдлийн самбараа үзүүлэхийн өмнө болсон явдал гэсэн. Нөхрийгөө гайхах байх гээд хуримаа хийснээс хойш яг 1 жилийн дараа нууцаа дэлгэжээ.

Түүний нөхөр Жим нь нэг л өдөр Америкийн зүүн хэсгийн хамгийн сайн тавилга борлуулагч болсон бөгөөд яг тэр альбомон дээрхи шигээ байшинд нүүж очин хамгийн үнэтэй тавилгануудаар дүүргэсэн байна. Глена ажиллаж байсан газрынхаа боловсон хүчний орлогч болж дэвшсэн юм.

Итгэхэд хэцүү ч гэсэн энэ бол үнэхээр болсон явдал (30). Түүний тухай энэ яриа радио ТВ-ээр дамжин Америк болон бүх дэлхий даяар тарсан билээ.

☛ Глена Шульзбергээс СУРАЛЦАХ ЗҮЙЛ

Глена Шульзберг $R=VD$ тухай зөвхөн сонсоод зогссонгүй. Түүнийг амьдралдаа хэрэгжүүлсэн юм. Өөрийнхөө чадах бүхнийг дайчлан хэрэгжүүлсэн.

Та Гленагийн VD хэрэгжихэд хэр хугацаа орсон байх гэж бодож байна? Дээр бичсэн 2 жил гэж бодож байна уу? Үгүй шүү. Тэр 2 жил нь Жимтэй уулздаг байсан хугацаа юм. Түүний VD хэрэгжихэд 8 долоо хоног орсон. Тэгээд бүр хурдны зам дээр шүү! Глена машиныхаа цонхыг онгойлгон Калифорнийн хурдны замаар давхиж явсан бөгөөд хажуугаар нь өнгөрсөн жолооч түүнийг хараад ухаангүй дурлан хойноос нь 15 мил хөөж байж олж уулзсан байна. Жолоочийн нэр мэдээж Жим. Бүх сэтгэлээ зориулан хийсэн VD үр дүн нь шуурхай бөгөөд тодорхой байдаг.

Глена Шульзбергийг та өөртэйгөө нэг харьцуулаад үзээрэй.

Та нөхрөөсөө эсвэл эхнэрээсээ салсан юм биш биз? Та тэжээх үүрэг хүлээсэн хүүхэдтэй юу? Хүүхэд байгаа бол нэг үү, гурав уу? Таны санхүүгийн байдал ямархуу байна? Төлөх ёстой өрөө бодон санаа алдаж суугаа юм биш биз?

Магадгүй та гэрлэж үзээгүй, хүүхэдгүй байх. Бас ямар нэгэн байдлаар бусдын итгэл алдах тохиолдол ч гарч байгаагүй байх. Тийм бол бодит байдлын үүднээс харахад Гленагаас

хэдэн дахин илүү азтай байх ёстой. Гэтэл жинхэнэ амьдрал шал өөр байна. Танд мөрөөдлийн тэр хүнтэйгээ уулзах завшаан олдохгүй байхад Глена Шульзберг тэр хүнтэйгээ учран бүр хуримаа хийгээд хамт амьдарч байна. Тэр $R=VD$ -г хэрэгжүүлсэн байхад та тэгээгүй байна.

Та цнэхээр хцссэн хцнтэйгээ уулзаж хуримаа хийн хамт амьдармаар байвал яг одооноос эхлээд $R=VD$ хэрэгжцлэх ёстой шцц.

Дахин дахин давтан хэлэхэд таны бодит амьдралыг таны сэтгэл л бүтээж байгаа юм шүү. Таны санаатай болон санаандгүй хийсэн VD -нүүд. Хэрвээ та яг одооноос эхлээд сэтгэлийн гүндээ хүсэн байгаа хэн нэгнийг нүдэндээ харагдтал төсөөлөөд эхлэх л юм бол тун удахгүй тэр хүнтэйгээ уулзах болно. Тийм учраас яг одоо сэтгэлдээ хувь заяаныхаа уулзалтыг төсөөлөөд эхлээрэй.

Та өөрийн хүсэн мөрөөдөж байгаа тэр зүйлийг л авах болно.



6. ГЯЛАЛЗСАН ИД ШИДИЙН ХҮЧ

☞ **Үйлчлүүлэгчийг татагч ИД ШИДИЙН ХҮЧ**

Сайн сонсоорой. 2 төрлийн хүмүүс байдаг.

Эхний хэсэг нь дараах гурван хүн

1. Ажилд ороод 3 долоо хоноогүй байхад даргаасаа “Чам шиг үйлчлүүлэгчийн сэтгэлийг ойлгодоггүй хүнийг анх удаа харж байна. Одоохон зайл.” гэж хэлүүлж байгаа залуу.
2. Бүх л таньдаг хүмүүстэйгээ уулзан үйлчлүүлэгчээ болгох гэж оролдоод татгалзсан хариу авч сэтгэлээр унан доройтсон залуу.
3. Үйлчлүүлэгчтэйгээ хамт хоол идэх нь бүү хэл утсаар ярихаас ч айдаг эмэгтэй. Борлуулалт нь мэдээж хамгийн доод хэмжээ.

Нөгөө хэсэгт нь ийм хүмүүс байгаа.

1. 27 настайдаа зөвхөн даатгалын гэрээ худалдсан орлогоороо гэхэд саятан болсон, одоо дэлхийн олон улсад 60 гаруй компанитай залуу.
2. Жилд 1000 гаруй машин худалдаж дэлхийн хамгийн олон машин зарсан хүнээр 12 жилийн турш Гиннесийн номонд бичигдсэн залуу.
3. 29 насандаа Брютникерийн 142 салбараас борлуулалтаараа дэлхийд 2-р байранд орж Японы хамгийн шилдэг борлуулагч эмэгтэй гэж нэрлэгддэг бүсгүй.

Эдгээр хүмүүст 2 нийтлэг зүйл байна.

- 1-рт энд нэг л ижил хүмүүсийн тухай яригдаж байгаа. Өөрөөр хэлбэл 2-р хэсгийнхэн нь эхний хэсгийн ирээдүй юм.
- 2-рт эхний хэсгийнхэн нь $R=VD$ хэрэгжүүлээд сүүлийн хэсгийн хүн болон өөрчлөгдөж чадсан байна.

Энэ бол даатгалын худалдааны хаан Пол Майер, Автомашин худалдааны хаан Жо Жиралд, Японы №1 худалдаачин эмэгтэй Вада Хируми нарын тухай яриа юм. $R=VD$ нь худалдан авагчийг татахад голлогч үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг хүмүүс зөвхөн энэ 3 биш ээ.

Рамзас Олон улсын семинар холбоог үүсгэгч Ибрахим Элпик бол Фортун сэтгүүлээс шалгаруулдаг шилдэг 500 компанийнханд 20 жилийн турш борлуулалтын хичээл зааж байгаа мастер хүн билээ. Тэр өөрийгөө $R=VD$ хэрэгжүүлэн зочид буудлын аяга угаагчаас дээд зэргийн буудлын захирал болж чадсан гэдэг. Ибрахим Элпик борлуулалт, маркетинг, сэтгэл зүй зэрэг 20 гаруй салбарт эрдмийн зэрэг авч дээрхи 3 салбартаа хамгийн шилдэгийн тоонд ордог юм.

Өөрөөр хэлбэл хувийн борлуулалтын амжилтын нууцаас гадна борлуулалтын хаадад тулгуурлан судалгаа хийж худалдах урлагийн онолыг нээж байгаа хүн юм. Тэхээр түүний арга нь дунд сургуулийн боловсролын программ шиг хэнд ч ойлгогдохоор нийтлэг гэж үзэхэд болно (31).

Колумбийн ИС-д сэтгэл зүйн багшаар ажиллаж байгаад одоо Стэндфордын ИС-д ажиллаж байгаа доктор Кэролл Дюик бол нийгмийн сэтгэл зүй ба хөгжлийн сэтгэл зүйн тал дээрээ дэлхийд нэрд гарсан хүн юм. Хорин жилийн судалгааны эцэст Mindset амжилтанд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг гэж үзэж байна. Mindset-ийг VD бүтээдэг сэтгэлзүйн машин гэж ойлгоход болох аж. Кэролл Дюик докторын энэ амжилтын онол нь уламжлалт салбараас гарсан судалгааны үр дүн гэхэд их ач холбогдолтой юм (32).

Ибрахим Элпикийг орчин үеийн эрдэмтэн гэж үзвэл Кэролл Дюикийг уламжлалт шинжлэх ухааны бүлгийн төлөөлөгч гэж үзэхэд болно. Уг нь энэ хоёр байнга эсрэг байр суурьтай байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл энэ хоёр бүлэг онолын болон судалгааны тал дээр нэг зүйл дээр зөрүүгүй санал нийлэх тохиолдол байсан удаагүй. Тийм боловч энэ хоёр эрдэмтэн үүнийг хүлээн зөвшөөрсөн юм.

“Дэлхий дээр соронзон мэт худалдан авагч үйлчлэгчдийг өөртөө татаж чаддаг ид шидийн

хүчтэй хүмүүс байдаг. Тэд $R=VD$ ийг хэрэгжүүлдэг хүмүүс юм. Нөгөө талаас нь үйлчлүүлэгчээ алддаг бүтэлгүй хүмүүс ч байна. Гэхдээ тэд ч бас $R=VD$ хэрэгжүүлбэл ид шидийн хүчтэй болж болно.”

Пол Маиер, Жо Жиранд, Вада Хируми, Ибрахим Элпик, Кэрролл Дюик нараас ийм зүйлийг сурч болох юм.

1. Хэрвээ та зохион байгуулагч бол ажилчидтайгаа хамтаар $R=VD$ хэрэгжүүлээд үзээрэй. Үйлчлүүлэгчид голын ус шиг цутган ирэх болно.
2. Хэрвээ та бизнес эрхлэгч бол хувиараа $R=VD$ -г хэрэгжүүлээрэй. Нэг их удахгүй л худалдан авагчийн үерт автах болно.

☞ Үйлчлүүлэгч усны цутгал шиг түрэн орж байгаа ҮЗЭГДЛИЙГ ТӨСӨӨЛӨӨРЭЙ

Үйлчлүүлэгчийнхээ санаанд тааруулах гэж худлаа инээх эсвэл зусардсан үг хэзээ бүү хэлж байгаарай. Сандарч балмагдан сэтгэлээ зовоох хэрэг ч байхгүй. Ийм сэтгэгдэл нь үйлчлүүлэгчээс болон дандаа сандарч тэвдэн, сэтгэлээ зовоох байдал бий болгодог.

Үйлчлүүлэгч таны жижүүрийн инээмсэглэл сайхан үгэнд хууртахгүй. Онгойхоосоо өмнө түр цаг гаргаад VD хийгээд үзвэл ямар вэ? Таны сэтгэлийн гүнээс гарсан талархал хайр гэрэлтсэн төсөөлөл, та чин сэтгэлээсээ үйлчлүүлэгчийг угтаж байгаа төсөөлөл гэх мэт. Таны тийм алхам үйлчлүүлэгч худалдан авагчийн сэтгэлийг хөдөлгөн тэр хүн танай байнгын үйлчлүүлэгч болох юм бол түүнээс илүү юу хүсэх ёстой билээ дээ.

Борлуулалтандаа санаа зовж санаашрах зав байгаа юм чинь тэр үедээ эерэг VD хий.

Хорвоо дээр үлгэрт гардаг шиг гүйлгээ сайн хийж байгаа дэлгүүр худалдааны газар хичнээн олон байгаа билээ! Үйлчлүүлэгч худалдан авагчийг соронзон мэт татаж аз жаргалтай амжилттай ажиллаж байгаа газрууд шүү. Та тийм газрын эзэн болж болохгүй гэсэн хууль байхгүй шүү дээ.

Амьдралын үнэн маш энгийн. Та өөрийн төсөөлсөн зүйлээ л авна. Тийм учраас бүтээлийн ба бүтээн байгуулалтын төсөөлөл хийгээрэй. Сэтгэл санаа зоволтыг *delete*-лээрэй. Найдвар итгэлтэй бай. Борлуулалт сайжирснаас болоод баярласандаа дэвхцэх цаг ирэх болно. Үйлчлүүлэгчээс татгалзсан хариу аваад цөхөрч гутрах нь хамгийн мулгуу алхам. Өөрийгөө нэг сайн хар. Та үйлчлүүлэгчтэй уулзахын өмнө бүх сэтгэлээ дайчлан $R=VD$ хийсэн үү? Үгүй л биз дээ. Тэгвэл мэдээж татгалзалгүй яахав.

$R=VD$ хэрэгжүүлээрэй. Өглөө босонгуутаа 2 нүдээ анин амжилттай худалдаа хийж байгаа өөрийгөө төсөөл. Үйлчлүүлэгчийн сэтгэлд хүрсэн бараа, үйлчилгээг хийж тусалж байгаагаар өөрийгөө нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Үйлчлүүлэгчид таны жинхэнэ найз болж бүр фэн болж байгаагаар сэтгэлдээ зураад л, зураад л бай. Үйлчлүүлэгчид аз жаргал амьдралын утга учир өгч байгаагаар төсөөлөөрэй.

Ажилдаа явах замдаа ч тийм л VD хийгээрэй. Ажлаа хийж байхдаа ч тийм л VD хийгээрэй. Өдөржин цаг гарах бүрд ийм амжилтын VD хий. Тараад харьж явах замдаа ч амжилтын VD хийж, унтахын өмнө ч тусгай цаг гарган чин сэтгэлээсээ амжилтын VD хийгээрэй. Ингэж таны *сэтгэл санаа амжилтын зургаар дүцрэхэд бодит байдал ч бас яг адилхан зургуудаар дүцрч эхлэх болно.*

☛ Пол Маиерын VD ПРОГРАММ

Пол Маиер нь $R=VD$ баталгаатай үйлчлүүлэгчтэй болоход тусламж болох сургалтын программ зохион дэлгэрүүлсэн хүн. Түүний сургалтын программ нь 10 гаруй жилийн судалгааны үр дүнд тулгуурлан зохиогдсон ба 16 улсын хэлээр орчуулагдан 80 гаруй улсад заагдаж байгаа юм. Энэ программ нь үйл ажиллагаа нь бүтэлгүйтсэн хүнийг богино хугацаанд хамгийн шилдэг борлуулагчаар өөрчилж чадсан бодит жишээ олонтойгоороо алдартай юм.

Саятан байх үедээ тэрээр түүний амжилтын нууцыг асуугаад хүн ирвэл Бенц машин зардаг салбар дэлгүүртээ



дагуулан аваачдаг байсан байна. Тэгээд Бенц машины өмнө аваачиж зогсоогоод яг тэр машины эзэн шиг урд нь зогсохыг шаардан зогссоных нь дараа зургийг нь авч өгдөг байжээ. Зураг нь гармагц Пол Маиер ингэж хэлдэг байсан гэнэ.

“Энэ зурган дээр байгаа хүн нээрээ чи мөн байна шүү. Энэ зургийг байнга харж нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Өөрийгөө гялалзтал амжилтанд хүрч Бенц машины эзэн болж байгаагаар шүү. Тэгвэл жинхэнээсээ тийм болдог юм.” гэж (33).

Түүний үгийг чин сэтгэлээсээ хүлээн авч хэрэгжүүлсэн хүмүүс бүгд амжилтанд хүрдэг гэдэг. Гэхдээ энэ арга нь шинэ санаа биш юм. Америкийн нэр цуутай амжилтанд хүрэгсэд өөрсдийнхөө төлөө, амжилтанд хүрээсэй гэж хүсдэг хүмүүсийнхээ төлөө түгээмэл хэрэглэдэг аргуудын л нэг юм. Санхүүгийн нэртэй мэргэжилтэн Клод Бристол зэрэг хүмүүс Пол Маиераас хэдэн арван жилийн өмнөөс яг ийм арга хэрэглэн хүмүүсийг аварга борлуулагч болгон өөрчилж байсан гэдэг.

Пол Маиер саятнаас арван саятан, тэгээд тэрбумтан болмогц түүний амжилтын нууцыг мэдэхийг хүсэгчид борооны үүл шиг л олон болсон байна. Тэгээд тэрээр өөрийнхөө төлөө ч гэсэн сургалтын программ зохиохоос өөр аргагүй байдалд орсон байна. Тэгээд зүгээр л хүмүүст $R=VD$ зааж байхад баяр хөөртэй болж байгаагаа мэдэрсэн байна. Ингээд АНУын хамгийн шилдэг борлуулагч мэргэжлээ орхин $R=VD$ заах сургалтын ажилд шамдан орсон байна. Ингэж байгуулагдсан компани нь LMI бөгөөд түүний зохиосон программ нь EPL Effective Personal Leadership юм.

Би “мөнгө хураахын тулд биш хүмүүний дотор унтаа байгаа тэр хязгааргүй боломжийг сэрээхийн тулд энэ ажлыг эхэлсэн” гэж хэлж байгаа түүний үгэнд найдаж болно. Яагаад гэвэл тэрбумтан хүн хүмүүст хичээл заан байж мөнгө хийх хэрэг байхгүй учраас тэр. Бас жилд 50 тэрбумыг буяны байгууллагад хандивладаг хүн учраас тэр. Өөрөөр хэлбэл түүний $R=VD$ сургалтын программ нь тодорхой хэмжээнд баталгаа өгч чадах учраас тэр билээ (34).

Пол Маиерын сургалтын программ нь Өмнөд Солонгост ч тодорхой хүрээнийхэнд заагддаг. Өндөр албан тушаалын төрийн албан хаагчид, том компаниудын удирдах ажилтнууд, цэргийн дээд тушаалтнуудад гэх мэт. Үүнд хамрагдах хөлс нь ч бага биш. Нилээн хэдэн сая орно. Мэдээж боломжийн хөрөнгө мөнгөтэй бол эсвэл өөрөө хийж чадна гэдэгтээ итгэлгүй байгаа хүн ийм сургалтанд хамрагдахад зүгээр. Хэрвээ тэгэхгүй гэвэл энэ номонд гарч байгаагаар хийгээд үзэхэд хангалттай.

☛ **Үйлчлүүлэгчийг дууддаг VD АРГА**

Үйлчлүүлэгчийн хайр байтугай сонирхлыг ч татаж чаддаггүй байсан байдлыг 100% өөрчилж ид шидийн юм шиг хүмүүсийг татаж чаддаг болсон хүмүүс нийтлэг VD хийдэг байна. Мэдээж VD хийдэг цаг хугацаа, газар, тоо нь хэд ч байж болох боловч өдөрт 2 удаа орондоо, босоод 10-30 мин орчим, унтахын өмнө 10-30 мин орчим хийдэг гэсэн нийтлэг тал байна.

1. Үйлчлүүлэгчийг чин сэтгэлийн инээмсэглэлээр угтаж байгаагаар өөрийгөө төсөөлнө.
2. Ямар ч онцлогтой үйлчлүүлэгч байсан гэсэн эцсийн эцэст түүний сэтгэлд хүртэл үйлчлэн үдэж байгаагаар өөрийгөө төсөөлөх.
3. Үйлчлүүлэгч харангуутаа л авмаар санагдахаар чанартай сайн бүтээгдхүүн, үйлчилгээгээр хангаж байгаагаар өөрийгөө төсөөлөх.
4. Үйлчлүүлэгчид таны фэн болж танилууддаа ярьж байгаагаар төсөөлөх. Тэгээд үйлчлүүлэгчийн тоо асар хурдан олширч байгаагаар зурах.
5. Жилийн эцсээр тоолж барахааргүй олон үйлчлүүлэгч танд чин сэтгэлээсээ талархал илэрхийлж та өөрөө ч баярласнаа илэрхийлж байгаагаар төсөөлөх.

Тэд R=VD-г үе шаттайгаар хэрэгжүүлдэг.

Эхний үедээ 1ш бүтээгдэхүүнийг амжилттай зарж байгаагаар төсөөлөх, нэг хэрэглэгчийг өөрийн хүн болгож

байгаагаар төсөөлнө. Тэгээд амжилттай гүйцэтгэсний дараа 2ш бүтээгдэхүүн, 2 үйлчлүүлэгчийг гэх мэтээр тоог олшруулна. Анхан шатны дамжаа гэж үзэхэд болно.

Борлуулалт улам нэмэгдэж, худалдан авагчийн тоо олширч бүр асар ихээр нэмэгдэж байгаа үзэгдлийг голдуу төсөөлнө. Худалдан авахыг хүсэгчдээс ирж байгаа утасны дуудлагаас болон утасны аппарат шатах шахах, дэлгүүрийн өмнө ээлжээ хүлээн зогсож байгаа худалдан авагчдын урт цуваа зэрэг дүр зургийг төсөөлөх. Үүнийг дунд шатны VD гэж үзэж болно.

Амжилттай ажиллаж байгаа борлуулагчаас хамгийн шилдэг нь болохын тулд бүгд нүүр тулахаас ч халшран зугтаадаг хэцүү худалдан авагч хачирхалтай нь зөвхөн танд л сэтгэлээ нээн ярилцаж, зөвхөн таниас юм худалдан авч, жирийн худалдан авагчаас таны фэн болтол өөрчлөгдөж байгаагаар төсөөлж эхлэх. Тэгэхэд бусад борлуулагч нар таныг боломжгүйг боломжтой болгодог хамгийн шилдэгт тооцон хүлээн зөвшөөрч хүндэтгэж байгаагаар төсөөлөх. Үүнийг дээд шатны VD гэж үзэж болно.

Хэрвээ та зохион байгуулагч бол ажилчидтайгаа хамтаар бүхнээ дайчлан ид шидийн хүч ялгаран холбогдож байгаа бүх л хүнийг үйлчлүүлэгч болгон өөрчилж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Хэрвээ та ийм VD тасралтгүй хийж чадах юм бол та ажилчдынхаа сэтгэлд хүрч чаддаг удирдагч болж чадна. Сэтгэлийн гүнд ийм кино зураг үзээд байж байхад яаж ажилчид чинь хамаагүй харьцах вэ? Бас та өөрөө ч ажилчдаа хүндэтгэх болно тэгээд энэ бүхэн нь үйлчлүүлэгчдэд сэтгэгдэл төрүүлэх болно.

Юу ч болсон байсан ажилчдаа хэт буруутган маргаан үүсгэх хэрэггүй. Тийм үйлдэл нь таны болон ажилчдын чинь сэтгэлд сөрөг VD л бий болгоно. Тэгээд тэр VD нь R буюу бодит болох болно. Муу дээр муухай муухай дээр улцан гэж бүр л байдал хүндрэнэ.

Бизнесийн ололт амжилтыг илэрхийлсэн дүн зэргийг хананд хадаж хэрэггүй. Тэгж ажилчдаа дарамталж зовоолоо гээд тэндээс авч байгаа стресс шууд үйлчлүүлэгч рүү дамжин

борлуулалт улам буурах болно. Түүний оронд ажилчиддаа боломж олгож итгэл хүлээлгээрэй.

Өглөө ажлаа эхлэхээс өмнө ажилчидтайгаа гар гараасаа барилцан VD хийгээд үз. Ажилчидтай харилцаж байгаа бүх хүнийг хамгийн идэвхтэй үйлчлүүлэгч болгосны үр дүнд захиалга эрс нэмэгдэж аз жаргалтайгаар хашгиралдаж байгаа үзэгдлийг нүдэндээ харагдтал төсөөлөөрэй. Орой ажлаа дуусгахын өмнө ч бас тийм VD хийгээрэй.

R=VD бцлгээрээ хийх нь тусам цр дцн нь хурдан бөгөөд хүчтэйгээр илэрдэг юм. *R=VD* хэрэгжүүлэх тусам та хамгийн шилдэг болох болно.

Хэрвээ та бизнес хийдэг бол таны бүх биенээс ид шидийн хүч гарч уулзсан бүгдийг жинхэнэ фэнээ болгон өөрчилж байгаагаар төсөөлөөрэй. Зүгээр ийм төсөөлөл хийхийн төдийд л таны нүүр гэрэлтэх болно. Сэтгэлийн гүнээс гарч байгаа өөртөө итгэх итгэл нь хүнийг өөрчилдөг нь хууль билээ.

Бусад хүмүүс тантай уулзах тэр мөчид “Энэ хүнд итгэж болох юм байна” гэж бодох болно. Хүмүүс зөвхөн таны үйлчлүүлэгч биш бүр найз болохыг хүсэх болно. Тэгээд танилууддаа таныг танилцуулна. Хүний дотоод сэтгэлээс гарч байгаа өөртөө итгэх итгэл хүмүүсийн сэтгэлийг татдаг учиртай.

Иймэрхүү гялалзсан амжилтыг ганц хоёр өдөр амсаад дуусгавал харамсалтай. Тогтмол багаар бодоход 2 удаа цаг гарган *R=VD* хэрэгжүүлээрэй. Таны амьдралын хаалгыг алдмааргүй сайхан мөчүүд тогшин ирэх болно.



МУЖИЙ МӨРӨӨДӨЛ

ТЭМДЭГИЛ

Vivid



Part

03

Нууцлаг ил шигдийн захиалга.

Дэлхийд алдартай амжилтын эзэн Рокки Аиуки зургаар VD хийдэв зуршилтай. Дэлхийн хамгийн шилдэг нь болох Өмнөд Солонгосын дайт сур харваачид, Жек Николс, Арнольд Палмер болон Маггер Вууд нь дүрс дүглэвийн VD хийдэв зуршилтай. Харин та яаж VD хийдэв зуршилтай вэ? Хараахан тийш зуршил байхгүй бол алийг нь сонгомоор байна? Алийг нь ч сонгосон гэсэн санаж ав. Та зөвхөн таны нэгдэндээ харагдал мөрөөдөж төсөөлсөн тэр зүйлээ л авах болно.

Dream Realization

1. “ЧРР” ЗУРАГ АБИЦГААЯ

☛ NASA-ийн ГЭРЭЛ ЗУРГИЙН VD

NASA-аас анх сар руу хүн илгээхээр төлөвлөж байх үед болсон явдал. Дэлхийд нэртэй VD сургагч доктор Денис Уэйтлиг урьжээ. Сансарын нисгэгчид болон саран дээр буух ажиллагаанд оролцох бүх хүн сургалтанд хамрагдсан юм. Сургалт сарнаа явагч аюул осолгүй буцаж ирэх хүртэл үргэлжилсэн юм.

Тэр үед NASA нь асар том сарны зургийг хэвлэн Аполло ажиллагаатай холбоотой газар болгонд наасан байна. $R=VD$ гол шаардлага болох “нүдэндээ харагдтал”-ын тулд шүү дээ. Тэгээд үр дүн нь ямар байсан бол? Төлөвлөснөөсөө 2 жилийн наана сар руу хүн илгээж чадсан билээ (35).

$R=VD$ томъёо гэдэг маань нүдэндээ харагдтал ургуулан бодохыг шаарддаг. Гэтэл тэгж “нүдэндээ харагдтал төсөөлөх эсвэл ургуулан бодох” тийм амар биш.

Нүдээ аниад сэтгэлийнхээ гүнд гар утас бодоод үздээ. Өдөржин харж, гартаа барьж, хуруугаараа оролддог эд боловч яг тулаад ирэхээр нүдэндээ харагдтал ургуулан бодно гэхээр санаснаар болохгүй.

За тэгвэл энэ удаа интернетээс гар утасны зураг дэлгэцэн дээрээ татаад үз. Тэр зургийг хараад гар утасны зураг зурах гээд оролдоод үзээрэй. Хамаагүй илүү төсөөлөгдөж байгаа биз.

Зураг хараад төсөөлөн боддог хүн тэгээгүй хүнээс хэд дахин илүү ургуулан бодож чадах болно. Давтан хэлэхэд зургаар VD хийх нь зорилгодоо хэд дахин хурдан хүрэх боломжийг олгох болно. Дээр гарсан NASA-ийн жишээг хараарай. Зургаар VD хийсний хүчээр дэлхийн шилдэг эрдэмтэд, математикчид төлөвлөж байсан цагаасаа 2 жилийн түрүүнд зорилгоо биелүүлж чадсан юм.

☛ **Рокки Ауки түүний зурган VD**

Мерседес Бенц машин.

Outback стейк хаус.

Хувийн нисэх онгоц.

Макдоналдсийн 100 салбар.

Та эдгээрийг эзэмших боломжтой. Хэрвээ та нүдэндээ харагдтал төсөөлж чадах юм бол! Гэхдээ та эдгээрийг эзэмшиж чадахгүй л болов уу даа. Нүдэндээ харагдтал төсөөлж чадахгүй болохоор.

Тэхээр эдгээрийг зураг ашиглан өөрийн мэтээр ургуулан бодох юм бол ямар үйл явдлууд тохиолдох бол? Магадгүй Рокки Ауки шиг болох болно.

Одоогоос яг 50 жилийн өмнөх үйл явдал. Японы жирийн нэгэн мэргэжлийн боксчин Рокки Ауки Америк явжээ. Америк-Японы боксын нөхөрсөг тэмцээнд оролцохоор. Танил түүх сонсогдож байна уу?

Тэмцээнд ялагдсан Рокки Ауки Америкт үлдэхээр шийдэв. Дайнд ялагдсны ул мөр арилаагүй Японыг бодвол Америкийн хаана ч тэр амжилт амьдрал буцалж байсан болохоор тэр. Тэр хэнээс хаана $R=VD$ ба зургаар VD хийхийг сурсныг би мэдэж чадсангүй. Таны адил номноос танилцсан ч байж магадгүй.

Гэхдээ түүний амжилт олох хүсэл нь төсөөллөөс нь давсан хатуу хүн эсвэл үнэхээр үнэнч хүн байсан байх. Жирийн хүн бол “тийм байж болох л юм” гээд өнгөрөөд явчихаж болох “Зургаар VD хийх” гэдэгт чин сэтгэлээсээ итгэн бүхнээ дайчлан хэрэгжүүлсэн болохоор...

Тэрээр эхлээд роллс-ройстой болохыг хүссэн гэдэг. Амжилтын бэлэг тэмдэг нь болж чадах юм шиг санагдсан байна.

Тэр үед түүнд байсан мөнгө дөнгөж 400 доллар. Энэ нь роллс-ройс нэг өдөр түрээслэхэд ч хүрэхээргүй мөнгө байв. Гэсэн ч олон юм бодолгүй шууд л машин зардаг газарлуу явсан юм. Очоод хэдэн зураг авав. Машиныхаа урд, хойд,

баруун, зүүн талаас, жолоочийн суудал дээр жолоо барин сууж байгаагаар, тэгээд хажууд нь эзэн нь мэт инээмсэглэн зогсож байгаагаар. Тэндэхийн эзнийг яаж аргалж байгаад тэгж чадсан нь тодорхойгүй байгаа юм.

Дараа нь Рокки өөрийн гэсэн дэлгүүртэй болохыг хүссэн байна. Гуравдугаарт хувьдаа онгоцтой болохыг, тэгээд дэлхийн 100 том хотод салбар бүхий нэрийн дэлгүүр нээхийг хүсэж байв.

Эдгээр хүслүүд нь эхнийхээсээ аваад сүүлчийнх хүртлээ боломжгүй мөрөөдлүүд байлаа. Бодит байдлаас харахад мөрөөдөж ч болохгүй зүйлс байв. Харин тэрээр мөрөөдөх замыг сонгон авсан юм. Бүр нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөдөхийг шүү. Ингээд машины зураг авсан шигээ хувийн онгоцны үзэсгэлэн худалдаа гарсан газар очиж зураг аван, дэлхийгээр нэг нэрийн дэлгүүр нь байдаг брэнд дэлгүүрт очин зураг авсан гэдэг. Тэгээд дараа нь доорх үйлдлийг хийдэг болсон байна.

1. Байнга тогтмол цагт зургуудаа харан $R=VD$ хэрэгжүүлнэ.
2. Хаашаа ч явсан зургаа авч явна.
3. Зав гарах бүр зургаа дэлгэн нүдэндээ харагдтал ургуулан бодно.

Эцийн үр дүн нь ямар байсан бол? Venihana-аас (1964 оноос АНУ-аас эхэлсэн амталж шарсан махны хоолны газар. Одоо дэлхийн 100 гаруй томоохон хотод салбар нь байгаа) эхэлсэн амжилтаар роллс ройс унаж, хувийн онгоцоороо дэлхийг тойрон аялдаг хүн болсон юм (36).

Танд Рокки Аукигийн хүрсэн шиг амжилтанд хүрч чадахгүй гэх шалтгаан юу байна? Одоогоос 50 жилийн өмнөх Рокки Ауки болон өнөөдрийн таны байдлыг харьцуулаад үзээрэй. Англиар ганц үг олигтой хэлж чаддаггүй, ганцаараа үлдэж байсан Ауки. Ганц чадах юм нь байсан мэргэжлийн боксоо ч орхисон үе. Та эх нутагтаа байгаа учир хэл болон бусад асуудал алга. Яаж ч бодсон хамаагүй дээр байдалтай байгаагаа хүлээн зөвшөөрөх хэрэгтэй шүү. Энэ нь яг одоо ч

хамаагүй $R=VD$ нэг хэлбэр болох “Зургаар VD хийх”-ийг хүчтэйгээр хэрэгжүүлж эхлэх юм бол Рокки Аукигаас ч илүү амжилтанд хүрч чаднаа гэсэн үг шүү.

☛ Мочизуки Тошитака-ийн ГЭРЭЛ ЗУРАГ АШИГЛАХ АМЖИЛТЫН АРГА

Мочизуки Тошитака нь гэрэл зураг ашиглан VD хийхэд сургадаг мэргэжилтэн хүн юм. Түүний зааж байгаа арга нь тун хялбархан.

1. Мөрөөддөг зүйлийнхээ зургийг олж ав.
2. Зургаа үзэж байхдаа аль тэр тань таны гарт орсон байгаагаар мэдрэх. Заавал гартаа хийнэ гэж амлах. Байнга тэгэх ёстой.
3. Тэгэхэд хэзээ нэгэн цагт зурган дээрхи зүйл таных болох л болно.

Ингээд л болоо.

Жишээ нь машинаар явж байтал таны мөрөөдөж байсан байшинтай адилхан байшин тааралдах юм бол эхлээд зургийг нь авах, тэр байшин таных болж байгаагаар мэдрэх, заавал гэр байшинг өөрийн болгоно гэж шийдэх, зургийг байнга авч яван санах бүрдээ харж төсөөлөх юм бол тэр чинь үнэхээр таных болох болно гэсэн үг. Тэр бүү хэл хэрвээ энэ аргыг хичээнгүйлэн хийх юм бол өөр хичээл зүтгэл нэг их гаргалгүйгээр хүссэнээ авч чадна гэж баталж байна. Зурган дээр байгаа байшин машиныг хэн нэгнээс бэлгэнд авч ч болох шүү дээ.

Мочизуки Тошитакагийн “гэрэл зураг ашиглах амжилтын арга” түүний бүх амьдралаар гэрчлэгдэх учраас итгэж найдаж болно. Энэ аргаа хэрэглэхээс өмнө тэр өртэй, орон тооны цомхтголын нөхөн төлбөрөөс өөр орлогогүй, тэгээд эмэгтэй хүнээс “айдаг” нэгэн байлаа. Харин аргаа хэрэгжүүлж эхлээд 3 жилийн дотор жилд 120 саяын орлоготой, семинар хийдэг цэлгэр өрөө бүхий сайхан байшингийн эзэн, улсдаа нэрд гарсан бас мөрөөдөж байсан эмэгтэйтэйгээ учран гэрлэж чадсан байв.

Тэрээр бүх японоор аялан гэрэл зураг ашиглан амжилт олох аргаа заадаг бөгөөд өнөөдрийг хүртэл түүнийг дагаад бүтэлгүйтсэн хүн гараагүй юм.

☞ Гэрэл зураг VD ТОМЪЁО

Гэрэл зургаар VD жийх гэдэг нь R=VD аргын VIVID буюу нүдэндээ харагдтал гэдэг хэсгийг гүйцэт хангаж өгөхөд тус болох юм. Ингэнэ гэсэн үг.

1. Мөрөөдөж байгаа зүйлийнхээ зургийг олж авах. Тэр хүний чинь зураг байсан ч болно. Заавал өөрийнх нь зургийг нь авах хэрэггүй. Сэтгүүл дээр гарсан зураг байсан ч болно.
2. Хаа явсан газраа авч явах. Ширээн дээрээ тавьж, хөргөгчний хаалганд нааж, тэмдэглэлийн дэвтэртээ хавчуулан явах. Гар утсан дээрээ хадгалан компьютерийн дэлгэцэндээ тавих гэх мэт.
3. Зургаа харан аль эрт таных болсон юм шигээр мэдрэх. Зөвхөн ургуулан бодох биш өөр бусад мэдрэмжээ ч ашигласан болно. Тэгээд тэр мэдрэмжээ үгээр илэрхийлэх юм бол бүр сайн. Жишээ нь таны нэр дээр бичигдсэн 1 тэрбумын чектэй болохыг хүсэж байгаа бол яг тийм чекний зургийг олж аваад түүнийгээ харангаа ингэж хэлж болно. "Нэг тэрбум гайхалтай гэж бодсон чинь нэг хуудас цаасан дээр л багтдаг юм байна. Гэхдээ л сайхан үнэртэйг бас гартаа барихад сайхан мэдрэмж төрж байна шүү." гэх мэт.
4. Ингэсэн тохиолдолд арай хурдан өөрийн болгож чадах болно.

Мөрөөдсөн зүйлээ илүү хурдан өөрийнх болгохыг хүсэж байвал зургийг нь харангаа ингэж асуухыг санал болгож байна.

"Үүнийг өөрийн болгохын тулд би юу хийх ёстой вэ?"

Ийм асуулт таны зураг тархинд RAS ихээр ялгаран сурах чадвар, өөрийгөө удирдах чадварыг идэвхжүүлэгч

гормон) та хүссэн зүйлийнхээ төлөө бүхнээ дайчлахад туслана. Мөрөөдсөндөө, хүссэндээ хүрэхийн тулд ямар ч боломжийг алдахааргүй болгож чадна.

Жишээ нь та хамгийн шилдэг удирдагч болохыг хүсэж байгаа бол тийм хүмүүсийн 20 орчим зургийг цуглуулаад голд нь өөрийнхөө зургийг байрлуулан тэднийг арын фон болгоорой. Тэгээд түүнийгээ харан өөрөөсөө тогтмол ингэж асуугаарай.

“Би энэ хүмүүстэй мөр зэрэгцэн алхахын тулд одоо юу хийх ёстой вэ?”

Тэгэхэд таны байр байдал өөрчлөгдөх болно. Зүгээр зураг харан VD хийж байгаа хүнээс хэд дахин хурдан мөрөөдлөө биелүүлж чадна.

☛ Дүрс бичлэгийн VD АРГА

“Дүрс бичлэгийн VD” хийх нь зургаар VD хийхээс илүү хүчтэй нөлөөтэй байдаг байна.

Өмнөд Солонгосын байт харваачид дэлхийд тэргүүн байранд явдгаараа бахархдаг билээ. Эмэгтэйчүүдийн хувьд дэлхийн 5-р байр Өмнөд Солонгосын 80-р байртай тэнцдэг бөгөөд улсын шигшээд багтаж орох нь Олимпод алтан медаль авахаас хэцүү гэгддэг.

Төгс ялалт гэдэг үгнээс өөрийг мэддэггүй тэдний амжилтын ард сэтгэл зүйн тусгай бэлтгэл хэмээх сургуулилалт байдаг юм. Түүний нэг нь дүрс бичлэгээр VD хийх. Сөүлийн ИС-ийн Спорт Сэтгэлзүйн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтнуудын улсын шигшээ багийнханд зориулан хийсэн 7 мин 2 сек-ийн бичлэгийг үзэцгээе. Ийм дараалалтай байна.

1. Тамирчид стадион руу явах замд тааралдах дүр зураг. Тамирчдын сууж буух автобусны дотор тал, автобус явах зам, стадионы гадна байдал, стадион доторхи хувцасны өрөө, тамирчдын хүлээх өрөөг тэмцээний талбайтай холбосон хоолой, гэрэл цацарсан гарах хаалга зэрэг нь дарааллаараа гарна.

2. Тамирчид тэмцээний талбайтай холбосон гарцаар алхан гарч байхдаа биеэ барьж байгаа байдал. Энэ үед “Та нар чаднаа.” хэмээн урам өгсөн үг сонсогдоно.
3. Стадион дүүрэн үзэгчид харагдаж эхэлнэ. Алга ташилт, хөгжөөн дэмжигчдийн уухай сонсогдоно.
4. Гайхалтай сэргэлэн цовоо зогсож байгаа тамирчин өөрөө гарч ирнэ. Залгуулаад нумаа татаж байгаагаа харна.
5. Дараалан харвасан 12 сум байны яг голд нь оносон байгаа үзэгдэл гарна (37).

Нэг үе гольфийн түүхэнд хамгийн дээд амжилтуудыг PGA (5 удаагийн аварга, US Open 4 удаагийн аварга, Masters-ийн 6 удаагийн аварга, British open 3 удаагийн аварга, Grand Slam-ийн эзэн) тогтоосон Жек Никольз тэмцээнд орохын яг өмнө нь хийдэг байсан “Дүрс бичлэгийн VD” хүчээр ялагдашгүй байж чаддаг байсан гэж мэдэгдэж байсан гэдэг. Тэр нь өөр хэн ч биш өөрийнх нь хамгийн шилдэг цохилтын бичлэг байдаг байжээ.

Нэмж хэлэхэд домогт гольфчин Арнолд Палмер ба гольфийн хаан Тайгер Вуудс нар ч “дүрс бичлэгийн VD” тогтмол хэрэгжүүлдэг гэдэг.

Нэг бодоод үздээ. Нэг мин, нэг сек-ийг хайрладаг дэлхийд нэртэй алдартай тамирчид яагаад зориуд цаг гарган “Дүрс бичлэгийн VD” хийдэг юм бол? Хоёр шалтгаан байна. Жинхэнэ биеэрээ хийсэн сургуулилалтаас илүү үр дүнтэй болохоор, бас ялалт авчирч өгдөг болохоор тэр юм.

☛ Та ямар VD хийх зуршилтай вэ?

Сохор зоос ч үгүй эхлээд дэлхийн хэмжээний “Kyuosega International” Инамори Казуогоос агуу амжилтынх нь нууцыг асуухад ингэж хариулж байсан гэдэг.

“Агуу амжилтанд хүрэхийн тулд заавал амжилтанд хүрэх л болно гэсэн халуун хэцэл эрмэлзэл таны далд ухамсарын мухарт хүртэл шингэсэн байх ёстой.” (38)

Дэлхийн хэмжээнд хүрсэн саятнуудын үзэл бодолд тулгуурлан хэлэхэд, заавал амжилтанд хүрэх болно гэсэн хүсэл эрмэлзэл уг хүн сэтгэлийн гүндээ амжилт мөрөөдөх мөчид далд ухамсарын өнгөн хэсэгт хүрнэ. Зураг хараад ерөнхийд нь амжилт мөрөөдөх юм бол далд ухамсрын дунд хэсэгт нь хүрнэ. Дүрс бичлэг үзээд бодит байдлаас тасран мөрөөдөх юм бол далд ухамсрынхаа гүнд хүрч чадна.

Мэдээж зураг болон дүрс бичлэг хэрэглэхгүйгээр сэтгэлдээ төсөөлж байгаагаараа далд ухамсартаа нөлөөлж чадаад амжилтанд хүрч чадсан хүчирхэг хүмүүс ч байгаа.

Тэгээд хэн ч гэсэн 10 жилээс илүү $R=VD$ тогтмол хийж чадах юм бол амжилтанд хүрэх хүсэл эрмэлзлэл нь далд ухамсрын гүнд хүрэх л болно. Магадгүй та ийм төрлийн хүн юм билүү мэдэхгүй шүү дээ. 10-аас илүү жил тасралтгүйгээр $R=VD$ хийж чадах найдвар бүхий хүн. Гэхдээ тийм хүн биш юм бол, арай хурдан мөрөөдлөө биелүүлэхийг хүсэж байгаа бол зургаар эсвэл дүрс бичлэгээр VD хийгээрэй хэмээн санал болгож байна.

Дэлхийд нэрээ гаргаж чадсан Рокки Ауки нь гэрэл зургаар VD хийх зуршилтай байлаа. Дэлхийн дээд амжилт хийж чадсан Өмнөд Солонгосын байт сур харваачид болон Жек Никольз, Арнольд Палмер, Тайгер Вуудс нар дүрс бичлэгээр VD хийх зуршилтай байсан билээ.

Харин та ямар VD хийх зуршилтай вэ? Хараахан болж амжаагүй бол алийг нь сонгоё гэж бодож байна? Аль нь ч байсан гэсэн үүнийг санаж ав. Та зөвхөн өөрийн нүдэндээ харагдтал мөрөөдөж төсөөлж байгаа тэр зүйлээ л авах болно гэдгийг.

2. ЯВ! ХҮСЭЛ МӨРӨӨДӨЛ РҮҮГЭЭ

☛ Арнольд Шварценеггер ба БАЙРШЛЫН VD

Одоогоос олон жилийн өмнө болсон явдал. Австри улсад нэгэн хүү амьдардаг байлаа. Хэтэрхий сулбагар учир “Ясан хэдрэг” гэдэг хочтой түүний мөрөөдөл нь булчинлаг залуу болох байв. Тэхдээ бүр дэлхийн улс бүрийг төлөөлсөн булчин шөрмөстөнгүүд цуглардаг Mister Universe-д түрүүлэн ялагч болохыг хүсдэг байлаа.

Мэдээж амьдрал дээр итгэхэд бэрх л сонсогдож байгаа биз. Тийм болохоор хүмүүс хүүгийн яриаг сонсоод инээлдэж үл тоомсорлодог байж. Харин хүү биелэх боломжгүй бодит бус мөрөөдөл бодит болдог арга болох $R=VD$ мэддэг байв. Тийм учраас тэр өөрийгөө Mister Universe-д түрүүлж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлдөг байлаа.

“Чин сэтгэлээсээ хүсэх юм бол биелдэг” гэдэг үг 2 утга агуулдаг.

Эхнийх нь хүссэн зүйл бэлэг болон өгөгдөх.

Хоёр дахь нь хүссэнээ нь биелүүлж чадах чадвар болон өгөгдөх.

Бяцхан хүүгийн хувьд сүүлийнх нь өгөгдсөн байсан. Сэтгэлийнхээ нүдээр ургуулан бодож сэтгэлдээ харж байсан мөрөөдлийн дүрс бичлэг нь хүний хэрээс хэтэрсэн дасгал сургуулилалтыг тасралтгүйгээр хийж чадах чадвартай болгосон байна.

Ингээд хүү насанд хүрч хүсч байсан тэмцээндээ оролцох эрх олж авлаа. Ясан хэдрэг хочтой байсан хүү Австрийн хамгийн булчинлаг залуугаар тодрох нь тэр.

Mister Universe тэмцээний талбай дээр ирсэн залуу маань онцгой үйл хөдлөлүүд хийж эхэлсэн байна. Сав л хийвэл тэмцээнд түрүүлсэн хүн шиг поз үзүүлэн талбай дундуур алхална. Тэгснээ гэнэт зогсож хичээнгүйлэн нүдээ ани зогсоно.

Аль эрт тэргүүн байранд орсон байгаагаар өөрийгөө сэтгэлдээ ургуулан бодохын тулд.

Хэрвээ та тэр үед залууг харсан бол тэмцээн дуусаад үнэхээр аварга нь болсон байна хэмээн итгэхээр байсан юм. Түүний хийж байгаа үйлдэл тэгж бат итгэхээр байсан байна. Үнэхээр тэр чин сэтгэлийн хүч байсан уу, тэр аварга болж чадсан. Залуугийн хэрэглэж байсан тэр аргыг “байршлын VD” гэж нэрлэдэг.

Ингээд аварга болж чадсан залуу маань кинонд хүчээ сорихоор Холливуд руу явлаа даа. Энэ өгүүлбэрийг уншаад нэг л ой тойнд буухгүй байгаа биз. Гэсэн ч цааш нь сонсоорой. Мэдээжээр тэр шалгаруулалтанд тэнцэж чадаагүй. Тэглээ гээд сэтгэлээр унасангүй. Холливудын киноны зураг авалтын талбайгаар хэсэж, өөрийгөө Холливудын хамгийн алдартай жүжигчин болсон байгаагаар төсөөлж эхлэв. Бодибилдингийн тэмцээнд оролцсон үеийнх шигээ байршлын VD хийдэг аргаа ашиглан байж шүү дээ.

Залуугийн VD биелсэн. Та магадгүй энэ залуугийн тоглосон кино ядахнаа нэгийг үзсэн л байгаа. Түүний нэр Арнольд Шварценеггер, хамгийн алдартай цувралын нэр нь “Терминатор”.

Мэдээж тэр “байршлын VD” хийлээ гээд өнөөдрийн Шварценеггер болсон гэхэд арай тиймхэн биш гэж үү гэсэн асуулт гарч болох юм. Энэ тухай тэр өөрөө аль эрт ингэж хэлсэн байдаг юм.

“Хүцхэд байхаасаа л би нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөдөх юм бол биелнэ гэдэгт чин сэтгэлээсээ итгэдэг байсан. Түүнд эргэлзэж байсан удаа ч байхгүй. Тийм сэтгэл санааны байдал үнэхээр гайхамшигийг дууддаг юм. Би Mister Universe тэмцээнд анх оролцохдоо хэзээний түрүүлсэн байгаагаар өөрийгөө төсөөлөн тэмцээний талбайгаар идэвхийлэн хэсэж байсан. Цаашид явах замаа кино жүжигчнээр солихдоо ч яг адилхан арга хэрэглэсэн. Үр дүнд нь би мөрөөдөж төсөөлж байсан бүхнээ бодит амьдрал дээр авч чадсан билээ.”



Үүн дээр нэмж хэлэхэд Арнольд Шварценеггер түүний амжилтын нууцыг асуусан асуулт бүрд голдуу “байршлын VD”-ний тухай ярьдаг бөгөөд физик хичээл зүтгэлийн хүчийн талаар хэлж байсан удаагүй гэнэ. Магадгүй ийм мессежийг олон түмэнд хүргэхийг хүсдэг байж болох юм. *Яагаад ч бцтэхгүй гэгддэг зорилго ч гэсэн нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөдөх юм бол түүнд хүргэх физик хүчин зүйлцүд өөрсдөө бий болоод ирдэг...*

❧ Байршлын VD АРГА

$R=VD$ аргын нэг хэлбэр болох “байршлын VD” нь ямар нэгэн газар өөрийн биеэр очоод нүдэндээ харагдтал төсөөлөхийг хэлнэ. Таны мэдэж байгаагаар $R=VD$ томъёо нь “нүдэндээ харагдтал төсөөлөх” гэсэн гол шаардлагатай. Өөрөөр хэлбэл бодит юм шиг байдалд тулгуурлагдан үр дүн нь гарч ирнэ. Сэтгэлдээ төсөөлөх ба зургаар төсөөлөх нь бодит байдалд төсөөлөхийн хаана ч хүрэхгүй. Тэхээр энэ арга нь дээрхи 3 аргаас хамаагүй хүчтэй юм.

Онассис ба Уолт Диснейн жишээ үүнийг батлаад өгнө. Тэр хоёр хоёулаа л өөр өөрийн салбарт хаан болохыг хүчтэйгээр мөрөөдөж байсан. Тэгэхэд зүгээр л мөрөөдлийн хэмжээнд байгаад байлаа. Харин тэд нэг нь усан онгоцны зах дээр, нөгөө нь Холливудад очсноор жинхэнэ юм шиг төсөөлж чадахаар болж хүсэл мөрөөдөл нь ид шидийн юм шиг л биелж эхэлсэн. Маш хурдан бөгөөд тов тодорхойгоор.

Байршлын VD ийг ингэж ойлгож болно.

1. Мөрөөдөлтэй чинь холбоотой газарт очно.
2. Тэндээ хэсэг байж мөрөөдөл тань биелснээр хүчтэйгээр төсөөлнө.
3. Тэр газартаа байнга очиж VD хийх. Мөрөөдөл нь бодит болтол.

Байршлын VD-г ашиглан амжилтанд хүрсэн алдартнуудаас Эсти Лаудер байна. Тэрээр 3 дахь дүрмийг ягштал хэрэгжүүлж чаддаг байсан юм.

Тэр ганцаараа бүхнийг эхэлсэн. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэгч нь ч тэр, борлуулагч нь ч тэр ганцаараа байлаа. Тийм учраас бүтээгдэхүүнийх нь чанар нь гайхалтай байсан ч савлагаа нь тун тааруухан байдаг байв. Жирийн нэг саванд хийж таглаан дээр нь “Эсти Лаудер” гэсэн бичиг наахаас хэтрэхгүй байв. Мэдээж хүмүүс түүний бүтээгдэхүүний үнэ цэнийг мэдэхгүй байсан учир борлуулах газар байхгүй тэгээд үсчин энэ тэр газраар явж үнэгүй тарааж өгч байсан байна. Тэр үед түүний ганц хүсч байсан зүйл бол Флоренс Морис гэдэг эмэгтэйн удирддаг “Хаус офф Эш Блондиз” үсчин дотор гоо сайхны тасагтай болох явдал байлаа. Тэгээд тэрээр сард нэг удаа очиж өөрийнх нь гоо сайхны тасаг бий болж байгааг нүдэндээ харагдтал төсөөлдөг байсан гэнэ. Тэр хэзээ хүртэл мөрөөдсөн бол? Флоренс Морис түүнээс өөрийн амаар “Ийст 60-р гудамжинд шинээр нээгдэж байгаа манай салонд гоо сайхны тасаг ажиллуулах бодол байхгүй биз?” гэж асуух хүртэл мөрөөдсөн юм. Эхлээд алдартай салонд тасагтай болсныхоо дараа тэр өөрийн гэсэн хаант улсыг байгуулахыг мөрөөдөж эхэлсэн байна. Эсти Лаудерийн хаант улс, тэр нь Америк, Европ болон дэлхийн бүх алдартай их дэлгүүрүүд дэх Эсти Лаудерийн гоо сайхны тасаг байсан юм. Гэхдээ бодит байдал тийм амар байсангүй. Америкийн нэртэй их дэлгүүрүүд түүнтэй хувь хүнийх нь хувьд ч уулзахыг хүсэхгүй байлаа. Тэгэх тусам нь тэр улам шаргуу зүтгэж байв. Тэр дэлгүүрийн менежер болон бусад хариуцлагатай хүмүүс дээр очин өөртэй нь уулзах хүртэл хүлээгээд л хүлээгээд л байдаг байсан гэдэг. Тэгээд ихэнхдээ наймаас арван цаг хүлээсний эцэст уулзсан ч “Одоо боломжгүй байна. Дараа ирээрэй.” гэсэн хариу авдаг байсан юм.

Харин ингэж хүлээж байхдаа тэр юу хийдэг байсан байх гэж бодож байна? Түүний онцлог болох “Байршлын VD” хийдэг байсан.

Тэр их дэлгүүрийн сандал дээр суугаад сэтгэлийнхээ гүнд мянга мянган зураг зурдаг байлаа. Менежер нь баяртайгаар түүнд гоо сайхны тасаг бэлдэж өгөн бүтээгдэхүүнийг нь хэрэглэж үзсэн үйлчлүүлэгчдийн хооронд ам дамжин яригдаж,

худалдан авагчид усны цутгал мэт түрэн орж ирж байгаа зураг бодит болох хүртэл тогтмол зурдаг байсан юм (39).

Харин түүний мөрөөдөл бүхэн бүгд биелсэн гэдгийг мэдэхгүй хүн байхгүй байх.

❖ Ричард Пол Эвансийн БАЙРШЛЫН VD

Мөрөөдлөө маш хурдан биелүүлэхийг хүсэж байгаа хүмүүст байршлын VD хамгийн үр дүнтэй ашиглаж чадсан Ричард Пол Эвансийн аргыг санал болгомоор байна.

Ричард Пол Эванс зохиолч болохыг хүсдэг байлаа. Түүний мөрөөдөл нь дэлхийн хэмжээний бестселлер бичих байв. Тэрээр өөрийн мөрөөдөл биелж байгаагаар нүдэндээ харагдтал мөрөөдсний дараа хичээнгүйлэн бичиж байсан ч харамсалтай нь хэвлэлийн газруудын анхаарлыг татаж чадахгүй байжээ. Түүний гар бичмэлийг уншиж үзсэн редакторууд нэг хүн шиг “Эх нь дажгүй боловч борлогдох боломж харагдахгүй байна” хэмээн хэвлэхээс татгалзсан хариу өгч байв. Хэдэн жил дараалан ийм хариу авсан байлаа.

R=VD томъёогоор бол нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол биелэх ёстой. Гэтэл Ричардын сэтгэлийн гүн дэх зураг хэдэн жил өнгөрсөн ч биелэх шинжгүй байв. Энгийн нэг R=VD хэрэгжүүлэгч бол тэгсгээд болих л байсан болов уу. “R=VD нь бусад хүний хувьд биелдэг байж болох юм харин надад бол тохирохгүй юм шиг байна” гээд л. Арай онцгой хүн бол төсөөлөх аргыг нь арай өөрчлөн хэрэгжүүлээд цааш нь юмаа бичих байсан байх.

Харин Ричард үнэхээр онцгой хэрэгжүүлэгч байсан юм шиг байгаа юм. Өөрийнх нь VD бодит болохыг хүлээхийн оронд бодит байдал руу өөрөө нэвтрэн орж бодит байдлыг өөрийн VD болгон хувиргаж чадсан учраас тэр.

Өөрийнх нь мөрөөдөл биелэхийг тэсэн ядан хүлээж байсан нэгэн өдөр Бүх Америкийн Номын дэлгүүрүүдийн холбооноос Нью-Йорк Таймс бестселлерийн зохиолчдын гарын үсэг авах хурал зохион байгуулах гэж байгааг олж мэдсэн байна. Энэ тухай олж сонсонгуутаа тэр ийм бэлтгэл хийсэн байна.

1. Өөрийнхөө зардлаар номоо хэвлэв.
2. Номоо аваад цуглаан болох газар руу нисэн очсон.
3. Бестселлер зохиолчдын бүхээгний хажууд өөрийн бүхээгийг нээв. Мэдээж зохион байгуулагчаас авсан зөвшөөрөлгүй өөрийн дураар.

Тэгмэгц цуглаанд оролцогсод Ричардыг өөрсдийнх нь хараахан мэддэггүй нэртэй зохиолч гэж үзээд гарын үсгийг нь авахаар оочирлож эхлэв. Ингээд тэр өөрийн зохиолыг дэлхийн хэмжээний бестселлер гэж танилцуулан гарын үсгээ зурж өгсөн гэнэ. Нью-Йорк Таймс-ийн бестселлер зохиогчид ихэнх нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зохиолчид байдаг.

Харин Номын холбооныхны хувьд энэ нь байж болохгүй үзэгдэл байсан учраас тэд Ричардыг хаагаад явахыг шаардсан байна. Харин тэр ямар хариу барьсан бол?

“Ам цангаад байна. Хүйтэн уух юм нэг аягыг өгөөч” гэж хэлсэн гэдэг. Зохион байгуулагчид эвгүй байдалд орохоос өөр аргагүй болов. Ричард Пол Эвансын нүүр царай, хэл яриа, хувцаслалт, байгаа байдал харьцаа зэрэг нь үнэхээр нэр алдартай хүнээс ялгарахааргүй байсан учраас тэр. Өнөөг хүртэл дэлхийн хэмжээний зохиолчидтой байнга нүүр тулан уулздаг хүмүүс тэр зэргийг мэдэхгүй байна гэж байхгүй. Тэгээд ямар хүч нөлөөлснийг мэдэхгүй тэд түүнийг зүгээр орхиод хүссэн хүйтэн ундааг нь авчирч өгчээ. Тэгээд бүр түүнд гарын үсэг зурахад нь тусалж, түүнийг дэлхийн хэмжээний зохиолчоор хүлээн зөвшөөрсөн байна.

Ричард Пол Эвансын төсөөллийг давсан байршлын VD-д онцлог үр нөлөө байсан. Дараа жил нь түүний “Зул сарын бэлэг” ном нь Нью-Йорк Таймсын бестселлерт 1-р байранд орж, далавчтай юм шиг л дэлхийн 18 улсын хэлээр орчуулагдан худалдагдсан учир юм (40).

Кино найруулагч Стивен Спилберг ч бас байршлын VD-г Ричард Пол Эвансын адил төсөөллөөс давсан байдлаар хийж амжилтанд хүрсэн жишээ юм. Өмнө бичсэн шиг Спилберг 9 жилийн турш R=VD хийнгээ кино найруулагч болохыг мөрөөдөж байсан ч биелүүлж чадаагүй байсан. Эцэст нь

тэр бодит байдлыг өөрийн VD-ээр эзлэхээр шийдсэн. Мөн л Ричардын адил өөрийн байхыг хүсэж байгаа газар болох Universal студид очсон. Тэр үнэхээр өөртөө итгэлтэй байсан учраас хэн ч түүнийг сэжиглээгүй. Тэр хоосон өрөө олж “найруулагч Стивен Спилберг” гэсэн хаяг хадмагц цэвэрлэгч нар өрөөг нь цэвэрлэж өгөн, харуулууд хамгаалдаг байв. Тэр өөрөө ч гэсэн найруулагч болсон гэж бат итгэсэн байсан учраас болж болох л асуудал байлаа.

Түүнд 7 хоногт 3 удаа өрөөндөө орж, найруулагч шиг хувцаслан зураг авалтын талбайгаар эргэлдэн жинхэнэ кино найруулагч болсон байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлөхөөс өөр хийх ажил байсангүй. Universal студид байрлан байршлын VD хийж эхэлснээс хойш яг 2 жилийн дараа өөрийнхөө киног кино театрт гаргах боломжтой болж чадсан юм.

Хэрвээ Стивен Спилберг Universal руу очоогүй тэнд R=VD-г хийгээгүй бол юу болох байсан бэ? Магадгүй мөрөөдөл нь биелэх хугацаа нь хоёр юмуу гурав дахин сунах байсан болов уу.

☛ Байршлын VD-г ХЭРЭГЖҮҮЛЭЭРЭЙ

Та юу хүсэж мөрөөддөг вэ? Тэр мөрөөдлөө биелүүлэхийн төлөө юу хийж байгаа вэ?

Чин сэтгэлээсээ хүсэх юм бол биелнэ гэдэг үгийн “Чин сэтгэлээсээ” гэдэг үг маш өргөн утга агуулж байгаа юм. Тэдний нэг нь таны үнэхээр байхыг хүсэж байгаа тэр газарт очоод бүхий л сэтгэлээ дайчлан R=VD хэрэгжүүлэх гэдэг утга орж байна.

Таны мөрөөдөл хамгийн шилдэг удирдагч болох явдал уу? Тэгвэл тийм болохын тулд физик хүчин зүйлийг ашиглан тогтмол цаг гарган тэр захирлын оффист оч, үз. Тэгээд тэр оффисын эзэн болсон байгаагаар өөрийгөө бүр нүдэндээ харагдтал төсөөл. Тэр компанид очсон зочид таныг тэндэхийн захирал гэж андууран “Захирлаа” гэж дуудан яриа өдтөл, ажилтнууд нь таныг даргаа гэж хүндлэн мэндэлтэл итгэлтэйгээр биеэ авч явах ёстой шүү.

Таны мөрөөдөл хотын төвд байрлалтай олон давхар байшингийн эзэн болох уу? Тэгвэл та тэр байшингийн эзэн болохын төлөөх физик хүчин зүйлийг хийх, тэнд зориуд цаг гарган очоорой. Тэгээд тэр байшингийн эзэн болсон байгаагаар өөрийгөө нүдэндээ харагдтал мэдрэх хэрэгтэй. Давхар бүрт таньтай таарсан түрээслэгчид таныг хараад шууд эзэн нь гэж андуурахаар.

Таны мөрөөдөл та өөрийн хүчээр боломжгүй гэж санагдахаар тийм хүнтэй танилцан үерхэж улмаар хуримлах уу? Тэгвэл тэр хүндээ ухаалгаар ойртон очиж ийм VD хийгээрэй. Түүнтэй хайр сэтгэлийн холбоотой болон хамт очиж үзмээр байгаа газрууддаа тогтмол очоорой. Тэгээд хамт байхдаа хийхийг хүсэж байгаа бүхнээ нүдэндээ харагдтал сэтгэлдээ зурах. Үнэхээр тэр хүн хамт байгаа мэтээр ярьж, мэдэрч, үйлдэх. Хуримаа хийхийг хүсэж байгаа газраа очиж хуримлаж байгаагаар нүдэндээ харагдтал ургуулан төсөөлөх. Бүр аль эрт хуримаа хийчихсэн ч гэсэн сая хажуугаар нь өнгөрөхдөө түр ороод гарч байгаа юм шиг мэдэрч, хэлж, үйлдэх.

Хэрвээ та чин сэтгэлээсээ тэгж мэдрэн, хэлж ярин, үйлдэх юм бол үнэхээр тийм болох болно.



3. ХЭЛЖ ЯРЬЖ БАЙГАА ЧИНЬ БОДИТ БОЛНО

Чангаар хэлж VD ХИЙХ АРГА

1990 онд хэвтэрт байгаа ээжийгээ харж байсан нэгэн залуу 50 долларын хуучин машин унан Калифорнид байдаг гэрээсээ Холливудыг чиглэн явжээ. Алдартай жүжигчин болж ээжийгээ сайн асрахын тулд. Тэгэхдээ бодит байдал тийм хялбар байсангүй. Гуйлагчин болоод л дууслаа. Өдөрт ганц гамбургерийг 3 хувааж идэн гудамжинд хонон цэцэрлэгт хүрээлэнгийн бие засах газар гар нүүрээ угаан өдөр хоногийг өнгөрөөнө.

Усанд унасан хүн ийм 2 замын нэгийг сонгодог нь бичигдээгүй хууль. Зүгээр л шууд живж үхэх, эсвэл өвснөөс ч хамаагүй зууран сарвалзах. Залуу хүү хоёр дахь замыг сонголоо. Өөрийн хүчээр жүжигчин болох мөрөөдлөө биелүүлэх боломжгүйгээ ухааран өөр хүчийг ашиглахаар дуудсан байна. Хадан цохионы ирмэгээс нисэхийн даваан дээр ийм юм гэж юу байдаг юм гэж бодож байсан нэгэн ярианд чин сэтгэлээсээ итгэн хэрэгжүүлж эхэлсэн байна.

Тэрээр шөнө болгон Холливуд тэр чигээрээ харагддаг уулан дээр гардаг байжээ. Тэгээд хотыг харангаа хоёр гараа савлуулан ингэж хашгирдаг байсан байна.

“Энэ хотын бүх хүн надтай хамтран ажиллахыг хэцэж байна!”

“Би сайн жүжигчин. Үнэхээр сайн жүжигчин!”

“Би хамгийн шилдэг кино найруулагч нарын хийх гэж байгаа бүх л кинонд тоглох санал авч байна!”

Үргэлжлүүлээд өөрийнх нь хэлж байгаа бүхэн биелж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлнө.

Кино жүжигчин Жим Керригийн нэрд гараагүй байхдаа хийдэг байсан VD-г “Яриан VD арга” гэж нэрлэж болно.

Иймэрхүү байдлаар хийнэ.

1. Мөрөөдөл тань биелж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлнө.
2. Мөрөөдөж байгаа зүйлээ үгээр илэрхийлнэ. Мөрөөдөл тань биелж байгааг нүдээрээ харж байгаа юм шиг тодорхойгоор илэрхийлнэ. Хэрвээ ингээд дутагдалтай санагдаж байвал эхлээд цаасан дээр бичнэ тэгээд чангаар уншина.
3. Хэлж байгаа чинь замхрахаас наана дахин нүдэндээ харагдтал төсөөлнө.
4. Өдөр бүр 30 минут дээрхийг давтана. Зөвхөн ганцаараа байхдаа хийх нь хангалтгүй тул мөрөөдлөө биелүүлэхийг хүсэж байгаа газраа очоод хийх нь илүү үр дүнтэй.

Энэ аргыг хамгийн сайн ашигладаг хүний нэг нь "Samsung" группын босс И Кон Хүй юм.

Түүний удирдлаганд ажилладаг эрдэм шинжилгээний ажилтнуудын ярьж байгаагаар тэр ч гэсэн мөрөөддөг хүн гэнэ. Ажил дээрээ нэг их очдоггүй, хүмүүстэй ч уулздаггүй. Гэртээ суугаад ирээдүйг нүдэндээ харагдтал мөрөөддөг гэнэ. "Өмнөд Солонгосын хөрөнгөтний онолыг үүсгэгчид" энэ талаар ингэж хэлж байна.

"И Кон Хүй захирал мөрөөдөл төсөөллөөр дцүрэн одоо цагт амьдардаг."

Тэрээр хүмүүсийн өмнө том дуугаар үе үе ингэж хэлдэг гэдэг. Удаан хугацааны туршид төсөөлсөн мөрөөдөл нэг л мэдэхэд амилан нүдний өмнө амьд амьтан мэт хөдөлж эхэлдэг. И Кон Хүй захирал болонгуугаа бүх ажилчдынхаа өмнө ийм мэдэгдэл хийжээ. "Samsung группын олох ашгийг 1 триллионд, ажилчдын цалинг одооныхоос 2-3 дахин нэмэгдүүлнэ." Тэр өөрийн группийн ирээдүйг нүдэндээ харагдтал төсөөлсний эцэст түүнийгээ тунхаглаж байсан бол түүний яриаг сонссон хүмүүс чихэндээ итгэхгүй байсан юм. Тэр үед группийн ашиг 200 тэрбумаас илүүгүй байсан гэдэг. Харин тун удалгүй түүний үг бодит байдал дээр биелсэн байна.

Эверлэнд хүүхдийн парк, Самсунг эмнэлгийн цогцолбор, гольфийн талбай, уран зургийн музей, хүүхдийн өдөр өнжүүлэх зэрэг ажлыг эхлэхэд ч мөн адил. Удаан хугацааны туршид нүдэндээ харагдтал төсөөлсний эцэст тэдгээр нь нүднийх нь өмнө амилан хөдөлсний дараа бүх ажилчдынхаа өмнө мэдэгддэг гэдэг. Үүнийг заримдаа И Кон Хүйгийн “мөрөөдлийн диваажин” гэж нэрлэдэг юм.

☞ Эхлээд хэл яриагаараа АМЖИЛТАНД ХҮРСЭН ХҮМҮҮС

Би яриан VD-г хэрэгжүүлэн амжилтанд хүрсэн хүмүүсийг судалж байгаад нэгэн сонирхолтой зүйлийг олж мэдсэн юм. Тэдний дунд Жим Керри шиг хүслээ чин сэтгэлээсээ зориуд хэлж байсан хүн тийм олон байсангүй. Харин хүслээ нэг их сүржигнэхгүй боловч нөгөө талаас нь харахад давилуун маягаар шууд хэлдэг хүмүүс олон байсан. Жишээ авч үзье. Мэдээж Жим Керри ч анхандаа ийм байгаагүй ч аажмаар өөрчлөгдсөн байх.

Ким Чол Ху

Киа автомашиныг бүтээгч. Тэр анх унадаг дугуй ч биш зөвхөн суудлыг нь үйлдвэрлэдэг байх үеэсээ л өөрийн хүслийг “Би дэлхийд нэртэй дээд зэрэглэлийн авто машины брэнд бий болгоно.” хэмээн тов тодорхой хэлдэг байжээ. Юу болоогүй царай гарган “Би хойтон нэг нас нэмнэ” гэж хэлж байгаа юм шиг л.

Сон Масаюши

Бага сургуульд байхдаа л яриан VD-г ашигладаг хүн байсан. “Би ирээдүйд заавал хэдэн арван мянган хүнийг удирдах болно.” гэж хэлэн ирээдүйгээ хүчирхэгээр төсөөлдөг байсан гэдэг. Зүгээр л бага сургуулийн сурагч “Хичээл тараад ээжийг чихэр авч хэлж өг гэнэ ээ.” гэж байгаа юм шиг л ярьдаг байсан гэнэ (41).

Жон Ванамэйкер

Их дэлгүүрүүдийн хаан гэгддэг хүн. Хүүхэд байхаасаа л хүмүүсийн өмнө өөрийгөө агуу худалдаачин болсон

байгаа дүрд тоглон үг хэлдгээрээ алдартай байсан бөгөөд үнэхээр үнэмшилтэй байдаг байсан учир хүмүүс огтхон ч эсэргүүцдэггүй байсан гэдэг.

Хонда Сойчиро

Хонда автомашины үйлдвэрийг үндэслэгч. Жижигхэн нүхэн үйлдвэртэй байх цагаасаа л ажилтнууддаа “Бид хэзээ нэгэн цагт дэлхийд №1 зэрэглэлийн мотоцикл үйлдвэрлэгч болох болно.” гэж хэлдэг байжээ. Тэгэх болгонд нь ажилчид нь ичиж нүүр нь улайдаг байсан гэдэг. Бодит байдлын үүднээс үнэхээр байж болшгүй зүйл боловч чин сэтгэлээсээ хэлж байгаа даргынхаа өөдөөс яалтай ч билээ дээ.

Морита Акио

Сони-г үүсгэн байгуулагч. Транзистор радио 10.000 ш-ийг ч зарж чаддаггүй байх үедээ Боллуба гэдэг том үйлдвэрээс 10.000 ш радионы захиалга авчээ. Гэхдээ Сони нэрээр биш тэр үйлдвэрийн нэрэн доор гаргах болзолтойгоор. Уг нь тэр захиалгыг хийвэл мөнгөний бэрхшээлээс гараад зогсохгүй овоохон мөнгө хийх боломж байсан боловч Морита нүүрний ямар ч хувиралгүйгээр ингэж хариулсан гэдэг. “50 жилийн дараа гэхэд манай компани танайхаас илүү нэрд гарсан байх болохоор татгалзаж байна.” (42)

Эдгээр хүмүүсээс 2 зүйлд суралцаж болно.

Эхнийх нь бат итгэлийн хүч. Тэдний мөрөөдлөө сүртэй биш энгийнээр илэрхийлж чаддаг нь тэр хэмжээгээр өөрийн амжилтыг эргэж буцалтгүй болох ёстой зүйл гэж хүлээн авч байгаа учраас тэр юм. Амжилт бат итгэлээс шууд хамааралтай. Амжилтандаа бат итгэлгүй байгаа хүн амжилтанд хүрэх алхам хийж чаддаггүй. Гарт нь ороод ирсэн боломжийг ч алдана. Эцэст нь бүтэлгүйтээд л дуусна.

Харин бат итгэлтэй байгаа хүний бүх үйл хөдлөл өөр байдаг. Боломжийг тэр дор нь шүүрэн авч чаддаг. Амжилтанд хүрэхийг хүсэж байгаа бол амжилтыг болох л ёстой зүйл хэмээн хүлээн авах ёстой юм шүү.

Хоёрдугаарт амжилтандаа бат итгэлтэй хүний байр байдал. Сэтгэл хөдлөм тансаг хоолны газарт ороход тэнд байгаа хүмүүс тань руу анхаарал хандуулахыг биеэрээ мэдэрсэн тохиолдол байгаа байх. Мэдээж сайхан мэдрэмж төрдөг шүү дээ. Амжилт ч бас түүнтэй адил. Хэрвээ та амжилтанд хүрнэ гэдгээ чин сэт-элээсээ мэдрээд бат итгэлтэй байгаа бол хажуудаа байгаа хүмүүст цаг үргэлж хэлэх болно. Би амжилтанд хүрч чадна гэж.

Үгэнд хүч байдаг. Найз нарын болон гэр бүлийнхээ өмнө “Би чадахгүй юм шиг байна аа” гэх мэт бүтэлгүйтлийн үг хэлээд байвал ялагдал бүтэлгүйтэл л ирэх болно.

Амжилт ч ярихгүй бүтэлгүйтэл ч ярихгүй бол жирийн л амьдрал угтана. Харин саяын жишээнд гарсан хүмүүс шиг аз, амжилт ярих юм бол амжилт бүр нисээд л ирэх болно. Тэгэхийн тулд хүмүүсийн өмнө юу болоогүй царайгаар “Би амжилтанд хүрнэ” гэж хэлж чаддаг байх хэрэгтэй. Цаад хүмүүс чинь юу ч гэж байсан хамаагүй.

Энэ хоёр сургамжийг дагахад хэн ч гэсэн амжилтанд хүрч чадна. Би үнэхээр та бүхнийг дээр гарсан хүмүүс шиг амьдраасай гэж хүсэж байна. Одоохондоо хэцүү байвал та өөрчлөлтийг төлөвлөн, амжилтыг дуудсан хэд хэдэн өгүүлбэр бичээд тогтмол 20-30 удаа давтал зүгээр. Мэдээж нь тэр нь биелж байгааг нүдэндээ харагдтал төсөөлөнгөө.

Жишээ нь “Би санаачлагатай хүн болох болно. Би захирал болох болно. Би аз жаргалтай хүн болох болно.” гэх мэтийн өгүүлбэрүүдийг бичиж болно. Энэ арга хүчирхэг үр дүнтэй. Та өөрөө энэ үгээрээ өөрчлөгдөж таны амьдрал ч өөрчлөгдөнө. Энэ нь шинжлэх ухааны үүднээс ч батлагдсан юм шүү. Ямар нэгэн үгийг тогтмол давтах юм бол уураг тархи тэр үгэнд итгэдэг. Тэгээд жинхэнээсээ түүнтэй холбоотой гормоныг ялгаруулдаг. Хэрвээ та “Би аз жаргалтай байна” гээд давтаад байх юм бол тархи аз жаргал мэдэрдэг гормон ялгаруулна. “Би амжилтанд хүрнэ” хэмээн давтах юм бол уураг тархи анхаарал төвлөрөх болон үйлдэх чадварыг сайжруулах идэвхжүүлэх гормонийг ялгаруулах болно.

АНУ Чикагод байдаг AON хэмээх байгууллагын үндэслэгч Климент Стоуны жишээг харахад тэр өглөө бүр бүх ажилчдын

хамтаар “Сэтгэл сайхан байна. Бие маань сэргэлэн цовоо байна. Нисмээр байна.” хэмээн хашгирч үнэхээр тийм байдалтай байгаагаар өөрсдийгөө төсөөлдөг байна. Тэгэхэд яадаг гээч? Тэдний үйл ажиллагаа асар хурдтайгаар хөгжсөн байна. Ажилчдынх нь тоо хэдэн арван мянгаар өсөж, Климент Стоун өөрөө тэрбумтан болсон (43). Өглөө бүр аз жаргалтайгаар ажлаа эхэлж байгаа захирлын удирдлаганд байгаа бүх албан хаагчид нь үйлчлүүлэгчээ инээмсэглэн угтаж ажлаа баяр хөөртэйгөөр хийсний ач юм.

☛ Таны өөрийн үгээр VD ХИЙГЭЭРЭЙ

Хэл яриагаар VD хийх аргыг хэрэглэн ядуу хүмүүсийг баян болгож чадгаараа алдартай Катерин Фонд гэдэг хүний яриаг сонсоцгооё. Түүний сургалтанд суусан нэгэн гэрийн эзэгтэй хэдхэн жилийн дотор эмнэлгийн тоног төхөрөөмжийн томоохон компанийн захирал болж, хөрөнгийн биржийн брокер байсан хүн ашгаа 4 дахин нэмэгдүүлж, 100 мянган \$ ийн төсөвтэй барилгын засвараас илүү орлоготой ажил олж чаддаггүй байсан барилгын компаний дарга тэрбум давсан төсөвтэй ажил хийдэг болсон зэрэг амжилтанд хүрсэн байна.

Катерин Фондын аргын нууц нь юунд байна вэ? Тухайн хүн өөрийнхөө хүсэл мөрөөдөл биелж байгааг нүдэндээ харагдтал төсөөлөн өдөрт 3 удаа 5 минутийн турш чангаар хэлэх ёстой гэнэ (44).

Сурган хүмүүжүүлэгч сэтгэл зүйч доктор Пол Крег, Жон Демартинийн жишээгээр “хэлж ярин VD хийх” аргыг хэрэгжүүлэх юм бол хэн ч гэсэн гайхамшиг гэмээр амьдралын өөрчлөлтийг биелүүлэх боломжтой гэдгийг баталж байна.

Долоон настайдаа сурах чадваргүй гэж дүгнэгдэн, 14 насандаа сургуулиа хаяж, 17 настайдаа эмэнд мансуурагч болсон Жон Демартини мэдэх болсон цагаасаа доктор Крег түүнийг эмчлэнгээ өдөрт хэдэн арван удаа “Би суут ухаантан. Би өөрийн цэцэн мэргэн ухааныг ашигладаг.” гэсэн өгүүлбэрийг чангаар уншуулан төсөөлүүлдэг байсан байна. Жон яасан гэж бодож байна? Хюстон ИС-ийг төгсөж, докторын зэрэг

хамгаалан, 54 төрлийн сургалтын программ зохиож, 13 ном бичин, дэлхийд алдартай илтгэгч болсон байна (45).

Пол Крег докторын хэмжээний алдартай доктор Прескотт Лекки “Хэлж ярин VD хийх” аргаар тааруухан сурлагатай байсан олон зуун хүүхдийг онц сурлагатан болгон өөрчилж чадсан байна. Жишээ нь англи хэлний шалгалтандаа унасан сурагчаа “Би англи хэл дээр зохиол бичин утга зохиолыг шагнал авах болно.” гэж давтан хэлүүлж VD хийлгэсний үр дүнд үнэхээр шагнал авч чадсан ба бас нэг сурагч нь сурлагаасаа болон сургуулиасаа хасагдсан сурагчаа “Би бүх хичээлдээ А авах болно” гэж хэлүүлэн VD хийлгэсний дүнд Колумбийн ИС-ийг улаан дипломтойгоор төгсөж чадсан зэргийг дурдаж болно (46).

Эдгээр 3 хүн хэлж ярин VD хийх арга амьдралыг өөрчилж чадна гэдэг үнэнийг гэрчилж чадаж байна.

Ингээд Жим Керрийн тухай яриагаар дүгнэлт гаргацгаая.

1990 оны Жим Керри ба та хоёрыг харьцуулцгаая. Хэн нь амжилтанд хүрэх боломж нь өндөр харагдаж байна? Мэдээж та. Хэрвээ та 1990 онд өглөө бүр паркийн нийтийн жорлонд гар нүүрээ угаадаг байсан биш л юм бол.

Гэтэл байдал яагаад шал эсрэгээр байгаа юм бол? Яагаад та байсан хэвэндээ, харин Жим Керри дэлхийн хэмжээний амжилтанд хүрч чадсан юм бол?

Олон зүйл дээр ялгаа байгаа. Гэхдээ тэдгээрээс ялангуяа Жим Керрийн өөрийн амжилтын нууц гэж нэрлэсэн “хэлж ярьж VD хийх” гэдэг талаас харах юм бол хамгийн том ялгаа нь энд байгаа юм. Тэр 17 жилийн турш энэ томъёог тогтмол үнэн сэтгэлээсээ хэрэгжүүлсэн, харин та тэгээгүй.

10 жилийн цаадах ирээдүйгээ төсөөлөөд үз дээ. Жим Керри нь ирээдүйн 10 жилийн турш одоог хүртэл хийж байснаасаа улам илүү үнэнчээр, халуунаар “хэл яриан VD-гээ хийх” болно. Харин та эсрэгээр нь хийхгүй. Өнгөрсөн цаг хэмээх толинд харах юм бол шүү дээ.

Энэ ялгаа нь танд болон Жим Керрид тус бүр ямар ирээдүйг авчирах байх гэж бодож байна?

4. БИЧ ТЭГЭЭД УНШ

☛ Клинтоны хийдэг VD ТУСГАЙ АРГА

Уилльям Жефферсон Клинтон XX зууны хамгийн их амжилтанд хүрсэн хүмүүсийн нэг билээ. Тэрээр ядуувтар гэр бүлээс гаралтай ч 32 насандаа мужийн ерөнхийлөгчөөр сонгогдон АНУ-ын түүхэнд хамгийн залуу сонгогдогчийн дээд амжилтыг тогтоож, жирийн улс төрчид яг л гараагаа эхэлж байх 46 насандаа дэлхийн улс төрийн ноён оргил гэж хэлж болохоор АНУ-ын ерөнхийлөгчийн суудалд хүрч чадсан юм. Ийм амжилтанд хүрч чадсан хүн дэлхий дээр хэд байгаа билээ?

Түүний бичсэн “Миний амьдрал” номны эхний хуудсанд ингэж бичсэн байдаг.

*“Хуулийн сургуулийг дөнгөж төгсөн жинхэнэ амьдарлын амтыг цэмээр халуун сэтгэл оргилж байсан залуу насандаа унших дуртай тцүх болон зохиолын номнуудаа тцр орхин арай өөр төрлийн нэг ном худалдаж аван уншсан юм. Эллен Ларкины “Цаг ба амьдралыг захирах арга **How to get control of Your time and Your life**” гэдэг ном байсан юм. Энэ номны гол агуулга нь богино, дунд, урт хугацааны амьдралын зорилгыг дараахи байдлаар чухлын зэрэглэлээр нь ангилаад цз гэсэн байлаа. А хэсэгт хамгийн чухал зцйлс, В хэсэгт тцүцний дараа орох зцйлс, С хэсэгт сцүлд орох зцйлсийг бичээд зорилго бцрт тцүнд хүрэхийн түлд хийх ёстой ажлыг ерөнхийд нь бичих ёстой. Би 30 жил орчим өнгөрсөн ч гэсэн одоо болтол тэр номыг хадгалсаар байдаг.*

Тэр цед зорилгоо бичиж байсан цаас хаа нэгтэй байгаа л байх. Харин А хэсэгт бичсэн зорилгуудыг би одоо ч гэсэн сайн санаж байна.”

Клинтон АНУ-ын ерөнхийлөгчөөр 2 ч удаа сонгогдож байсан хүн бөгөөд буусан ч гэсэн бүх дэлхийд онцгой нөлөөтэй хэвээр байгаа билээ. Ийм мундаг хүн яагаад өөрийн дурдатгалын эхний хуудсанд “зорилго”-оо бичсэн тухайгаа бичиж байгаа юм бол?

Түүний дотор л ороод гарахгүй л юм бол хэн ч тодорхой шалтгааныг нь мэдэх боломжгүй. Гэхдээ хар ухаанаар дүгнэж болно. Клинтон өөрийн хүрсэн гайхамшигт амжилтууд нь “зорилгоо бичих юм бол биелнэ” гэсэн утга агуулсан нэг номноос эхэлсэн гэж хэлэхийг хүсэж байгаа юм биш үү?

1953 онд болсон явдал. АНУ Yale ИС-ийнхан төгсөгчдөөсөө амьдралын зорилго ба түүндээ хүрэх төлөвлөгөө бичсэн цаас байгаа эсэхийг асуухад нийт төгсөгчдийн 3% нь тийм гэж хариулсан байна. 20 жилийн дараа 1973 онд, 1953 оны төгсөгчдийг хамруулан судалгаа явуулжээ. Тэр үед зорилго төлөвлөгөө байгаа гэж хариулж байсан 3% үлдсэн 97%-аас илүү дүүрэн аз жаргалтай амьдралаар амьдарч байгаа гэсэн хариу гарсан байна. Санхүүгийн хувьд бүр гайхмаар дүн гарсан байна. Тэр 3%-ийн эзэмшдэг хөрөнгө нь нөгөө 97%-ийн бүх хөрөнгийг нийлүүлснээс ч их байсан байна.

USA Today 2002 оны 1 сард 1953 оны Yale ИС-тай адилхан судалгаа явуулсан байна. Уншигчдаасаа ирэх шинэ оны төлөвлөгөөний тухай ярилцлага авахад шинэ оны төлөвлөгөөгөө бичдэг хүмүүс болон толгойдоо хадгалдаг хүмүүсээр ялгах боломжтой байжээ. 1 жилийн өнгөрсний дараа 2003 оны 2 сард харин ийм дүгнэлтэнд хүрсэн байна. Төлөвлөгөөгөө бичиж тэмдэглэдэг хүмүүсийн биелэлт нь тэгдэггүй хүмүүсийнхээс 1100% өндөр байсан гэнэ (47).

Клинтон 1973 оны хавар Yale ИС-ийн Хуулийн ангийг төгссөн юм. Тэрээр 1953 оны судалгааны дүнг сургуулиа төгссөний дараа олж мэдсэн юм шиг байгаа юм. Тэгээд л шууд зорилгоо бичих аргын тухай ном болох Эллен Ларкины “Цаг ба амьдралыг захирах арга” хэмээх номыг худалдаж аван өөрийн амьдралын зорилгыг бичсэн бололтой. Амжилтын эзэд бусдаас

арай л өөр байдаг юм. Тэд чихээрээ сонссоноо шууд л ажил хэрэг болгодог.

Гэтэл энд нэгэн сонин асуулт гарч ирж байна. Зорилгоо цаасан дээр бичих тэмдэглэхийг тэгж их чухалчлаад байсан Клинтон яагаад “Тэр үед зорилгоо тэмдэглэсэн цаас хаа нэгтээ байгаа” гэж хэлсэн юм бол? Түүний энэ үг нь тэрээр тэр зорилгууддаа хааш яаш хандаж байсан гэсэн ойлголт өгөхөөр байгаа биз. Харин түүний номны сүүлийн хуудсан дээрхи өгүүлбэрийг унших юм бол ойлгомжтой болно.

“Одоо миний тухай яриа руу орё. Би одоо ч гэсэн залуу насандаа зохиосон амьдралын зорилгодоо хүрэхийг хичээн амьдарч байна.”

Үүнээс бид дүгнэлт хийж болно. Клинтон “цаасан дээр зорилгоо бичих дадал” нь ИС төгсөөд, экс ерөнхийлөгч болсон өнөөдөр ч гэсэн үргэлжилж байна. Зав гарах бүрийдээ зорилгоо шинэ цаасан дээр бичдэг учир 30 жил өнгөрсөн өнөөдөр тэр хуучин цаасыг хадгалаад байх шаардлага байхгүй.

Харин Клинтон үгийг залуу цагтаа зохиосон амьдралын төлөвлөгөөнүүдийг шинэ цаасан дээр үргэлжлүүлэн бичсээр тэдэндээ хүрэхийн тулд одоо ч хичээж байгаа гэсэн утгаар хүлээж авахад болно. Ийм дүгнэлт нь Клинтон $R=VD$ ийн мэргэжилтэн учраас гарах боломжтой юм. Тэр бага сургуульд байхдаа л “Би ерөнхийлөгч болох болно.” гэж яридаг байсан бөгөөд өсвөр насандаа Кеннеди ерөнхийлөгчтэй авахуулсан зургаа харан Цагаан ордны эзэн болсон байгаагаар төсөөлдгөөрөө алдартай байсан аж. Ингээд дүгнээд үзэх юм бол Клинтон бага сургуульд байхдаа “Хэлж ярих VD ”, 15 настайгаасаа “Зургаар VD хийх” тэгээд 27 настайгаасаа “Бичиж VD хийх” аргыг хэрэгжүүлдэг байсан хүн байна.

☛ Бичиж VD хийх аргаар АМЖИЛТАНД ХҮРСЭН ХҮМҮҮС

Хүсэл мөрөөдөл нь биелж байгаагаар төсөөлөн бичихэд биелнэ гэдэг нь үнэндээ $R=VD$ аргын түгээмэл хэлбэрийн нэг

юм. Энэ аргаар мөрөөдлөө биелүүлж чадсан алдартнуудыг нэрлэе.

◆ **Жорж Вашингтон**

“Би гоо үзэсгэлэнт эмэгтэйтэй гэрлэх болно. Би Америкийн хамгийн баян хүү болно. Би цэрэг захирах болно. Би Америкт тусгаар тогтнолыг тогтоож ерөнхийлөгч нь болох болно.”

Агуу Америкийн эцэг гэгддэг Жорж Вашингтон 12 настай байхаасаа эхлэн ийм зорилго тавьж бичин нүдэндээ харагдтал төсөөлөн мөрөөддөг байжээ (48).

◆ **Брюс Ли**

“1980 он гэхэд би АНУ-д хамгийн алдартай ази жүжигчин болсон байх болно. Би 10 сая \$ хөлс аван кинонд тоглох болно.”

Брюс Лигийн өөрийн гараар бичсэн гар бичмэл Нью-Йорк Планет Холливодад хадгалагдаж байгаа гэнэ.

◆ **Битлз**

“Жон бид 2 дандаа л нэг тэмдэглэлийн дэвтэр бариад зэрэгцээд суудаг байлаа. Бүр ноорч гүйцсэн тэр дэвтрийг одоо хүртэл нандигнан хадгалдаг юм. Эхний хуудсан дээр нь “Леннон ба Маккартни оригинал” гэсэн гарчиг өгөөд л санаанд орсон бүхнээ бичдэг байв. Зай завсаргүй дүцрэн юм бичсэн байсан. Бид дараагийн үеийн хамгийн шилдэг хамтлаг гэсэн мөрөөдлөөр дүцрэн дэвтэр байлаа. Тэгээд бид тэр мөрөөдлөө биелүүлж чадсан билээ.”

Энэ бол Битлз хамтлагийн Пол Маккартний хэлсэн үг бөгөөд “Ихэмсэг захирал Битлз” номыг зохиогч Ларри Ленцийн номонд энэ тухай бичсэн байдаг. Мөн зохиогчийн бичсэнээр Пол Маккартни ингэж тунхаглан ярьдаг байсан тухай бичсэн байгаа.

“Мөрөөдлөө бичдэг зуриил маань Битлзийн амжилтад маш их үрэг гүйцэтгэсэн билээ.”

◆ **Скотт Адамс**

“Би сонинд цуврал комикс гаргадаг алдарт зохиолч болох болно.”

Комикс зохиолч болохыг хүсдэг ч үйлдвэрт ажиллах болсон Адамс өөрийн мөрөөдөл биелснээр төсөөлөнгөө 15 удаа тогтмол ингэж бичдэг байсан гэнэ. Тэгээд сонинд цуврал комикс хэвлүүлэх мөрөөдөл нь биелмэгц 15 удаа тогтмол “Би дэлхийн хамгийн шилдэг комикс зохиолч болох болно” гэж бичдэг болсон байна.

Өнөөдөр түүний комиксууд дэлхийн 2000 янзын сонинд гарч байгаа юм. Тэр одоо ч гэсэн 15 удаа тогтмол ингэж бичиж байгаа.

“Би Pulitzer шагнал авах болно.” (49)

◆ **Инамури Казио**

“Сарын борлуулалтаа 1 тэрбум иен хүргэж, бүгд хамтдаа Хавайруу аялцаа.”

Жилийн борлуулалт нь 500-600 сая иен байх үедээ Инамури Казио ингэж бичин самбарт компанийхаа үүдэнд хадаад бүх ажилчдын хамтаар нүдэндээ харагдтал төсөөлдөг байсан гэдэг. Сард 1 тэрбум иен хийх зорилго нь тун удалгүй биелж, энэ амжилтын гараа нь түүний компани группийн хэмжээнд хүрэх эхлэлийг тавьсан юм.”

☞ **Бичиж VD ХИЙХ АРГА**

Энэ арга нь тун хялбархан.

1. Мөрөөдлөө бичих дэвтэр 1-ийг гаргаарай.
2. Түүн дээрээ мөрөөдлөө бичээрэй.
3. Бичингээ, мөн урд нь бичсэн бүхнээ чангаар уншиж мөрөөдлөө биелж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлөх.

Ингээд л болоо. Арай илүү тодорхой тайлбар хэрэгтэй байгаа бол дахин тайлбарлая.

1. Мөрөөдлөө бичих дэвтэр ямар ч байж болно. Заавал тэмдэглэлийн дэвтэр байх шаардлага байхгүй. Календарь, дасгалын дэвтэр болон наадаг цавуутай өнгийн мемо цаас байсан ч болно. Компьютертоо Word ашиглаад бичсэн ч болно. Гол учир цаасандаа, дэвтэртээ байгаа юм биш мөрөөдлөө бичиж тэмдэглэх үйлдэлд байгаа юм.
2. Мөрөөдлөө аль болох их бичвэл сайн. 50 бүр 100 байсан ч хамаагүй. Биелээсэй гэж хүсч байгаа мөрөөдлүүдээ бүгдийг нь бичээрэй. Зоригтойгоор, шийдмэгээр бичээрэй. Тэгээд дэвтэрээ 3 хэсэгт хуваахыг зөвлөх байна. Эхний хэсэгт нь хувийн хүсэл мөрөөдөл, хоёр дахь хэсэгт нь гэр бүлийн төлөөх мөрөөдөл, гурав дахь хэсэгт улс эх орныхоо төлөөх мөрөөдлийг бичихийг зөвлөх байна. Ерөнхийдөө нэг удаа, эсвэл "Dilbert" комиксын Скотт Адамс шиг 15 удаа давтан бичдэг шиг тогтмол хичээнгүйлэн бичвэл бүр сайн. Тэгж хичээнгүйлэн олон удаа бичихэд үр дүн нь хурдан гардаг учраас тэр юм.
3. Тэгээд бичсэн зүйлээ өдөрт нэгээс олон удаа уншиж хүсэл мөрөөдлөө биелж байгаагаар нүднээ харагдтал төсөөлнө. Үнэхээр бүхий л таван мэдрэхүйгээ ашиглан төсөөлөөрэй. Мөрөөдөл биелэх хурд таны мэдрэх мэдрэмж, төсөөлөх төсөөлөл хэр бодиттой байж чадахаас шууд хамааралтай гэдгийг сайн санаарай.

Гэхдээ энэ аргыг хэрэгжүүлэхдээ анхаарах хоёр дүрэм байгаа.

Нэгдүгээр дүрэм нь хэн ч юу ч хэлсэн байсан гэсэн мөрөөдлийн дэвтэр дээрх бичсэн бүхэн заавал биелнэ гэдэгт чин сэтгэлээсээ итгэх ёстой. Энэ итгэлээ сахих нь танд ямар нэгэн хохирол учруулсан ч талархаж чадахаар байх ёстой. Ийм байдал нь мөрөөдөлдөө итгэдэг хүний хийдэг алхам бөгөөд мөрөөдөл ч яг ийм итгэлд хариу өгдөг юм шүү.

Олон жилийн өмнө болсон нэгэн явдал. Америкийн нэгэн ахлах сургуулийн багш ангийнхандаа том болоод биелээсэй гэж хүсэж байгаа мөрөөдлөө бичиж ирэх даалгавар өгчээ.

Хүүхдүүд ирээдүйн тухайн мөрөөдлөө хичээнгүйлэн бичээд багшдаа үзүүлсэн байна. Харин ангийн багшийн хувьд шал дэмий мөрөөдлүүд бичиж ирсэн байв. Мэдээж юугаа ч мэдэхгүй арван хэдтэнгүүд бичиж болох бүхнийг бичээ биз. Ингээд ангийн багшийн хувьд сурган хүмүүжүүлэгчийн оролцоо хэрэгтэй гэж үзсэн байна. Хүүхдүүдэд бодит байдлыг олж харах нүдийг нь нээж өгөх хэрэгтэй гэж үзсэн байжээ. Дэвтэр дээр нь хийсвэр мөрөөдлийнх нь алдаануудыг бичээд буцаан тарааж өгөв. Хүүхдүүд мэдээж мөрөөдлөө багшийнхаа санаанд тааруулан шинээр бичсэн байна. Ар гэрийнхээ байдал, сурлагын дүн зэрэг бодит байдалдаа тааруулан шууд биелж болохоор зүйлсүүдийг л зөвхөн бичээд өгсөн байна. Багш нь нэг хүүхдээс бусдад нь А болон А+ тавьжээ.

Гэтэл Монти хэмээх нэгэн хүү л нэг үг ч солилгүй хэвээр нь буцаагаад өгсөн байж. Түүний дэвтэрийн эхний хуудсанд ингэж бичсэн байсан байна.

“Би 200 акр талбайтай фермтэй хүн болох болно. Тэгээд уралдааны морь сургагчдыг хөлслөн ажиллуулах болно. Бас цэвэр thoroughbred цүлдрийн морьд өсгөж үржцүлэх болно.”

Үргэлжлүүлээд фермийг агаараас харахад ямар байхыг нүдэнд харагдтал бичээд, дараа хуудсанд нь нарийн бүтэц зохион байгуулалт, тэнд өсгөх гэж байгаа морьд болон ажилчдын тоо зэргийн тухай ерөнхийд нь бичсэн байжээ. Иймэрхүү маягаар бүтэн 7 хуудас дүүрэн өөрийн ирээдүйн эзэмших фермтэй холбоотой бүхнийг нэг бүрчлэн бичсэн байна.

Багш хэлэх үгээ олж ядав. Бүр өөрийг нь үл тоомсорлоод ч байгаа юм шиг санагдан уур нь хүрч шавьдаа хүйтнээр ингэж хэлжээ.

“Монти, би чиний сэтгэлийг ойлгож байна. Би ч гэсэн чиний насан дээр том том юм л мөрөөдөж байсан. Гэхдээ, мөрөөдөл гэдэг чинь биелдэггүй болохоор л мөрөөддөг байхгүй юу. Чи өөрийн байгаа байдлаа нэг хардаа. Чи аавтайгаа хамт ачааны машины амбаарт

амьдарч байгаа биз дээ. Аав чинь тогтмол ажилгүй энд тэнд олдсон бүхнийг хийгээд л. Тийм байж юугаараа фермтэй болох гэсэн юм бэ? Чи хаанаас юун мөнгөөрөө хурдны морьд авч ажилчдаа цалинжуулах гэж байгаа юм? Зуун удаа бодоод үзсэн ч бүтэхгүй зүйл. Ийм юм болно гэж хэзээ ч байхгүй. Багш нь дахиад нэг удаа боломж олгоё. Энэ бичсэнээ ураад шинээр мөрөөдлөө бичээрэй. Өөрийн байгаа байдалдаа тааруулаад эрцл ухаанаар бодсон, биелэх боломжтой тийм мөрөөдөл бич. Тэгэхгүй бол би чамд F өгөхөөс өөр арга алга даа. Үндэслэлгүй худлаа юм дүцрэн бичсэн ажилд чинь таарах үнэлгээ F учраас.”

Золоор Монти багшийн үгэнд орсонгүй. Өөртөө бат итгэлтэйгээр ингэж хариулжээ.

“Багш аа, би мөрөөдлөө бичээд нүдэндээ харагдтал төсөөлөх юм бол биелнэ гэдэгт итгэдэг. Тийм учраас надад F тавьсан ч болно. Надад сургуулиас өгөх дүн биш миний мөрөөдөл чухал.” Ингээд багш нь толгойгоо сэгсрэн Монтид F тавьсан байна.

АНУ Калифорнид “Flag is up Farms” гэдэг эдлэн байдаг. Ахлах сургуулийн сурагч Монтигийн мөрөөдлийн дэвтэр дээр бичигдсэнтэй бараг зөрүүгүй адилхан баригдсан энэ газрын эзэн нь мэдээж Монти билээ.

Хоёрдахь дүрэм нь мөрөөдлийн дэвтрээ үргэлж авч явах ёстой. Хэрвээ мөрөөдлөө бичиж байгаа дэвтэр чинь хэтэрхий зузаан учраас авч явахад хэцүү байгаа бол тэнд бичсэн зүйлсээ жижиг дэвтэр эсвэл цаасан дээр хуулж бичээд авч явж болно. Жижигхэн цаасан дээр бүх мөрөөдөл чинь багтаж байгаа бол түрийвчиндээ хийгээд явсан ч болно шүү дээ.

Хорвоо дээр байгаа бүхний адил мөрөөдөл ч гэсэн тэр өөрийг нь нандигнан хүндэлж байгаа нэгэн рүү татагдаж, өөрийг нь нэгэн бие мэт үзэж байгаа нэгний төлөө өөрийгөө золиослодог юм.

Олимпийн 10 төрөлтийн алтан медальт Брюс Женнер 1996 оны Атлантын олимпид оролцохоор бэлтгэл хийж байсан тамирчдад зөвлөлгөө өгч байхдаа ингэж асуужээ.

“Та нарын дунд мөрөөдлийн дэвтэр хөтөлдөг хүн байна уу? Тогтмол тэр дэвтэрт бичсэн мөрөөдлөө биелж байгаагаар нүдэндээ харагдтал төсөөлдөг хүн байна уу?”

Заал дүүрэн тамирчид бүгд гараа ярсхийтэл өргөв. Дахиад ингэж асуулаа.

“Тэгвэл яг одоо мөрөөдлөө цаасан дээр бичээд авч явж байгаа хүн байна уу?” Энэ удаа ганцхан хүн гараа өргөлөө.

1996 онд Атлантын олимпийн 10 төрөлтийн алтан медалийг авсан хүн Брюс Женнерийн сүүлийн асуултанд гараа өргөсөн Дэн Обрайн байсан юм (50).

Нэрт жүжигчин Жим Керри ч гэсэн энэ дүрмийг чандлан сахидгаараа алдартай юм.

Уртаас урт, хахир хатуу алдар нэргүй байх цаг үедээ тэрээр бичиж VD хийх аргын тухай олж сонсоод мөнгөний хоосон чек олж аваад ингэж бичсэн байна.

Төлбөр хийгдэх хугацаа: 1995 он талархалын баяр хүртэл.

Төлбөрийн хэмжээ: 10 сая доллар.

Төлбөр хийх газар: Холливуд кино компани.

Мөнгө авах хүн: Жим Керри.

Жим Керри энэ чекийг түрийвчиндээ хийгээд байнга гаргаж үзэн 10 сая доллар авч байгаагаар төсөөлдөг байсан гэдэг.

Жим Керри 1995 онд үнэхээр кинонд тоглосныхоо хөлс гэж 10 сая \$ авсан бөгөөд яг талархлын баярын өмнөхөн байсан юм. Киноны нэр нь “Маск” байлаа (50).



ТМТМТМТМ

.....
ТМТМТМТМТМ

1. ОЮУН САНААНЫ КИНО ТЕАТР ДОТОР ТӨСӨӨЛНӨ

☛ Кино үзүүлэх

Би америкийн иргэн баян хүн ч биш. Фортун 500-д багтах группын хэн нэгэн ч биш, дэлхийн шилдэг удирдагчдын холбооны хүн ч биш. Тийм болохоор хоёрхон хоногийн дотор биелдэг мэргэжлийн хэмжээнд хүртэлх амжилтын VD-ын талаар сайн мэдэхгүй. Мэргэжлийн VD хийх талаар сургалтанд сууж, заалгаж байсан удаагүй. Гэхдээ голыг нь мэднэ. Америкийн хамгийн шилдэг зөвлөхүүд нь *Америкт шилдэг байна гэдэг бол дэлхийд шилдэг гэсэн үг*. Өөрсдийн ном зохиолдоо маш тодорхой тайлбарласан байдаг болохоор сайн мэдэж байгаа юм.

Клод Бристол, Жозефф Мерфи, Максвелл Мальц, Жек Кенфилд, Жон Кехо, Энтони Робинс, Шакти Ковейн нарын зэрэг гарамгай амжилтын VD-ын мэргэжилтнүүд бүгд л оюун санааны кино театрын тухай *The Theater of Mind* ярьцгааж байна. Ойлгомж муутай нэртэй ч боловч үүнийг хийхийн тулд цаг, байр, сэтгэлээ л бэлдвэл болох нь тэр.

1. Тогтмол 30-аас доошгүй минут цаг гаргах хэрэгтэй. Хамгийн тохиромжтой цаг бол унтахын өмнө болон өглөө босонгуут байдаг. Өглөө босоод 15-30 минут, шөнө унтахаас 15-30 минутийн өмнө гэсэн үг. Заавал тэр цагт биш байсан ч болно. Чөлөөтэй сонгоорой.
2. Хэн ч саад болохооргүй ганцаараа байх газар хэрэгтэй. Тэр газар чинь түшлэгтэй сандал эсвэл ор байвал бүр сайн.
3. Үр дүнд нь чин сэтгэлээсээ итгэсэн сэтгэл, байнга бүх сэтгэл зүрхээ дайчлан хичээнгүйлэн хэрэгжүүлнэ гэсэн хатуу сэтгэлийн тэвчээр чухал.

☛ Ажиглах арга ба НЭГДЭХ АРГА

Оюун санааны киноны арга нь ажиглах ба нэгдэх гэж 2 хувааж болно. Энэ хоёр хоёулаа бие сэтгэлээ бүрэн суллахыг шаарддаг. Өөрөөр хэлбэл Сэтгэл оюунаа суллаж чадалгүй хийвэл үр дүн нь тааруухан байх магадлал байдаг юм.

Ингээд ажиглах аргын тухай үзэцгээе.

Энэ нь үндсэн ба зохиолын гэж 2 янз байна.

Үндсэн хэлбэрийг авч үзэе.

1. Та өөртөө хамгийн эвтэйхэн байрлалаар сандал дээр сууж эсвэл орон дээрээ хэвтэнэ.
2. Маш тайван инээмсэглэнэ. Нүдээ зөөлөн анина.
3. Сэтгэл оюунаа бүрэн дүүрэн суллаж өгнө.
4. Нүдээ аньсан чигээрээ томоохон хэмжээний дэлгэц сэтгэлдээ бий болгоно.
5. Дэлгэцэн дээрээ гол баатраа гаргана. Таны хүссэн бүхэн гол баатар болж болно. Жишээ нь хамгийн шилдэг захирал болсон та өөрөө, бенц машин, уулздаг болохыг хүсэж байгаа хүн чинь, эвлэрэхийг хүсэж байгаа хүн, ядуу хүмүүст туслан үйлчилж байгаа та, хүн төрөлхтөний төлөө идэвхи санаачлагатай ажиллаж байгаа та ч байсан болно.
6. Таван мэдрэхүйгээ ажиллуулан дэлгэцэн дээрээ бодит байдлыг бий болгох. Жишээ нь гүйцэтгэх захирал гол дүр бол албан тасалгааны дотор талыг бодитоор харах ёстой бол чихээрээ нарийн бичгийн даргын тайланг сонсон гар хуруу тань таны шийдвэрийг хүлээж байгаа бичиг баримтуудыг барьж байх ёстой. Хэрвээ бенц машин гол дүр болох бол машины өнгө, хаалга хаах, нээх чимээ зэргийг харж, сонсож, мэдрэх ёстой. Мөн та машины хаалгыг онгойлгон орж суугаад түлхүүрээ хийн асаагаад хаазан дээр гишгэж чадах ёстой.
7. Хүссэн үзэгдлээ дэлгэцэн дээр бий болгоод түүнийгээ дахин давтан үзэх.



Энэ бол Оюун санааны кино театр аргын үндсэн хэлбэр. $R=VD$ мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар тогтмол 30 минут үндсэн хэлбэрээр хийхэд л тун боломжийн үр дүнд хүрэх боломжтой гэсэн.

Зохиолын хэлбэр нь ийм юм.

1. Мөрөөдлийн кино зохиол гэсэн нэртэй нэг дэвтэр, мөрөөдлийн үзэг гэсэн нэртэй нэг үзэг бэлдэх.
2. Үзэхийг хүсэж байгаа киноныхоо зохиолыг бичих.
3. Мэдээж үндсэн хэлбэрийн аргыг ашиглана, гэхдээ бичсэн зохиолынхоо дагуу шүү.
4. Үзэж дуусаад эх бичмэлдээ нэмэлт өөрчлөлт хийнэ.
5. Нэмж өөрчилсөн зохиолоо үзнэ.
6. Бодит байдлаас ялгарахааргүй болтол хийсэн кино бий болтол 4 ба 5-р хэсгийг давтан хийнэ.

Оюун санааны кино театр аргын зохиолын хэлбэр. Энэ аргаар үндсэн хэлбэрээс илүү хурднаар мөрөөдөлдөө хүрэх сайн талтай.

Нэг талаас харахад Оюун санааны кино театрын нэгдэх арга нь түрүүн гарсан ажиглалтын аргатай бараг адил. Зөвхөн төгсгөлийн шатанд киног үзэж байгаа та кинон дотор орж, гарч байгаа гол дүр болох таньтай нэгдэн нэг хүн болох хэсгээр л өөр юм.

Жишээ нь ийм байж болно.

Таны мөрөөдөл Сөүл Каннамын төв хэсэгт 10 тэрбумаар үнэлэгдэх том барилгын эзэн болох тэгээд түүнээсээ олдог ашгаа ядууст туслах үйлст зориулах гэж бодъё.

Тэгэхээр та тухлан хэвтээд нүдээ анин таны мөрөөдөл биелж байгаа кадр бүхий киног үзнэ. Хамгийн сүүлд нь та зурагтаар мэдээ үзэх болно. Нэвтрүүлэгч инээмсэглэл гэрэлтсэн царайгаар мэдээ уншиж байна.

“Энэ удаа цээгч та бүхний сэтгэлийг дулаацуулах мэдээ хүргэх гэж байна. Энэ удаа ч гэсэн нэгэн цл мэдэгдэх ивээн тэтгэгч хүнд амьдралтай хүмүүст туслаарай хэмээн ихээхэн хэмжээний мөнгөний чек өгсөн байна.”

Харин кинон дотор мэдээ үзэж суугаа таны нүүрэнд үл ойлгогдох инээмсэглэл тодорно. Тэр өглөгийн эзэн та учраас тэр. Энэ үед үзэгчийн суудалд сууж байсан та огцом босон дэлгэцэн дундуур алхана. Тэгээд зурагтын өмнө инээмсэглэн сууж байгаа тантай нэгдэх болно. Нэг хүн болсон та зурагтаа унтраан сонин үзнэ. Тэгээд тусламж хэрэгтэй хүмүүсийг хайж олон нэрсийг нь дэвтэртээ тэмдэглэнэ. Дараа сард туслах ёстой хүмүүс учраас.

Энэ арга ажиглалтын аргаас илүү хүчтэй үр дүнтэй. Үүнийг ажиглалтын аргын сайжран хувирсан хэлбэр гэж үзэж болно.

☞ Сэтгэл оюунаа СУЛЛАХ

Сэтгэлийн кино театрын аргыг хэрэгжүүлэн зориудын үр дүнд хүрэхийн тулд юу юунаас илүү сэтгэл оюунаа бүрэн чөлөөлж чадах ёстой. Энэ аргыг та өөрийн далд ухамсартайгаа ярилцах гэж ойлгож болно. Орчлон ертөнцөөр ниг дүүрэн байгаа эгэл биетүүдийг физик биет болгон хувиргаж чадах хүч агуулсан бидний дотор оршигч далд ухамсарын хүчээ хэрэглүүлээч туслаач гэж хүсэх үйлдэл юм. Тэгэхээр та өөрийн оюун ухааныг бүрэн төгсөөр суллан хязгааргүй тайван байдалд оруулах нь чухал юм. Бидний бие сэтгэл хязгааргүй амар тайвныг олох үед бараг гипнозын байдалд орж далд ухамсар сэргэж эхэлдэг.

Сэтгэл оюунаа суллах энэ арга нь үндсэн ба гипнозын хэлбэр тэгээд цахилгаан шатны гэж хуваагддаг.

Эхлээд үндсэн хэлбэрийн тухай цэье.

1. Хамгийн аятайхан байрлалаар суух эсвэл хэвтээд нүдээ анина.
2. Өнөөг хүртэл амьдрахад тань хамгийн амар амгаланг мэдэрч байсан газраа санах.
3. 5-10 удаа хэвлийгээрээ гүн амьсгална. Дараахи 4 үе шаттайгаар амьсгалах. *Нэгдүгээрт*, Хэвлийгээ ашиглан хамраараа аль болох гүнзгий амьсгал авах. Энэ үед

хорвоогийн бүх л амар амгалан тоолшгүй олон бяцхан гэрлэн цэг хэлбэрт орон хамраар дамжин орж бүх биенд тархан шингэж байна гэж төсөөлнө. *Хоёрдугаарт*, Түр амьсгалаа түгжинэ. Удаан барих тусам сайн. Энэ үедээ дотор чинь дулаахан тайван гэрлээр дүүрсэн байна гэж төсөөлнө. *Гуравдугаарт*, Амьсгалаа амаараа аль болох уртаар гаргана. Энэ үед таны дотор байгаа бүхий л сөрөг сэтгэгдэл, санаа зовнил, зовлонгууд, муу өвчнүүд амьсгалаар гадагшилж байна гэж төсөөлнө. *Дөрөвдүгээрт*, Хамгийн амгалан тайвнаар ингэж хэлнэ. “Сэтгэл тайван байна, Үнэхээр тайван байна, Үнэхээр тайван байна.”

4. Ингээд ч тайвширч чадахгүй байвал хэвлийгээрээ амьсгалаад тунгалаг тод гэрлэн бөмбөлөг төсөөлөх. Энэ гэрлэн бөмбөлөг таны бүх бие сэтгэлээр дамжин эвгүй сэтгэгдэл айдас хүйдэс бүхнийг уусгаж байгаа үзэгдлийг төсөөлнө.
5. Сэтгэл доторхи кино эхэлнэ.

Гипнозийн хэлбэрийн тухай.

1. Хамгийн эвтэйхэн байрлалаар суух эсвэл хэвтээд нүдээ анина.
2. Таны төсөөлж чадах хамгийн амар тайвныг, дулааныг агуулсан гэрлэн бөмбөлөг нэгийг зурах.
3. Гэрлэн бөмбөлөг аль эрт таны дээр тогтож байгаагаар төсөөлөх. Толгой доторхи бүхий л тавгүйтэлт, сэтгэл зовоолтууд гэрлэнд уусаж байгаа үзэгдлийг төсөөлөх. Магнайнаас эхлэн тайвширч сэтгэл сайхан болж ирнэ. Амаа нээгээд “Тайван байна. Тайван байна. Тайван байна.” гэж хэлнэ.
4. Гэрлэн бөмбөлөг нүүрлүү бууж ирнэ. Зүүн хацарнаас тайвшран сэтгэл сайхан болно. Баруун хацарнаас тайвшран сэтгэл сайхан болно. Амаа нээн “Тайван байна. Тайван байна. Тайван байна.” гэж хэлнэ.
5. Гэрлэн бөмбөлөг эрүү - хүзүү - цээж - гэдэс - гуя - шилбэ - хөлийн ул - хөлийн хуруу болон гарлуу

удаанаар бууж ирж байгаа үзэгдлийг төсөөлөх. Биеийн хэсэг бүр дулаацан тавирч байгаагаар төсөөлнө. Амаа нээн “Тайван байна. Тайван байна. Тайван байна.” гэж хэлнэ.

6. Баруун хөл ба зүүн хөл тавиран амарч байгаа үзэгдлийг төсөөлөх. Баруун гар ба зүүн гар тавиран амарч байгаа үзэгдлийг төсөөлөх. Бүх бие дулаацан тайвширч байгаагаар төсөөлнө. Тэгээд амаа нээн “Тайван байна. Тайван байна. Тайван байна.” гэж хэлнэ.
7. Сэтгэл доторхи кино эхэлнэ.

Сүцлийнх нь цахилгаан шатны арга.

1. Хамгийн эвтэйхэн байдлаар суух эсвэл хэвтээд нүдээ анина.
2. Гэрэлтэй саруулхан цахилгаан шат нэгийг төсөөлөх. Та 10-р давхарт байна. Одоогийн оюун санаа тань шаламгай үйлдэл хийдэг орчин байна.
3. Цахилгаан шатны хаалга онгойлоо. Та дотор нь суулаа. Цахилгаан шат доошилж байна. Тайван дулаахан гэрлээр хүрээлүүлэн доошилж байна.
4. Цахилгаан шат 9-р давхрыг өнгөрөөд 8-р давхарлуу бууж байна. Доошлох тусам дулаан тайван мэдрэмж ихсэнэ. Одоогийн оюун санаанаасаа аажмаар холдоно. Далд ухамсар ойртож байна.
5. 7-р давхрыг өнгөрөөд 6-р давхар, 5-р давхарт бууж байна. Одоогийн оюун санаа аажмаар унтарч байна. Далд ухамсрын ертөнц нээгдэж байна. Далд ухамсрын ертөнц нь хязгааргүй дулаахан амгалан гэрлээр хүрээлэгдсэн байна. Одоо та тал хувь хүртэл нь доошилсон байна. Цаашдаа улам л дулаахан амгалан ертөнцтэй учрах болно.
6. 4-р давхрыг өнгөрөөд 3-р давхар, 2-р давхарлуу бууж байна. Одоогийн оюун санаа бүр унтарсан байна. Та далд ухамсрын гүн рүү бууж байна. Доошлох тусам хамгийн төгс төгөлдөр дулаахан амар амгаланг мэдэрнэ.

7. Цахилгаан шат 1-р давхарт хүрлээ. Та буух бэлтгэлээ хийж байна. Хаалга өөрөө онгойно. Нүдний өмнө үнэхээр төгс дулаахан амар амгалан ертөнц байна. Тэр ертөнцийн яг дунд нь оюун санааны кино театр байна. Хаалгыг нь онгойлгоод орлоо. Дотор нь ганцхан танд зориулсан сандал байна. Суумагц кино эхэлнэ.
8. Кино дууслаа. Баяр хөөр дүүрэн царайтай босно. Хаалга нээн гадагш гарна.
9. Цахилгаан шатанд суугаад дээшилж эхэллээ. 2 давхар, 3 давхар, 4 давхар, 5 давхар, 6 давхар, 7 давхар, 8 давхар, 9 давхар10 давхарт гарч ирлээ. Хаалга дуугаран онгойлоо. Та шал өөр болсон байна. Зөвхөн ялагчдын нүднээс харж болох оч таны нүднээс гэрэлтэнэ. Уруулан дээр чинь 1 сая долларын үнэтэй инээмсэглэл тодорно. Бардам сэтгэл цээж дүүрэн харагдаж байна. Та мөрөөдлөө биелүүлэх бүрэн чадвартай хүн бөгөөд бусад хүмүүст боломжийг нь ухааруулж өгдөг хүн шүү.
10. Хэвтээгээрээ эсвэл суусан чигээрээ өөрчлөгдсөн өөрийнхөө төрхийг харан аз жаргалтай инээмсэглэнэ. Нүдээ нээнэ. Хөнгөхнөөр босно.

Би энэ номондоо бүхэлд нь $R=VD$ -г хэрэгжүүлэх тухай танилцуулж байна. Бас өөрөө ч хэрэгжүүлж үзээд л байж байна. Мэргэжлийн түвшинд *Оюун санааны кино театрын арга* нь мэдээж арай өөр. Тодорхой хэмжээний тэвчээр, зүтгэл шаардана. Үнэхээр тийм амар биш шүү. Гэхдээ тэр хэмжээгээрээ үр дүн өгдөг. “Яг бодит юм шиг байдал” нь бодит байдал ба төсөөллийг ялгаж мэдэрч чадахааргүй байдалд хүргэдэг. Энэ аргыг тогтмол хэрэгжүүлэх юм бол бусдаас өөр илүү дотоод энергитэй хүн болж чадах бат итгэл төрж ирнэ. Нөгөө талаас асар их мөнгө төлөн ийм сургалтанд сууж байгаа хүмүүс амжилт олохоос өөр арга байхгүй гэсэн бодол ч төрдөг. Таныг ч гэсэн хийгээд үзээрэй гэж хэлэх байна. Надтай санал нийлэх болно.

Доктор Максвелл Малц “Сэтгэлийн кино театрын арга” гэж нэрлэж байгаа, доктор Ричард Купер “Сэтгэхүйн киноны арга

Mental Movies Techniques” гэж нэрлэж байгаа мэргэжлийн VD арга нь үргэлжлүүлэн хэрэгжүүлээд л байх юм нэг л мэдэхэд кино өөрөө амилан хөдөлж эхэлдэг гэж байна.

Жишээ нь нэг дор 1 тэрбумыг хийхийг хүсэж мөрөөдөж байгаа хүн энэ аргыг тогтмол хэрэгжүүлэх юм бол нэг л мэдэхэд кинон дундаас 1 тэрбум олох санаа гэнэт гараад ирнэ гэсэн үг. Эсвэл гэр бүлийнхэн юмуу даргатайгаа үл ойлголцол үүсээд байгаа хүн тэдэнтэй сайхан харьцаж байгаа юмуу харьцаагаа сэргээж байгаагаар сэтгэлийн кино байнга үзэх юм бол нэг л мэдэхэд кинон дотроос эсрэг талын чинь хүн төсөөллийн жаазыг эвдэн гэрч ирж өөртэй нь сайн харьцаатай байх аргыг зааж өгөх болно гэсэн үг юм шүү дээ.

Энэ аргыг нээлттэй хэрэгжүүлдэг байсан Жек Никольс ийм зүйлийг байнга мэдэрдэг байсан гэсэн. Тэгээд Сэтгэл доторхи кинонд зааснаар хийснээр ихээхэн амжилтанд хүрсэн юм. “Сэтгэлийн киноны бидэнд зөвлөж байгаа арга нь *гольфийн цохиур сонгох энгийн зүйлээс эхлээд цохилт хийх чухал ажил хцртэл* ялалтанд хүрэх хамгийн зөв зам байх болно.” гэж хэлснийг нэгд нэгэнгүй бодож үзээрэй.

Таныг ч гэсэн ийм хязгаарт хүрч чадсан хүн болоорой гэж чин сэтгэлээсээ хүсье.



2. САЯТНЫ КОКТЕЙЛ ҮДЭШЛЭГ

☛ Саятны үдэшлэг

Амжилтын эх орон гэгдэх АНУ-д амжилтанд хүрэхийг шимтэн улайрагч хүмүүс цуглан “Ирээдүйн саятны коктейл үдэшлэг” гээчийг зохион байгуулдаг юм. Ерөнхийдөө жирийн коктейл үдэшлэгтэй адилхан. Коктейл шимэнгээ нөхөрсгөөр ярилцан хоорондын харьцаагаа өргөжүүлнэ. Зөвхөн нэг онцлог байдаг нь жинхэнээсээ саятан биш боловч үдэшлэгийн туршид өөрийгөө саятан гэж танилцуулан саятан шиг биеэ авч явдаг гэнэ.

Өөрөөр хэлбэл та өөрийгөө тэр үдэшлэгийн оролцогч гэж бодоод үз. Тэгээд та өөрийгөө танилцуулахдаа ингэх ёстой гэсэн үг.

“Сайн байна уу? Би ийм бизнесээр сая доллар хийсэн хэн нэгэн байна.”

Харин хүмүүсийн сэтгэл хөдлөн таниас юм асууцгаана.

“Үнэхээр гайхалтай. Гэхдээ сая доллар жийхэд бэрхшээл саад байсангүй юу?”

Та талархсанаа илэрхийлээд, сая долларын төлөө яаж хичээснээ бэрхшээл учрах үе ямар байсан болон түүнээс гарахын тулд ямар шийдвэр гарган юу хийсэн тухайгаа тайлбарлан ярина.

Таны яриаг сонсож байгаа хүмүүс хүндэтгэлээ илэрхийлэн алга ташиж, дэвтэртээ таны яриаг тэмдэглэн, яриа хураагчаар бичлэг хийнэ. Энэ үед өөр нэг хэсэг хүмүүс асуулт асууна.

“Та тэр мөнгөө юунд зарцуулж байгаа вэ?”

Тэхэд та сая доллараар юу худалдаж авсан, хаана юунд хөрөнгө оруулалт хийсэн, хадгаламжийн дэвтэрт чинь хэд үлдсэн зэргийг тодорхой тайлбарлана. Үгээ хэлж дуусах үед хэн нэгэн хандивын хайрцаг барьсан хүн дөхөж очин “Би ийм буяны байгууллагыг төлөөлөн хандив цуглуулж байгаа

юм. Манай байгууллагад хандив өгөх боломж байна уу?” гэж хэлнэ.

Та халааснаасаа чекийн дэвтрээ гарган 100.000 доллар гэж бичин түүний хандивын хайрцаганд дуртайяа хийнэ. Хүмүүс таны сайн үйлсийг магтан шагшиж алга ташина. Иймэрхүү байдалтайгаар оролцогчид ээлж дараалан хэн хэрхэн сая доллар хийсэн болон яаж хэрэглэж байгаагаа ярин, бусад оролцогчид нь түүнд хариулан тухайн нөхцөл байдлыг дэмжин хөгжөөнө (52).

Энэ яриаг анх сонсоод би “Энэ чинь юун дэмий яриа вэ?” гэж бодсон. Харин Лаура Бет Жонс болон дэлхийд нэртэй мэргэжилтнүүд ийм цуглааны үр дүнд маш их ач холбогдол өгдөг гэдгийг сонсоод бодлоо өөрчилсөн юм.

Боловсон хүчин бэлтгэх талдаа дэлхийд алдаршсан Лаура Бет Жонс нь “Шинэ амьдралаараа ялалт байгуулна *The Path*” зохиолдоо жирийн нэгэн албан хаагч байхдаа эд баялгийг онцгой аргаар зохицуулах тухай заасан лекцэнд суусан өөрийн туршлагын тухай бичсэн байдаг. Илтгэгч оролцогчдод нэг нэг цаас тарааж өгөнгөө олохыг хүсэж байгаа мөнгөний хэмжээг бичихийг хүссэн байна. Лаурад жаахан эвгүй санагдав. Хөрөнгөө хэрхэн зөв захиран зарцуулахыг заах лекцэн дээр мөнгө хийж зөв зохицуулах бодит аргыг заахгүй нэг муу цаас өгөөд олохыг хүсэж байгаа мөнгөнийхөө хэмжээг бич гээд байдаг. Тэгээд зүгээр л суугаад байв. Гэтэл хажуугаар нь өнгөрсөн илтгэгч яагаад юу ч бичихгүй байгааг асуулаа.

“Хэдийг бичихээ мэдэхгүй байна даа.”

“Лаура, энд буруу хариу гэж байхгүй. Тийм болохоор зүгээр л санаандаа орсон тоог бичиж яагаад болохгүй гэж?” гэсэн яриа тэр хоёрын хооронд болов. Ингээд Лаура ямар ч байсан хэцүү байдлаас гарах гэж бага зэрэг сэргэлэнтэхээр шийдэн чангаар ингэж хэллээ.

“Ирэх жил 86.000 доллар хийхийг хүсэж байна.”

Тэгмэгц түүнийг бодвол иймэрхүү лекцэнд оролцож байсан туршлагатай сонсогчид урамшуулан халуунаар алга ташсан байна.

Лаура Бет Жонс 1985 оны сүүлээс 1986 оны эхэн хүртэл яг 5 долоо хоногийн турш тэр лекцэнд оролцсон бөгөөд тэгэх болгондоо хийхийг хүсэж байгаа мөнгөнийхөө хэмжээг бичсэн цаасыг энгэртээ тэврээд явах ёстой байсан юм. Тэгэхэд бусад сонсогчид түүнд хандан “Гайхалтай, та нээрээ 86.000 доллартой болсон байна шүү. Үнэхээр сайн ажилласны хүч шүү дээ. Баяр хүргэе.” гэж хэлдэг байж.

Тэгэхэд Лаура бага зэрэг онгирон биеэ тоосон царайгаар ингэж хариулах ёстой байсан байна.

“Тийм шүү. Гэхдээ санасныг бодоход хялбархан байлаа.”

Тэгээд ярилцаж байгаа хүнийхээ цаасан дээр бичсэн мөнгөний хэмжээг харан хариу урамшуулах үг хэлнэ. Лаура Бет Жонс нь “Ирээдүйн саятны үдэшлэг”-ийн өөр нэг хэлбэрт оролцсон нь энэ юм.

Ингээд юу болсон бол? Лекцэнд оролцож эхлээд сар болоогүй байхдаа ажилгүй болсон ч гэсэн 86.000 доллараас илүү орлого олж чадсан гэсэн. Тэр нь 1985 оны орлогоос нь 3 дахин илүү байсан юм.

☛ Ирээдүйн дүр төрхтэйгээр ОРОЛЦОЖ БАЙГАА ҮДЭШЛЭГ

Илэн далангүй бөөн мөнгө ярьсан ирээдүйн саятны үдэшлэг хэцүү санагдаж байгаа бол “10 жилийн дараах би оролцож байгаа үдэшлэг”-ийг сонирхоод үз гэж зөвлөх байна.

Ийм үдэшлэг ердийнхөөс ялгагдах юм байхгүй. Зөвхөн 10 жилийн дараахь өөрийн мөрөөдлөө биелүүлсэн байгаагаар оролцох ёстой гэсэн онцлогтой.

Жишээлбэл таны мөрөөдөл томоохон компаний захирал болох гэж бодъё. Тэгвэл таны мөрөөдөл биелсэн байгаагийн гэрч болсон зүйлүүд болох сонин сэтгүүл дээр гарсан тантай хийсэн ярилцлагын хайчилбар эсвэл “000 компаний захирал” гэсэн нэрийн хуудас ч юмуу бэлдэн оролцох ёстой гэсэн үг. Бусад үйл ажиллагаа нь ирээдүйн саятны үдэшлэгтэй яг адилхан. Оролцогчид ээлжлэн өөрийн ажил үйлсийн тухай

танилцуулж бусад оролцогчид мөрөөдлөө биелүүлж чадсан нууцынх нь тухай асууж хариулна.

Иймэрхүү үдэшлэг Америкт түгээмэл болдог бөгөөд цагаар ажиллагсдыг ихээр оролцуулдаг юм. Тэд ийм үүрэг гүйцэтгэдэг. Нэртэй дуучин болох мөрөөдөлтэй хүн оролцож байгаа бол тэр хүнийхээ фен гэдгээ илэрхийлж чангаар нэрийг нь хэлж, гарын үсгийг нь аван, папараци мэтээр камер барин эргэлдэнэ. Саятан болох мөрөөдөлтэй хүн бол өөрийнх нь хийж байгаа ажилд хөрөнгө оруулалт хийхийг санал болгож мөнгө хийдэг нууцаасаа зааж өг хэмээн хоргооно. Өөрөөр хэлбэл тэд оролцогчдод хүсэл мөрөөдөл зорилгоо биелүүлж чадсан гэсэн мэдрэмж төрүүлэх үүрэгтэй юм.

Заавал ингэх шаардлага байгаа юу гэсэн бодол төрж болно. Надад ч гэсэн тийм бодол төрж байснаа дээр бичсэн байгаа. Шуудхан хэлэхэд ийм үдэшлэгт оролцоно гэдэг инээдтэй бас хөөрхийлөлтэй санагдаж магадгүй юм. Гэхдээ эерэг талаас нь авч үзэцгээе. Сөрөг үзэл бодол бидний амьдралд огтхон ч нэмэр болохгүй учраас.

Би үдэшлэгийн арга нь $R=VD$ -ийн мөн чанарт хамгийн ойртож очсон арга гэж боддог.

Ганцаараа зөвхөн хувийн бэлтгэл хийж байгаа боксчин, хувийн бэлтгэл ч хийгээд бусадтай хамтарсан бэлтгэл хийж байгаа боксчинг ялах боломж байхгүй. Тэгвэл $R=VD$ ч адилхан гэж бодож байна. Ганцаараа хэрэгжүүлж болно гэхдээ хааяа бусадтай хамтран хийх нь илүү үр дүнтэй байх болно. Магадгүй тийм болохоор нь АНУ-д “үдэшлэгийн VD ”-г өргөн ашигладаг байж болох юм. Дараагийн жишээг Жек Кенфилд, Жаннет Свитцер нарын хамтын бүтээл “Амжилтын учир шалтгаан” хэмээх номноос иш татлаа.

Сюзан Жефферсон нь Нью-Йорк Таймсын бестселлерийн зохиолч болох мөрөөдөлтэй гэрийн эзэгтэй байлаа. Тэгээд $R=VD$ г идэвхийлэн хийсэн ч мөрөөдөл нь биелэхгүй л байжээ. Мэдээж Нью-Йорк Таймсын бестселлерийн зохиолч болно гэдэг энгийн нэг хичээл зүтгэлээр бүтнэ гэж үү! Гэрийн ажлаас бүрмөсөн хөндийрөн 10, 20 жил зүтгэхэд бүтэх эсэх

нь тодорхойгүй мөрөөдөл шүү дээ. Тэгтэл нэг удаа тэрээр “Үдэшлэгийн VD” аргын тухай олж сонсон түүнээс хойш тийм үдэшлэг болохыг л хүлээдэг болжээ. Ингээд 1986 оны нэг өдөр нэгэн нэртэй компаний ивээн тэтгэсэн нэгэн VD үдэшлэг Калифорнийн Лонг бичид байрладаг “Хатан хаан Мари” хэмээх хөлөг онгоцон дээр нээгдэх тухай олж сонсчээ. “1991 оны та оролцох үдэшлэг” нэртэй үдэшлэг байлаа. Тэр үед ганц ч ном бичээгүй байсан боловч өөрийн нэрээр гаргасан жинхэнэ ном шиг 3 ном хийгээд очсон байна. Тэгээд өөрийгөө Нью-Йорк Таймсын бестселлерийн зохиолч хэмээн танилцуулжээ. Оролцогчид түүнд “Мэдэлгүй яахав. Саяхан Опра Уинфригийн шоунд оролцсоныг үзсэн. Үнэхээр сэтгэл хөдөлмөөр ярьж байсан шүү.” гэх зэргээр урмын үг хэлцгээжээ. Зарим нь бүр гарын үсгийг нь авсан байна.

Ингэж тэр мөрөөдлөө биелүүлж чадсан хүн шиг өөрийн төрхийг сэтгэлийнхээ гүнд нүдэндээ харагдтал хадгалан авч гэртээ харьсан байна. Тэр үед Сюзан Жефферсон хуучны Сюзан Жефферсон биш болсон байлаа. Хүсэл мөрөөдлөө биелүүлэхийг зүгээр нэг хүсч байгаа хүн ч биш болсон байлаа. Тэрээр өөрийн мөрөөдөлтэйгээ нэгдэн нэг болсон байсан юм. Мөрөөдөл нь Сюзан Жефферсон болж, Сюзан Жефферсон нь мөрөөдөл болсон байсан юм. Тэгмэгц тэр өдрийн шөнөөс эхлэн амьдралд нь өөрчлөлт орж эхэлжээ. Түүний дотоод ертөнцөөс хүмүүсийн сэтгэлийн чавхдасыг хөндсөн өгүүлбэрүүд урсан гарч эхэлсэн байна. Ингэж тэрээр 17 ном бичин хэвлүүлж эцсийн эцэст Нью-Йорк Таймс бестселлерийн зохиолч болж чадсан юм.

“Хатан хаан Мари” хэмээх хөлөг онгоцон дээр болсон үдэшлэгт зохиолч болох мөрөөдлөөр оролцсон бас нэгэн хүн байсан юм. Тэр Сюзан Жефферсоноос нэг алхам илүү хийн очсон байдаг нь өөрийгөө Нью-Йорк Таймсын бестселлерийн 1-р байранд шалгарсныг мэдээлсэн сонины хайчилбар болон нийтлэл хийгээд авчирсан байсан байна. Тэрээр өөрийн тухай бичсэн сонины хайчилбарыг хүмүүст идэвхтэйгээр үзүүлж хүмүүс түүнд чин сэтгэлээсээ баяр хүргэжээ. Магадгүй та түүний бичсэн номыг уншсан байгаа байх. Түүний нэрийг Жек

Кенфилд гэдэг бөгөөд “Сэтгэл нээсэн 101 яриа”, “Эзэн хичээвэл заяа дэлгэрнэ.” цувралын зохиолч билээ.

Тэрээр хөлөг онгоцон дээрх үдэшлэгт оролцоод хэдэн жил ч бололгүй мөрөөдлөө биелүүлэн, төрөл бүрийн шоу ярилцлаганд оролцогч болсон. Нэг удаа ABCийн “Кэролл энд Мериллин шоу”-нд оролцон 1986 оны VD үдэшлэгт оролцсоноо ингэж ярьсан байдаг юм. “Үнэхээр гайхалтай нь тэр үдэш тэнд оролцсон бүх хүний мөрөөдөлдөө хүрэх өдөр нь хурдсан наашилсан юм.”

Жек Кенфилдийн ярианд сэтгэл хөдөлсөн шоу хөтлөгч Кэролл, Мериллин нар нэвтрүүлэг дуусангуут зөвхөн тэр 2-ын VD пати хийхээр төлөвлөжээ. Тэдний мөрөөдөл хамтарч ном гаргах явдал байлаа. Тэгээд тэр 2 номныхоо загварыг бүтээн VD пати хийсэн байна.

2 жилийн дараа тэр 2-ын мөрөөдөл биелжээ. Тэд Harpercollins хэвлэлийн газраар дамжуулан “Ээжийн гэр” гэдэг ном гаргасан байна. Хамгийн гайхалтай нь тэдний номны хавтасны зураг нь яг загвар номны хавтасны зурагтай адилхан байсан гэнэ. Тэд хавтасыг нь тэгж хийгээрэй гэсэн заавар огт өгөөгүй байхад тийм явдал болсон байжээ.

Энэ явдлаар өдөөгдсөн Мериллин дахин нэг VD пати хийхээр болсон байна. Тэгээд тэрээр 15 настай охиныг хөлслөн түүнд 5 жилийн дараахи түүний охины дүрд тоглох захиалга өгчээ. Үдэшлэг болох өдөр хөлслөгдсөн охин Мериллиний найруулгаар бичсэн зохиолын дагуу үйлдсэн байна. Охин гэнэт түүний өрөө рүү гүйн орж хацар дээр нь үнсээд ингэж хэлнэ. “Ээж ээ, Бүх зүйл сайн байгаа шүү. Би таны санааг зовоох юм хэзээ ч хийхгүй. Муу хүүхдүүдтэй ч нийлдэггүй, архи тамхи амандаа ч хүргэдэггүй. Би таны хүссэнээр сайн хүн болж байгаа шүү. Ээж тантай харьцаандаа үнэхээр сэтгэл хангалуун бас баяртай байдаг шүү. Бид бүгдийг хамтдаа ярилцдаг болохоор муудалцах юм ч гардаггүй. Би үнэхээр аз жаргалтай байна. Нээрээ, ээжээ би явахгүй бол болохгүй нь, Өнөөдөр сургууль дээр үдэшлэгтэй, тэнд Дензел Вашингтоны хүүтэй хамт оролцох ёстой юм. Явчихаад ирье.”

Мериллин бага сургуульд явж байсан охиноо өсвөр насандаа алдах вий хэмээн санаа зовон ийм үдэшлэг зохиосон бөгөөд үнэхээр охин нь ээжийгээ зовоох зүйл огт хийгээгүй байна. Тэдний хоорондын харьцаа гайхалтай байсан гэх ба ахлах сургуульдаа Дензел Вашингтоны хүүтэй нэг ангид сурч янз бүрийн үдэшлэгүүдэд хамт оролцдог байсан гэсэн.

VD үдэшлэгээр АМЖИЛТЫН БАТ ИТГЭЛ ОЛЖ АВ

Боломжгүйг зорилго болгон мөрөөддөг хүмүүсийн нийтлэг тал юу вэ? Бүхий л бие сэтгэлээрээ амжилтанд итгэх бат итгэлтэй байдал. Тийм учраас тэд ямар ч сөрөг шаардлага, ямар ч бүтэлгүйтэлд бууж өгөлгүй мөрөөдлөө чиглэн давшиж чаддаг юм. VD үдэшлэгийн гол утга учир нь амжилтын бат итгэл олж авах явдал.

Хэрвээ та тийм итгэлтэй болж чадах юм бол тийм үр дүнд хүрч чадна гэсэн үг. Гэтэл тийм итгэлтэй болох амархан уу? Цөөн хэдэн хүний хувьд амархан байж магадгүй боловч дийлэнхийн хувьд бараг боломжгүйд тооцогдохоор зүйл. Өөрөөр хэлбэл жирийн хүн амжилтын бат итгэл олж авахад учир шалтгаан хэрэгтэй. VD үдэшлэг тийм шалтгаан болж болох шүү дээ. Таны ойр орчмынхон дотор амжилтыг халуунаар хүсэмжилж байгаа хүн байна уу? Тэгвэл түүнтэйгээ хамтаар VD үдэшлэг төлөвлөөд үз л дээ. Байхгүй байна уу? Тэгвэл интернэтээр амжилттай холбоотой блог-д элсэн орж тэнд оролцогчдод санал болгоод үз. Дэмжигчид гарч ирэх л болно. Үдэшлэгээ төлөвлөөд хийж байх явцад “Ингээд үр гарах болов уу?” гэсэн эргэлзээ төрж болох ч ямар ч байсан дуусгаад гэртээ хариад үз, амжилтын ямар нэгэн бат итгэл бий болсныг мэдрэх л болно. Тэр мэдрэмж удалгүй таныг бүхэлд нь эзэмдэх болно. Таны сэтгэлд өөртөө итгэх итгэлийг суулгаж таны үйл хөдөлгөөнд хүчирхэг хүч нэмэх болно.

Та магадгүй одоо энэ хоёрын нэг л байгаа. Бодит байдлын хүнд хүчирт дарагдан мөрөөдөхөөс айдаг хүн, эсвэл мөрөөдөхийн хувьд мөрөөддөг ч саад тохиолдонгуут найдвараа алдан анхны байдалдаа эргээд ордог хүн.

VD үдэшлэг хийгээд үз. VD үдэшлэгт оролцоод үз. Таны дотоод сэтгэлийн гүнээс гүнд унтаж байсан амжилтын эзэн сэрэх л болно. Бодит байдлын хүнд ачааг сэгсрэн хаях, мөрөөдлийг чиглэн галт шувуу мэт нисэх агуу энергитэй болох болно. Тэгээд ч зогсохгүй хайр найргүй газарт унасан ч VD үдэшлэгээс олж авсан амжилтын мэдрэмжээ санан шинэ хүчтэй болох болно. Унасан яг тэр газраасаа дахин хүчтэйгээр далавчаа дэлгэж нүд гялбуулан гялалзах оршихуй болох болно.

Өнгөрсөн амьдралаа түр эргээд хараарай. Та янз бүрийн хэдэн цуглаанд оролцож байсан бэ? Тоолж барахааргүй олон байх. Гэтэл тэдгээрээс таны амьдралыг өөрчилсэн нь хэд байна? Магадгүй ихэнх нь дэмий ярьсан эсвэл архидсан шоудсан л байгаа байх. Ингэхэд хэдий болтол ийм юманд оролцох вэ? Одоо өөрт тань амжилт авчрах цуглаантай болох болсон юм биш үү?



3. МИНИЙ ЗӨВЛӨГЧ ТОЛСТОЙ

☞ Төсөөллийн ЗӨВЛӨГЧ 1

Жирийн хүмүүс бол аль нэгэн салбарт нь амжилт гаргахад ч хэцүү байдаг байхад шүлэг яруу найраг, хэвлэл нийтлэл, уран зураг, тайзны урлаг, улс төр, боловсрол, шинжлэх ухаан зэрэг 8 салбарт бүтээлээ үлдээсэн нэг үеийн суутан Гёте ингэж хэлсэн байдаг.

“Мөрөөдөж болж байгаа бүхнийг биелцүлж болно.”

Харин бид энэ үгнээс нь түүнийг $R=VD$ хэрэгжүүлэгч байсныг нь мэдэж авна. Тэгээд мөн түүний гайхамшиг ид шид гэмээр эдгээр чадварууд нь $R=VD$ хэрэгжүүлсний үр дүнд бий болсныг ч мэдэж болох юм.

Гётегийн намтраас харах юм бол түүний өвөрмөц VD зуршилын тухай ярианууд гарч ирнэ. Тэрээр үргэлж хэн нэгэнтэй ярилцдаг байсан гэнэ. Бүр хэдэн цагаар шүү (53). Эрхэм суутны харилцан ярилцагч нь хүн төрөлхтөний бүхий л цэцэн мэргэнээр бүрэн зэвсэглэсэн ухаалаг оршихуй байсан бөгөөд түүнд бүтээгчийн онгод оруулан зовлонг нь сонсон зөвлөлгөө өгөгч үүрэг гүйцэтгэдэг байжээ. Мэдээж тэр оршихуй бол Гёте төсөөллөөрөө бүтээсэн нэгэн байсан байна. Тэгээд үнэхээр түүний VD төсөөлөл гайхалтай бодит юм шиг байдаг байсан нь хүмүүс тэдний яриаг сонсоод л тэр зөвлөгчийг ерөнхийд нь төсөөлж чаддаг байсан гэдэг.

Психоанализ судлалын салбартаа Гёте гэж нэрлэж болохоор хүн болох Карл Юн, мөн сэтгэлзүйн эмчилгээний Гёте гэж болохоор Карл Саймонтон ч бас иймэрхүү VD зуршилтай байсан гэнэ. Карл Юнд “Пиллэмүн” гэдэг төсөөллийн зөвлөгч байсан бол Карл Саймонтонд “Хелпер” гэдэг төсөөллийн зөвлөгч байсан гэнэ. Пиллэмүн ба Хелпер хүн төрөлтөнд байхгүй хязгааргүй хүч чадлыг агуулсан хүнээс давсан оршихуй байсан гэдэг. Энэ хоёр эрдэмтэн зав чөлөө гарах бүрдээ сэтгэлийн кино театрtaа орон өөрсдийн бүтээсэн

төсөөллийн зөвлөгчидтэйгөө уулзан хязгааргүй мэргэн ухааныг авч психоаналитик эмчилгээний салбарт шинэ эхлэлийг зөвхөн өөрсдийнхөөрөө амжилттайгаар тавьж чадсан юм. Гёте, Карл Юн, Карл Саймонтон гэсэн энэ гурван суутны хүссэнээрээ хийдэг байсан энэ VD хийх техник нь хамгийн өндөр зэрэглэлийн VD болох хязгаарын VD гэж үзэж болно. Энэ гурвын төсөөллийн зөвлөгч нь өөр юу ч биш таны дотор байгаа далд ухамсар тань юм. Тэд далд ухамсартаа нэр өгөн зөвлөгчөө болгосноор $R=VD$ -г зүгээр нэг хэрэгжүүлэх түвшинг давж $R=VD$ томъёотойгоо нэгдэн нэг болсон байна. Өөрөөр хэлбэл Куосего группийг үндэслэгч Казио Иномуригийн хэлсэн “Агуу амжилтанд хүрэхийн тулд заавал амжилтанд хүрэх ёстой гэсэн хүчирхэг халуун хүсэл эрмэлзэл таны далд ухамсарт чинь нэвтэрч дүүргэн шингэж ёстой.” эсэн түвшинг ч даваад далд ухамсарыг бодит байдал болгон хувиргасан гэсэн үг юм. Энэ гурвын VD чадвар тийм түвшинд хүрсэн болохоор...

Надад байгаа мэдээллээс үзэхэд Гёте ба Карл Юн нь төсөөллийн зөвлөгчийнхөө тухай ярьдаг л байсан болохоос яаж бий болгосон талаар хэлж ярьсан юм байхгүй байгаа. Харин золоор Карл Саймонтоний үлдээсэн тэмдэглэл байна. Нөгөө хоёр ч иймэрхүү арга хэрэглэдэг байсан болов уу гэж бодож байна.

Энэ бол Карл Саймонтоны хэрэглэж байсан арга юм.

1. Сэтгэл оюунаа бүрэн дүүрэн суллаад сэтгэлийн кино театртаа орно.
2. Надад хязгааргүй мэргэн ухаан, чадварыг өгөх нэгнийг тасралтгүйгээр гол дүр болгоно. Энэ шат нь далд ухамсарт хүний хэлбэр дүрс өгөхийн тулд хийх ажиллагаа юм. Үүнийг үргэлжлүүлэн хийгээд байх юм бол нэг л мэдэхэд далд ухамсар хүний биеийг олоод гараад ирнэ.
3. Далд ухамсартаа нэр өгнө. Карл Саймонтон өөрт нь туслагч оршихуй байгаасай гэсэн утгаар “Хелпер Helper” гэж нэрлэсэн байна.
4. Хелпертэй ярилцана.

Нэмж хэлэхэд Карл Юн, Карл Саймонтон нар нь зөвхөн сэтгэлийн кино театртаа нүдээ анин төсөөллийн зөвлөгчидтэйгээ уулздаг байсан бол Гёте зүгээр хаана ч хамаагүй нүдээ харсан чигээрээ уулзаж чаддаг байсан гэдэг. Энэ ялгааг чадварын ялгаа гэж ойлгоход болох аж. Өөрөөр хэлбэл, Юн болон Саймонтон тус бүр нэг л салбарт амжилт гаргасан бол Гёте 8 салбарт суут бүтээлүүдээ үлдээсэн гэдгийг санаарай.

☞ Төсөөллийн ЗӨВЛӨГЧ 2

1910 онд “Шингэн ба хийн физик шинж чанарын тухай судалгаа” гэсэн онолоороо Нобелийн шагнал авсан, Вандервальсийн хүч хэмээн нэрлэгдсэн онолоороо алдаршсан Нидерландийн эрдэмтэн Иоханесс Дидерик Вальс ба их бичгийн хүн Толстой, суут эрдэмтэн Эйнштэйн нар нь нас барсан эрдэмтдийг төсөөллийн зөвлөгчөө болгодог дадал зуршилтай байжээ. Вандервальсийн зөвлөгч нь гүн ухаантан Райтон Иохан байжээ. Тэрээр үйлдвэрт хар ажил хийдэг ч өөрөө бие даан гүн ухааныг судлан 20 насандаа бие даасан гүн ухааны онол бүтээн олонд хүлээн зөвшөөрөгдөж чадсан хүн байжээ. Райтон Иохантай зүйрлэхээргүй ядуу бөгөөд бие даан суралцагч байсан бөгөөд Вандервальс Райтоны намтарыг олж уншмагцаа л түүнийг хүндлэн бишрэх болсон байна. Харамсалтай нь Райтон 27-хон насандаа таалал төгссөн боловч энэ нь Вандервальст хамаагүй байж. Учир нь тэр $R=VD$ -г ашиглан төсөөллийн зөвлөгч бий болгох аргыг мэддэг байсан юм. Ингээд аль эрт нас барсан Райтон Иоханыг мэддэг болмогцоо төсөөллийн тайз бий болгоод түүндээ Райтон Иоханыг урьжээ. Тэгээд түүнтэй хичээнгүйлэн ярилцдаг байсан гэнэ.

“Хэрвээ та байсан бол энэ тохиолдолд юу хийх байсан бэ?”

“Та бол энэ асуудлыг яаж шийдэх вэ?”

“Та энэ судалгааг яаж үргэлжлүүлэх вэ?”

Тэгтэл нэг л өдөр цаадахи нь хариулж эхэлсэн гэдэг. Нас барсан Райтон Иохан шүү. Ингэж Вандервальс Райтон Иоханы зөвлөлгөөний хүчинд хүнд хэцүү бүхнийг даван туулж бүр Нобелийн шагнал авч чадсан гэдэг юм (54).

Толстойн төсөөллийн зөвлөгч нь гүн ухаантан Руссо байсан юм. Тэр бүр Руссогийн хөргийг зурсан зүүлтийг хүзүүндээ зүүж яван бүр илэн далангүй ярилцдаг байсан гэдэг юм. Эйнштэйний төсөөллийн зөвлөгч нь Ньютон, Фарадей, Максвелл нар байсан юм. Толстойн нэгэн адил Эйнштейн ч гэсэн тэр гурвын хөргийг ханандаа өлгөн тэдэнтэй ярилцдаг байсан гэдэг. Тэгээд тэр гуравтай хийдэг яриа түүнд хэр их онгод оруулдаг байсан юм. Нүүх болоход бусад үнэт зүйлсээс илүү тэр гурван зургаа бөөцийлдэг байсан гэнэ.

Нас барсан ч үнэнээсээ хүндлэн хайрладаг алдартнуудаас төсөөллийн зөвлөгчөө сонгон түүнээсээ зөвлөлгөө авдаг арга нь дэлхийн хэмжээний $R=VD$ мэргэжилтнүүдийн нутаг болох Америкт өргөн түгсэн арга юм.

Вашингтон пост-ийн найруулгын редакцийн дарга болох Уотергейтийн хэргийг ил гаргаснаараа алдаршсан Боб Эдвардийн 1996 онд олон нийтэд зарласан илтгэлд нэгэн онцгой агуулга бүхий мэдээлэл орсон байжээ. Тухайн үеийн АНУын ерөнхийлөгчийн эхнэр Хиллари Клинтон ерөнхийлөгчийн зуслангийн байранд нэртэй сэтгэл судлаач Жин Хюстоныг урин тусгай хичээл заалгасан байна.

Хиллари Жин Хюстоноор Рузвельт ерөнхийлөгчийн гэргий Элеонара Рузвельтийг төсөөллийн зөвлөгчөө болгох аргыг заалгасан гэнэ. Нэмж хэлэхэд Хиллари нь Жин Хюстонтой уулзахын өмнөөс эхлээд Элеонара Рузвельтийн зургийг харан төсөөллийн яриа өрнүүлдэг байсан гэнэ. Харин нь тэр нь мэргэжлийн биш байсан болохоор тусгай хичээл заалгажээ.

Дэлхийн хамгийн шилдэг ярилцагч гэгддэг Ларри Кинг ч гэсэн Жин Хюстоноор төсөөллийн зөвлөгчийн аргыг сурсан юм. Ларри Кингийн төсөөллийн зөвлөгч нь радио телевизийн суутан гэгддэг байсан талийгаач Артур Кафре юм. Мөн Ларри Кинг төсөөллийн зөвлөгчтэй болох аргыг сурч байгаа тухай тусгай шууд нэвтрүүлэг хүртэл гарсан билээ. Тэр хичээлийн

ач тус хэр зэрэг байсныг мэдэхгүй ч ямар ч байсан Ларри Кинг нь нас дал гарсан ч гэсэн одоо хүртэл дэлхийн хамгийн шилдэг ярилцлагын шоу хөтлөгч хэмээн нэрээ алдаагүй байгаа билээ (55).

☛ Төсөөллийн ХУРАЛ

Амжилт судлалын салбарын тулгын чулууг тавилцсан Наполеон Хилл нь өөрийгөө дахин төрүүлэх зорилгоор өөрийн туйлын их хүндэлдэг 9 хүнийг шөнө бүр урин төсөөллийн хурал хийдэг байжээ. Тэр 9 хүний дунд аль эрт нас барсан Наполеон болон Линкольн, мөн тэр үед амьд сэрүүн байсан Генри Форд болон Эндрю Карнеги нар орсон байжээ. Ийм байдлаар хийдэг байсан байна.

1. Шөнө унтахын өмнө чимээгүйхэн нүдээ анин сэтгэлийн кино театртаа орно.
2. 9 зөвлөгчөө төсөөллийн ширээ рүү урина. Төсөөллийн зөвлөгч нар нь ширээ тойрон сууцгаана. Өөрөө хурлыг удирдах дарга болно.
3. Зөвлөгч тус бүрд асуулт тавина. Хүн тус бүрд нухацтай бөгөөд тодорхой асуулт тавина.

Наполеон Хилл “Алдахыг хүсэхгүй байгаа миний мөрөөдөл миний амьдрал” гэдэг номондоо ингэж сэтгэлийн үгээ хэлж байна.

“Шөнө бүр төсөөллийн хурлыг хийдэг болсноос хойш хэдхэн сарын дотор гайхалтай зүйлс болж эхэлсэн юм. Төсөөллийн баатрууд маань миний нүдний өмнө бодит болон гараад ирлээ. Үнэхээр амьд ахуйд нь танидаг байсан хүн л мэдэж болохоор 9 хүн тус бүрийн онцлог ааш занг хүртэл мэдэх болсон. Төсөөллийн хурал намайг гэрэл цацарсан адал явдлын замаар удирдсан юм. Өөрөөсөө цнэхээр агуу ихийг шаардаж чадах зориг зүрхийг өгсөн юм.”

Наполеон Хиллийн энэ арга дэндүү бодит байдлаас хол хийсвэр санагдаж байгаа хүнд өөр нэг хүний аргыг “Innodesign-ийг 2009 оны дэлхийн дизайны шилдэг 10 байгууллагын нэгээр шалгарсан” үндэслэгч Ким Ёнг Сэгийн аргыг танилцуулахыг хүсэж байна.

Ким Ёнг Сэ өөрийн энэ аргыг “Зохиомол ярилцлагын өрөө” гэж нэрлэдэг бөгөөд бүтээлээ танилцуулж байгаа өөрөө тэгээд хэрэглэгч, үйлчлүүлэгч, технологич зэрэг хүмүүс оролцоно. Түүний тайлбар маш ойлгомжтой байсан учир яриаг нь тэр чигээр нь энд бичлээ.

“1,2 тэрбумын үнэтэй нэг хувь ноорог” ярилцлагаас нь авлаа.

“Зохиомол ярилцлагын өрөөг хаана ч хэзээ ч хийж болгож болохоор сайн талтай байдаг. Тэнд бүтээгдэхүүнээ тавиад жинхэнэ ярилцлага явагдах болно. Худалдан авахыг хүсэж байгаа компани энэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх техник технологи байгаа эсэхийг асууж болно, хэрвээ энэ аргаар хийх нь хүндрэлтэй эсвэл зардал их гарахаар байгаа бол тэр хэсгийг нь хасахаар шийдвэрлэнэ. Шинэ дизайн бол ийм тийм янз бүрийн талууд нь зөвүй байхаар байгааг хэрэглэгч хэлэх юм бол би түүнийг нь засуулах заавар өгнө.

Хэн нэгэн хариуцлагатай ажилтан зах зээлд гаргахад саад болохоор элементийг олж харан хэлэх юм бол тэр хэсгийг хасах арга хэмжээ авна.

Ийм зүйл байвал зүүр гэсэн санал хэн нэгэн нь хэлэх юм бол мэдээж технологи тэйгоо зөвлөлдөөд түүнийг нь нэмнэ. Нэг нэмэлт хийлээ гээд зардал өндөр гарахаар байвал аль болох багасгах үүднээс бодитойгоор тооцоолохыг хичээнэ.

Ингэж миний толгойн дотор хэрэглэгч болон бусад бүх мэргэжилтнүүд хоорондоо зөрчилдөн тохиролцоонд хүрэн санаа нийлж байж нэг дизайныг бэлэн болгоно. Сэтгэлдээ зохиомол дизайнер ба хэрэглэгч, худалдан авагчийг дуудан суулгаж байгаад төсөөлөн хийдэг энэ хурал нь маш хурдан болдог сайн талтай юм. Хэн ч хөндлөнгөөс оролцох боломжгүй ийм төсөөллөөс таашаалавч бүтээгдэхүүний хамгийн нарийн

ширийнийг хүртэл толгой дотроо бэлэн болгоно. Нүдэнд харагдахгүй газар нүдэнд харагдахгүй үйлчлүүлэгчтэйгээ өөд өдөөсөө харан сууж гэрлийн хурдаар гайхалтай санаа олох хурал хийж байгаа гэсэн үг юм. Тэгээд уг хурал хүссэн хэмжээнд санаанд чинь таартал үргэлжлүүлэн дуусгаад хурдхан цаас харандаа гартаа аван нооргоо хийж эхэлнэ дээ.

Хүмүүсийн "Inno touch" хэмээн нэрлэдэг дизайны онцлог нь ийм аргаар төрдөгт байдаг юм.

Ким Ёнг Сэ маш тодорхой хэлж өгч байна. Дизайны ертөнцийн академийн шагнал гэгддэг IDEA алт, мөнгө, хүрэл медалиуд, АНУ-ын Бизнес WIKI сэтгүүлийн шилдэг дизайнерийн шагналтан, Билл Гейтсийн магтаад байсан IRIVER H 10 загварын эзэн, Silicon Valey-д компаниа нээсэн хамгийн анхны солонгос хүн бөгөөд тэрээр амжилтын нууцыг "Төсөөллийн хурал хийх зуршлаас эхэлсэн." хэмээн.

☛ Төсөөллийн ЗӨВЛӨЛГӨӨГ АВААРАЙ

Та өнөөдрөөс эхлэн оролддоод үзээрэй. Төсөөллийн зөвлөгчтэй ярилцаж эхлэх юмуу төсөөллийн хурлыг хийх гээд оролддоод. Түүхийг бичилцсэн суутнууд болон АНУ-ын экс ерөнхийлөгчийн гэргий, дэлхийд алдартай ярилцлагын шоу хөтлөгч болон дэлхийд нэртэй дизайнерийн хийдэг VD аргыг хэрэгжүүлэх гээд оролддоод үз.

Та өнгөрсөн амьдралаа нэг эргэн хараарай. Та голдуу хэнтэй ярилцдаг вэ? Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөгчтэй ярилцдаг уу? Эсвэл өөрийн урдах замаа ч гүйцэд харахгүй шахуу явдаг хүмүүстэй ярилцаж байна уу?

Та голдуу юуны тухай ярилцдаг вэ? Таны доторхи далд ухамсарыг сэрээн таны хүч чадлыг харуулах таны энэ дэлхийд оруулах хувь нэмрийн тухай ярилцдаг уу? Эсвэл зүгээр тулга тойрсон хов, дэмий яриа юмуу хэн нэгнийг үзэн ядсан юм арьдаг уу? Нэг хатуухан дүгнээд үзээрэй. 10 жил, 20 жилийн дараа ямар ирээдүй хүлээж байгаа бол гэдгийг...

Төсөөллийн зөвлөгчийг ийм аргаар бий болгож болно.

1. Та зөвлөгчөө болгохыг хүсэж байгаа хүнээ сонгоорой. Аль эрт нас барсан хүн, одоо амьд байгаа хүн аль нь ч байсан болно.
2. Зөвлөгчтэйгөө уулзаад яаж мэндлэх, ямар сэдвээр ярилцах, ямар зөвлөлгөө хүсэх зэргээ цаасан дээр тэмдэглэн төсөөллийн кино театрт хэрэглэх зохиол бэлдэх.
3. Тогтмол цаг гарган сэтгэлийн кино театртаа орох. Зөвлөгчөө урих. Тэгээд ярилцах.
4. Төгс төгөлдөр кино болтол нь эх зохиолоо засаж нэмэх ажлыг үргэлж лүүлэн хийх.

Эхэндээ хиймэл санагдаад хэцүү байх болно. Цаг хугацаа өнгөрөхөд гайхмаар зүйлс тохиолдоод ирэх болно. Төсөөлөл дундах зөвлөгч чинь амь орон хөдлөөд эхэлнэ. Тэр туйлын анхааралтайгаар чих тавин таны яриаг сонсоно. Тэгээд танд хамгийн мэргэн цэцэн ухааныг бэлэглэх болно.

Энэ аргыг эрт цагт Гёте нарын зэрэг суутнууд л мэддэг байсан бөгөөд орчин үед Эйнштейн нарын суутнууд хэрэглэж байсан юм. Та аль замыг нь сонгох вэ? Энэ аргыг хэрэглэн нүд гялбуулсан ирээдүйг бүтээх үү? Эсвэл зүгээр л уншаад өнгөрч очигдрийнхөө амьдралаар үргэлжлүүлэн амьдрах уу?



АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. "Developing the leader within you" Жон Максвелл.
2. "Beyond coincidence" Мартин Флимор, Браун Кинг.
3. "Winning 101: devotional" Бен Круз.
4. "Discovering yourself" Орисон Свитт Мардон.
5. "Эсти Лаудер" Эсти Лаудер.
6. "Онассис" Вольтер Шавер.
7. "Стивен Спилберг" Жозефф Макбрайд.
8. "Саягнууд ингэж сэтгэдэг" Марк Фишер, Марк Эллен.
9. "Онассис" Вольтер Шавер.
10. "Зочид буудлын хаан Хилтон" Конрад Хилтон.
11. "Эйнштейн, Пикассо" Артур Миллер.
12. "101 more stories to open the heart and rekindle the spirit" Жек Кенфилд, Марк Виктор Хансен.
13. "Уолт Дисней" Жон Марсеж.
14. "Dare to win" Жек Кенфилд, Марк Хансен.
15. "Хүсэж байгаагаар чинь болно" Дипек Чопра.
16. "Above life's turmoil" Жеймс Аллен.
17. "The Success Principles" Жек Кенфилд, Жаннет Швацер.
18. "Awaken the gliant within" Энтони Робинс.
19. "Mozart's brain and the fighter" Ричард Лестик.
20. "Ялагч шиг сэтгэ" Вольтер Степаулс.
21. "Avtobiography of Andrew Carnegie" Эндрю Карнеги.
22. "Сэтгэ, баяж" Наполеон Хилл.
23. "Эрдэнэсийн газрын зураг" Мочизуки Тошитака.
24. "Rockefeller: anointed with oil" Грант Сигал.
25. "Мөрөөдлийг бодит болгох 128 яриа" Шин Гён И.
26. "Домогт Ли Кай Шин" Хун Ха Сан.
27. "1%-ийн баяжих дүрэм" Сайто Хитори.

Дээврийн өрөөний мөрөөдөл бодит болно

28. “Тархины хувьсгалд суралцах арга” Хукуи Казсикээ.
29. “Би өнөөдөр ч найдварын жантай гоймон хийж байна.”
Нам Сан Хэ.
30. “Dare to win ” Жек Кенфилд, Марк Хансен.
31. “Top vendeur: 1001 trucs...” Ибрахим Элфик.
32. “The New Psychology of Success” Кэролл Дьюк.
33. “Тэгээд ч би баян” Нисида Икиү.
34. “Paul Meyer and Art of Giving” Жон Хакки.
35. “The Success Principles” Жек Кенфилд, Жаннет Швацер.
36. “Эрдэнэсийн газрын зураг” Мочизуки Тошитака.
37. “Олимпийн 6 удаагийн аваргуудын дараа үеийнхэндээ дамжуулж байгаа_Сэтгэл зүйн тусгай дасгалын арга”
Ким Хён Ми.
38. “Саятнууд ингэж сэтгэдэг” Марк Фишер, Марк Эллен.
39. “Эсти Лаудер” Эсти Лаудер.
40. “The Success Principles” Жек Кенфилд, Жаннет Швацер.
41. “Би яагаад ч унахгүй” Ушита Эйчи.
42. “Awaken the gliant within” Энтони Робинс.
43. “Grow Rich with Peace of Mind” Наполеон Хилл.
44. “The Dynamic Law of Prosperity” Кэтрин Фонда.
45. “The Success Principles” Жек Кенфилд, Жаннет Швацер.
46. “(The)new psycho-cybernetics” Максвелл Мальц.
47. “Time Power” Брайн Тресси.
48. “Discovering yourself” Орисон Свитт Мардон.
49. “Write it down, make it happen” Хенриет Энн Клаузер.
50. “The Success Principles” Жек Кенфилд, Жаннет Швацер.
51. “(The) power of focus” Жек Кенфилд.

svizzer.

rtsi.c

Radiotelevisione svizzera

Radiotelevisione svizzera